# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

## (ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ)

*Монгол Улсын Их Хурлын Тамгын газар*

1992 оны 12 сар—1993 оны 1 сар № 1 (10)

### ГАРЧИГ

### I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1. Хууль хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль 1
2. Гаалийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 2
3. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 5
4. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 6
5. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль 7
6. Иргэний байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 8
7. Хууль хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль 9
8. Монгол Улсын татварын ерөнхий хууль 10
9. Монгол Улсын худалдааны албан татварын хууль 21
10. Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль 25
11. Монгол Улсын хүн амын орлогын албан татварын хууль 28
12. Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль 36
13. Монгол Улсын төсвийн тухай хууль 41
14. Монгол Улсын Хүн амын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 53

15. Монгол Улсын 1993 оны улсын [illegible] төсвийн тухай Монгол Улсын хууль 54
16. Татварын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 56
17. Хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 58
18. Гэрээ соёрхон батлах тухай Монгол Улсын хууль 59

## 2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

19. Бүгд Найрамдах Босни-Герцеговина улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх тухай 60
20. Бүгд Найрамдах Хорват Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх тухай 61
21. Бүгд Найрамдах Словени Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх тухай 62
22. Монгол Улсын Татварын ерөнхий хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 63
23. Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай 64
24. Дүүргийн нэрийг өөрчлөх тухай 65
25. Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 65
26. Д. Бямбасүрэнг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай 66
27. Бүгд Найрамдах Словак Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, тус улстай дипломат харилцаа тогтоох тухай 67
28. Бүгд Найрамдах Чех Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, тус улстай дипломат харилцаа тогтоох тухай 68
29. Монгол Улсын Их Хурлын 1993 оны төсвийн тухай 69
30. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 1993 оны төсвийн тухай 69
31. Цалингийн тухай 70
32. Зарим хүнийг албан тушаалд томилох, албанаас чөлөөлөх тухай 71
33. Ч. Ган-Өлзийг Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай 71
34. Шүүгч, прокурорын албан тушаалын цалинг тогтоох тухай 72
35. «Төрөөс мөнгөний бодлогын талаар 1993 онд баримтлах чиглэл»-ийг батлах тухай 75
36. «Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1993 онд хөгжүүлэх үндсэн чиглэл»-ийг батлах тухай 78
37. Цалингийн тухай 81
38. Монголбанкны 1993 оны [illegible] батлах тухай 82

## 3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

39. Д. Ёндонг элчин сайдын үүргээс чөлөөлөх тухай 83
40. Б. Должинцэрэнг элчин сайдаар томилох тухай 83
41. Х. Жүгдэрнамжилд хошууч генерал цол олгох тухай 84
42. Зарлиг, зарлигийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай 84
43. Л. Мөндлөгбаатарыг элчин сайдын үүргээс чөлөөлөх тухай 85
44. Х. Бэхбатыг элчин сайдаар томилох тухай 86
45. Шагнал, одон олгох тухай 86
46. П. Дамбийбазарт Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол олгох тухай 88
47. Зарим хүмүүст Монгол Улсын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай 89
48. Зарим хүмүүсийг одон медалиар шагнах тухай 93
49. Сүхбаатарын одонг эргүүлэн олгох тухай 99

50. Зарим хүнд Монгол Улсын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай 100
51. Зарим хүнд Монгол Улсын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай 100
52. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай 101
53. З. Гэнчигжавыг Сүхбаатарын одонгоор шагнах тухай 102
54. Зарим хүнийг одон медалиар шагнах тухай 103
55. Зарим хүнийг одон медалиар шагнах тухай 105
56. Ч. Батсүхийг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах тухай 106
57. Б. Базаррагчааг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах тухай 106
58. В. Банзрагч, С. Баянцай нарыг Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнах тухай 107
59. Д. Энхжаргалыг Шударга журам медалиар шагнах тухай 107

## 4. НИЙТЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ, ЯРИЛЦЛАГА

60. Г. Цэдэндагва. Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хороо юу эрхэлдэг вэ? 109
61. Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хорооны үндсэн гишүүдийн намтар 111
62. Мэндийн Зэнээ хүнд суртлтан гэж үү? 117
63. Цахиагийн Элбэгдорж алтан хараацай мөн үү? 132
64. Ч. Бавуу. Захидал задлахад 149

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1992 оны 12 дугаар сарын 15-ний өдөр — Улаанбаатар хот

# ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль, Хүн амын орлогын албан татварын хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1990 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталсан БНМАУ-ын Албан татварын хуулийг 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1992 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

# ГААЛИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Гаалийн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 1, 6 дахь дэд хэсэг, 17 дугаар зүйлийн 1, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 27 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 1, 30 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

«1. Монгол Улсын хилээр нэвтрүүлэх бараанд гаалийн татварын тарифын дагуу гаалийн албан татвар ногдуулна. Гаалийн албан татварыг гаалийн үнэлгээг үндэслэн тооцно. Гаалийн үнэлгээний аргачлалыг Засгийн газар батална».

15 дугаар зүйлийн 1, 6 дахь дэд хэсэг:

«1) Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагын дүрмийн санд оруулах технологийн тоног төхөөрөмж;»

«6) тахир дутуу хүмүүст зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, түүнийг үйлдвэрлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, түүхий эд, түүнчлэн тодорхой хаяг, зориулалтаар ирж байгаа хүмүүнлэгийн буюу буцалтгүй тусламж;»

17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«1. Гаалийн албан татвар, импортын барааны худалдааны болон онцгой албан татварыг гаалийн байгууллага хураана.»

26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«1. Гаалийн хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дурдсан хариуцлага хүлээлгэнэ:

1) энэ хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, 3, 4, 7-д заасан зөрчил гаргасан бол 25000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулж, тухайн зөрчилд холбогдох барааг хураан авах бөгөөд хураан авах боломжгүй бол түүний үнийг гаргуулан авна;

2) энэ хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5, 6, 8, 9-д заасан зөрчил гаргасан бол 25000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна;

3) энэ хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10, 11, 12, 14-т заасан зөрчил гаргасан бол 20000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна;

4) энэ хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 13-т заасан зөрчил гаргасан бол хугацаа хожимдуулсан хоног тутамд төлбөл зохих татвар, хураамжийн үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх хэмжээний торгууль ногдуулна.»

27 дугаар зүйл.

«27 *дугаар зүйл.* Тээврийн хэрэгслийг хураах

Барааг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх зорилгоор нуувч болгон ашигласан, эсхүл контрабандын бараа тээвэрлэсэн тээврийн хэрэгслийг хураан авах бөгөөд хураан авах боломжгүй бол түүний үнийг гэм буруутай этгээдээс гаргуулан авна.»

28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

«1. Энэ хуульд заасны дагуу барьцаанд авсан барааг гаалийн байгууллага 2 сар (чанараа түргэн алдах барааг 7 хоног) хадгална. Хэрэв энэ хугацаанд уул барааг буцааж аваагүй, эсхүл гаалийн хяналт шалгалтын явцад илэрсэн барааны эзэмшигч нь тодроогүй бол эдгээр барааг улсын орлого болгоно.»

30 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:

«1. Монгол Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлсэн буюу нэвтрүүлэхээр завдсан нь гэмт хэргийн шинжтэй бол хяналт шалгалт хийсэн гаалийн улсын байцаагч акт үйлдэж хэрэг бүртгэх эрх бүхий гаалийн албан тушаалтанд шилжүүлнэ.

2. Хэрэг бүртгэх эрхийг гаалийн удирдах төв байгууллагын дарга, гаалийн газрын дарга, хилийн болон гүний гаалийн байгууллагын эрхлэгч нар эдэлнэ.»

Хоёр. Гаалийн хуулийн 7 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулж, 2, 3 дахь хэсгийг нэмсүгэй:

«7 *дугаар зүйл.* Гаалийн мэдүүлэг

1. Монгол Улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгслийн эзэмшигч нь гаалийн удирдах төв байгууллагаас ба-

талсан маягтын дагуу гаалийн мэдүүлгийг өөрөө, эсхүл гэрээний үндсэн дээр гаалийн зуучлагчаар төлөөлүүлэн бүрдүүлнэ.

2. Аж ахуйн нэгж нь гаалийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэхийн тулд Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гаалийн удирдах төв байгууллагаас зөвшөөрөл авна.

3. Гаалийн зуучлагч төлөөлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын өмнөөс гаалийн мэдүүлгийг үнэн зөв бүрдүүлж, гаалийн хяналт шалгалтын үед биечлэн байлцах үүрэгтэй.»

Гурав. Гаалийн хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6, 7 дахь хэсгийг нэмсүгэй:

6 дахь хэсэг:

«6. Гаалийн албан татварыг зөвхөн дараахь тохиолдолд буцаан олгож болно:

1) гадаад орны захиалагчийн материалаар Монгол Улсад бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон Монгол Улсын захиалагчийн материалаар гадаад оронд бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор нийлүүлэх;

2) түр хугацаагаар Монгол Улсын хилээр нэвтрүүлэх;

3) импортын барааг аливаа өөрчлөлт оруулахгүй экспортлох.»

7 дахь хэсэг:

«7. Гаалийн албан татварыг буцаан олгох журмыг Засгийн газар тогтооно.»

Дөрөв. Гаалийн хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2 дахь дэд хэсгийг нэгтгэн 1 дэх дэд хэсэг болгож доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

«1) Монгол Улсын хилээр бараа, тээврийн хэрэгслийг хууль бусаар нэвтрүүлсэн буюу нэвтрүүлэхийг завдсан;»

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2 дахь дэд хэсэг нэмсүгэй:

«2) гаалийн хяналт шалгалтад шаардлагатай баримт бичгийг засварласан, эсхүл хуурамчаар бүрдүүлсэн;»

Тав. Гаалийн хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 3, 4 дэх дэд хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН**
**ХУУЛЬ**

1992 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр | Улаанбаатар хот

# ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

«2. Торгуулийн хэмжээг үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөн, гэм буруутай этгээдийн байдлыг харгалзан хоёр мянгаас хоёр зуун тавин мянга хүртэл, энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд таван зуун мянга хүртэл төгрөгөөр тогтооно.»

2. Мөн зүйлийн 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Эрүүгийн хуулийн 227 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

«*227 дугаар зүйл.* Албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийх

1. Албан татвар ногдох их хэмжээний орлого, эд хөрөнгө буюу ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлснээ нуух, тэдгээрийн тоо хэмжээг зориуд бууруулан мэдээлэх, албан татвар төлөхгүй оргон зайлах зэргээр албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр нуусан орлогыг хураан гурван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл нуусан орлогыг хураан хоёр зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2. Энэ үйлдлийг зохион байгуулалттай бүлэг этгээд буюу энэ гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол эд хөрөнгийг хураан буюу хураахгүйгээр нуусан орлогыг хураан таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл нуусан орлогыг хураан таван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.»

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1992 оны 12 дугаар сарын 24-ний өдөр — Улаанбаатар хот

# ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 121-р зүйлийн 8 дахь дэд хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

«8) гаалийн газрын дарга, хилийн болон гүний гаалийн байгууллагын эрхлэгч-гаалийн хууль тогтоомж зөрчсөн гэмт хэргийн талаар;»

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН**
**ХУУЛЬ**

1992 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр | Улаанбаатар хот

## ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 121-р зүйлд дор дурдсан агуулгатай дэд хэсэг нэмсүгэй:

«9) улсын татварын албаны хэрэг бүртгэх нэгжийн албан тушаалтан-татварын хууль тогтоомж зөрчсөн гэмт хэргийн талаар.»

Монгол Улсын Их Хурлын дарга — **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга — **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1992 оны 11 дүгээр
сарын 24-ний өдөр

# ИРГЭНИЙ БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Иргэний байцаан шийтгэх хуулийн 295-р зүйлд доор дурдсан агуулгатай дэд хэсэг нэмсүгэй:

«6) улсын болон орон нутгийн татварын талаархи шаардлага.»

2. Мөн хуулийн 296-р зүйлийн 1 дэх дэд хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Их Хурлын дарга** — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1992 оны 12 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

## ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан 1989 оны 6 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан «БНМАУ-ын Төсвийн эрхийн тухай хууль»-ийг 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын
дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын ерөнхий
нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

# МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### *Нийтлэг үндэслэл*

*1 дүгээр зүйл.* Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын татварын тогтолцоо, албан татвар, хураамж, төлбөрийн нийтлэг зарчим, татвар төлөгчийн эрх, үүрэг, хариуцлага, Улсын татварын алба, татварын байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлж, эдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл.* Татварын хууль тогтоомж

1. Татварын хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын татварын хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

*3 дугаар зүйл.* Татварын тогтолцоо

Монгол Улсын татварын тогтолцоо албан татвар, хураамж, төлбөр (цаашид «татвар» гэх)-өөс бүрдэнэ:

1) хууль тогтоомжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд, тогтоосон хувь, хэмжээгээр ногдуулж, харилцаа төлбөргүйгээр улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг албан татвар гэнэ. Албан татвар шууд болон шууд бус татвараас бүрдэнэ;

2) хууль тогтоомжийн дагуу төрийн зохих байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө тэднээс тухай бүр авч улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг хураамж гэнэ;

3) төрийн өмч (иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц зэрэг) ашигласны төлөө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авч улс, орон нутгийн төсөв, тусгай зориулалтын санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгийг төлбөр гэнэ.

*4 дүгээр зүйл.* Татвар бий болгох, өөрчлөх, хүчингүй болгох, түүний хувь, хэмжээ

1. Татварыг Улсын Их Хурал хуулиар бий болгож, өөрчилж, хүчингүй болгоно.

2. Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно.

*5 дугаар зүйл.* Татвар төлөгч

Хуулийн дагуу татвар ногдох орлого, эд хөрөнгө, тодорхой эрх бүхий, эсхүл эд хөрөнгө эзэмшин ашиглаж байгаа дараахь иргэн, аж ахуйн нэгж, байгууллага татвар төлөгч байна:

1) Монгол Улсын иргэн;

2) тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

3) тус улсын нутаг дэвсгэрт байгаа дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага;

4) тус улсад орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчийн газар.

Энэ зүйлийн 1, 2-д заасан татвар төлөгчийг цаашид «иргэн» гэнэ.

*6 дугаар зүйл.* Татвар төлөгчийг бүртгэх

1. Татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллага татварын албанд бүртгүүлнэ.

2. Татвар төлөгч иргэнийг бүртгэх журмыг тухайн төрлийн татварын хуулиар тогтооно.

*7 дугаар зүйл.* Татвар ногдох зүйл

Татвар ногдох зүйлд орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ, тодорхой эрх, газар, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц хамаарна.

*8 дугаар зүйл.* Татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх хэлбэр

Хууль тогтоомжийн дагуу татвар төлөгчид дараахь хэлбэрээр татварын хөнгөлөлт үзүүлэх буюу түүнийг татвараас чөлөөлнө:

1) ногдуулсан татварыг хорогдуулах;

2) татварын хувь, хэмжээг бууруулах;

3) татвар төлөгчийг дэмжих, үйл ажиллагааг нь урамшуулах зорилгоор тодорхой зориулалт бүхий татварын хөнгөлөлт үзүүлэх;

4) тогтоосон доод хэмжээнд хүрээгүй орлого, эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээг татвараас чөлөөлөх;

5) татвар төлөгчийг татвараас чөлөөлөх;

6) татвар ногдох зүйлийн зохих хэсгийг татвараас чөлөөлөх;

7) хуульд тогтоомжид заасан бусад хөнгөлөлт.

*9 дүгээр зүйл.* Татвар төлөх журам

1. Татварыг татварын тайлан буюу орлого, татвар тодорхойлох хуудсаар, эсхүл суутгал хийх замаар ногдуулж, төлбөрийг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр гүйцэтгэнэ. Энд заасанаас өөрөөр татвар ногдуулж төлөх журмыг тухайн төрлийн татварын хуулиар тогтооно.

2. Татвар төлөх хугацааг тухайн төрлийн татварын хуулиар тогтооно. Татвар төлөх, тайлагнах эцсийн хугацаа адил байна. Хэрэв энэ хугацаа долоо хоног бүрийн амралт, нийтээр амрах баярын өдөртэй давхцвал түүний өмнөх ажлын өдөр татварыг төлж тайлагнана.

3. Тогтоосон хугацаанд төлөөгүй татвар болон нөхөн ногдуулсан татвар, хүү, торгуулийг аж ахуйн нэгж, байгууллагаас үл маргах журмаар гаргуулна.

4. Аж ахуйн нэгж, байгууллага шууд бус татварыг өөрийн үйл ажиллагааны үр дүн гарахыг хүлээлгүй төлнө.

5. Аж ахуйн нэгж, байгууллагын татвар ногдуулах, төлөх тооцоог татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч гүйцэтгэнэ.

*10 дугаар зүйл.* Татвар төлөгчийн үүрэг

Татвар төлөгч дараах үүрэг хүлээнэ:

1) татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;

2) татвар ногдуулах, төлөхтэй холбогдсон тооцоо, мэдээ тайланг тогтоосон хугацаанд татварын албанд ирүүлэх;

3) бэлэн шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, санхүү аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл гаргах;

4) татварын хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд уг зөрчлийг арилгах талаар татварын албанаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

5) татварын албаны шалгалтын актыг зөвшөөрч байгаа бол гарын үсэг зурах. Актыг зөвшөөрөхгүй тохиолдолд тайлбараа бичгээр гаргаж өгнө;

6) аж ахуйн нэгж, байгууллага бусдад олгосон хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод ногдох татварыг үнэн зөв суутган тооцож, тогтоосон хугацаанд төсөвт төлөх;

7) хууль тогтоомжид заасан бусад үүрэг

*11 дүгээр зүйл.* Татвар төлөх үүрэг дуусгавар болох, бусдад шилжих

1. Татвар төлөх үүрэг дараах тохиолдолд дуусгавар болно:
1) тухайн төрлийн татварын хууль хүчингүй болсон;
2) тухайн төрлийн татвар төлж дууссан;
3) татвар төлөгч тухайн төрлийн татвараас бүрэн чөлөөлөгдсөн;
4) татвар төлөгч иргэн нас барсан, нас барсанд тооцогдсон;
5) аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан.

2. Нас барсан, нас барсанд тооцогдсон иргэний татвар төлөх үүрэг, түүнтэй холбогдох эрх өв залгамжлагчид нь шилжинэ.

3. Өөрчлөн байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагын дутуу төлсөн татвар төлөх үүрэг, түүнтэй холбогдох эрх өөрчлөн байгуулагдсаны дүнд бий болсон аж ахуйн нэгж, байгууллагад шилжинэ. Аж ахуйн нэгж, байгууллага тусгаарласан, салсан тохиолдолд татвар ногдох зүйлтэй хувь тэнцүүлэн татвар төлөх үүрэг тэдгээрт шилжинэ.

4. Аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан бол татан буулгах комисс, дампуурсан бол нэхэмжлэгчийн зөвлөл төлөөгүй буюу дутуу төлсөн татварыг уг аж ахуйн нэгж, байгууллагын эд хөрөнгөөс хуульд заасан журмаар гаргуулж төлнө.

*12 дугаар зүйл.* Татвар төлөгчийн эрх

Татвар төлөгч дараах эрх эдэлнэ:

1) татварын хууль тогтоомжид заасан нөхцөлд хөнгөлөлт эдлэх, татвараас чөлөөлөгдөх. Хэд хэдэн нөхцөлөөр хөнгөлөлт эдлэх тохиолдолд аль нэгийг нь сонгон авах;

2) татварын албаны шалгалтын акттай танилцах;

3) татвар ногдуулалт, төлөлт, шалгалтын дүнгийн талаар тайлбар авах буюу өгөх;

4) татварын албаны буруугаар учирсан хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлэх;

5) илүү төлсөн татварыг эгүүлэн авах буюу суутган тооцуулах;

6) татварын алба, түүний байцаагчийн хууль бус ажиллагаа, шийдвэрийн талаархи гомдлоо эрх бүхий төрийн захиргааны байгууллага болон шүүхэд хууль тогтоомжийн дагуу гаргах. Шүүхэд гомдол гаргасан нь татвар төлөхийг зогсоох үндэслэл болохгүй. Харин уг гомдлыг хянаж байгаа шүүхийн шийдвэрээр татвар төлөхийг түр зогсоож болно.

*13 дугаар зүйл.* Татвар төлөгчид хүлээлгэх хариуцлага

1. Татварын хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татвар төлөгчид дараахь хариуцлага хүлээлгэнэ:

1) татвар ногдох орлогоо нуусан буюу санаатайгаар бууруулсан бол нуусан буюу бууруулсан орлоготой тэнцэх хэмжээний торгууль ногдуулах;

2) орлогоос бусад татвар ногдох зүйлийг нуусан буюу түүний тоо, хэмжээг санаатайгаар бууруулсан бол ногдох татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлсэн татвартай тэнцэх хэмжээний торгууль ногдуулах;

3) татвар ногдох зүйлийн тоо, хэмжээг болгоомжгүйгээр бууруулсан бол ногдох татварыг нөхөн төлүүлж, саатуулсан хоног тутам нөхөн төлүүлсэн татварын дүнгээс бодож 1 хувийн хүү ногдуулах. Хүүгийн хэмжээ нь төлбөл зохих татварын 50 хувиас хэтэрч болохгүй;

4) татварыг хугацаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй татварын дүнгээс бодож хоног тутам 0,3 хувийн хүү ногдуулах;

5) хууль тогтоомжид заасан бусад хариуцлага.

2. Татвар, торгууль төлөх хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байна.

*14 дүгээр зүйл.* Банк, санхүүгийн байгууллагын үүрэг, хариуцлага

1. Банк, санхүүгийн байгууллага татварын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үзүүлэлтийг Сангийн сайд, Монголбанкны ерөнхийлөгчийн тогтоосон журмын дагуу татварын албанд гаргаж өгнө.

2. Банкны байгууллага харилцагч аж ахуйн нэгж, байгууллагын татварын төлбөрийг 12 цагийн дотор гүйцэтгэх бөгөөд тухайн төлбөр хүлээн авсан банкны байгууллага тэр өдөрт багтаан төсвийн харилцах дансанд оруулах үүрэгтэй. Хэрэв уг үүргийг биелүүлээгүй бол татварын алба гүйцэтгээгүй татварын төлбөрийн дүнгээс бодож хоног тутам 0,5 хувийн хүү ногдуулна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### *Монгол Улсын татварын ангилал*

*15 дугаар зүйл.* Монгол Улсын татварын бүрэлдэхүүн

Монгол Улсын татвар нь улсын болон орон нутгийн татвараас бүрдэнэ:

1) Улсын Их Хурал, Засгийн газраас хувь, хэмжээг нь тогтоосон бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт нийтээр үйлчлэх татварыг улсын татвар гэнэ;

2) аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хувь, хэмжээг нь тогтоосон бөгөөд тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх татварыг орон нутгийн татвар гэнэ.

*16 дугаар зүйл.* Улсын татвар

Улсын татварт дараах татвар хамаарна:

1) хүн амын орлогын албан татвар;
2) аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар;
3) гаалийн албан татвар;
4) худалдааны албан татвар;
5) онцгой албан татвар;
6) автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;
7) өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар;
8) үл хөдлөх хөрөнгийн албан татвар;
9) бууны албан татвар;
10) хотын албан татвар;
11) нийтийг хамарсан спорт, уран сайхны арга хэмжээний орлогын албан татвар;
12) хот, суурин газрын нохойны албан татвар;
13) улсын тэмдэгтийн хураамж;
14) замын хураамж;
15) ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж;
16) ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;
17) газрын төлбөр;
18) ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр;
19) ус ашигласны төлбөр.

*17 дугаар зүйл.* Орон нутгийн татвар

Орон нутгийн татварт дараах татвар хамаарна:

1) ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж;
2) байгальтай харьцахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж;
3) захын нэг удаагийн хураамж;
4) түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр;
5) рашаан ашигласны төлбөр.

*18 дугаар зүйл.* Татварын хувь, хэмжээг тогтоох

1. Улсын Их Хурал энэ хуулийн 16 дугаар зүйлийн 1—13-т заасан татварын хувь, хэмжээг тогтооно.

2. Засгийн газар энэ хуулийн 16 дугаар зүйлийн 14—19-д заасан татварын хувь, хэмжээг тогтоож болно.

3. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан татварын хувь, хэмжээг тогтоож болно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### *Монгол Улсын татварын алба*

*19 дүгээр зүйл.* Монгол Улсын татварын албаны тогтолцоо

1. Монгол Улсын татварын алба нь Улсын татварын ерөнхий газар, аймаг, нийслэлийн татварын алба, сум, дүүргийн татварын алба (байцаагч)-аас бүрдэнэ.

2. Улсын татварын ерөнхий газар, аймаг, нийслэлийн татварын албанд бүтцэд татварын хэрэг бүртгэх нэгж байна.

3. Улсын татварын ерөнхий газар, аймаг, нийслэлийн татварын албаны дэргэд татвар төлөгч, татварын албаны хооронд үүссэн маргааныг шийдвэрлэх бүрэн эрх бүхий Татварын маргаан таслах зөвлөл ажиллана. Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар тогтооно.

*20 дугаар зүйл.* Улсын татварын албаны дүрэм

Улсын татварын албаны дүрмийг Засгийн газар батална.

*21 дүгээр зүйл.* Татварын албаны удирдлага

Улсын татварын ерөнхий газар Сангийн сайдын, орон нутгийн татварын алба тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын удирдлага дор ажиллана. Улсын татварын ерөнхий газар бүх шатны татварын албаны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

*22 дугаар зүйл.* Улсын татварын алба, татварын байцаагчийн үйл ажиллагааны зарчим

Улсын татварын алба, татварын байцаагч үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, татвар төлөгчийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэх зарчим баримтална.

*23 дугаар зүйл.* Улсын татварын албаны чиг үүрэг

Улсын татварын алба дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1) татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

2) татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлал гаргах, сургалт, сурталчилгаа явуулах;

3) улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.

*24 дүгээр зүйл.* Улсын татварын алба, татварын байцаагчийн бүрэн эрх

1. Улсын татварын алба дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) татвар төлөгчид татварын хууль тогтоомжийн дагуу хөнгөлөлт үзүүлэх, түүнийг татвараас чөлөөлөх;

2) анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгүйгээс орлого, зарлагыг нь тодорхойлох боломжгүй татвар төлөгчид түүнтэй адилтгах үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа татвар төлөгчийн жишгээр татвар ногдуулах;

3) татварын хэрэг бүртгэх ажиллагааг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу явуулах;

4) тогтоосон хугацаанд татвар төлөөгүй аж ахуйн нэгж, байгууллагын банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг татвараа төлж дуустал түр зогсоох;

5) татварын албаны тогтоосон актад заасан татвар, хүү, торгуулийг хугацаанд нь төлөөгүй бол татвар, хүү, торгуультай тэнцэх хэмжээний хөрөнгийг зохих журмын дагуу хурааж, дуудлагын худалдаагаар борлуулж төсөвт шилжүүлэх;

6) илүү төлсөн татварыг дараачийн сар, улирал, жилийн татварт суутган тооцох буюу татвар төлөгч хүсвэл тооцоо хийснээс хойш 30 хоногийн дотор эгүүлэн олгох;

7) татвар, хүү, торгууль төлөхөөс зайлсхийсэн, татварын мэдээ, тайланг хугацаанд нь ирүүлээгүй, татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй татвар төлөгчид хуульд заасан хариуцлага хүлээлгэх;

8) доод шатны албаны гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл хүчингүй болгох буюу өөрчлөх;

9) татварын хяналт хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, бусад холбогдох баримт бичгийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

10) шүүхэд дараахь асуудлаар нэхэмжлэл буюу гомдол гаргах;

а) татварын хууль тогтоомж ноцтой зөрчсөн татвар төлөгчийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг зогсоох;

б) татвар төлөгч хууль тогтоомжоор хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж олсон орлого, ашигласан тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд, материалыг хураах;

в) татвар төлөгч хуулиар тогтоомжоор хоригдоогүй үйлдвэрлэл, үйлчилгээг зохих зөвшөөрөлгүй явуулж олсон орлогыг хураах;

г) татвар төлөгч хуурамч буюу хүчингүй гэрээ хэлцэл, хууль бус үйлдлээр олсон орлогыг хураах;

д) албан үүргээ гүйцэтгэхэд нь татварын байцаагчид саад учруулсан, эсэргүүцэл үзүүлсэн, түүнийг үйл ажиллагаатай нь холбогдуулан мөрдөн хавчсан, амь бие, эрүүл мэндэд нь хохирол учруулсан гэм буруутай этгээдэд зохих шийтгэл хүлээлгэх;

е) хууль тогтоомжид заасан бусад асуудал.

2. Татварын байцаагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) татвар ногдуулах, төлөхтэй холбогдсон данс бүртгэл, тайлан тэнцэл, төсөл болон санхүүгийн бусад баримтад хяналт шалгалт хийх, тайлбар, лавлагаа гаргуулж авах;

2) татварын хяналт шалгалтад шаардагдах мэдээлэл, баримтын хуулбарыг татвар төлөгчийн харилцагч аж ахуйн нэгж, банк, санхүүгийн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

3) татвар ногдох зүйл нуусныг гэрчлэх баримтыг татвар төлөгчөөс түр хугацаагаар хураан авах, хуулбарлах;

4) орлого олох зориулалтаар ашиглаж байгаа, эсхүл татвар ногдох зүйлийг хадгалж буй татвар төлөгчийн байр, агуулах (түүний байршлаас үл хамааран)-д нэвтрэн орж шалгалт, тооллого, ажлын зураг авалт, шаардлагатай бол үздэг хийх;

5) аж ахуйн нэгж, байгууллага бусдад олгосон хөдөлмөрийн хөлс, шилжүүлсэн орлогод татвар ногдуулж, суутган авч төсөвт төлөөгүй бол түүнийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөс нэхэн төлүүлэх;

6) татвар төлөгчид энэ хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээлгэх;

7) татвар төлөгчийн хөрөнгө, үйлдвэрлэл, худалдааны нууцыг хадгалах;

8) албан үүргээ гүйцэтгэх явцад иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа нь илэрвэл холбогдох байгууллагад мэдэгдэх.

*25 дугаар зүйл.* Татварын байцаагчид хүлээлгэх хариуцлага

Татвар төлөгчийн хууль бус үйл ажиллагааг нуух, татварын орлогыг хувийн зорилгод ашиглах, хээл хахууль авах, мэдээллийн нууц задруулах, эрхээ хэтрүүлэх зэргээр албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй татварын байцаагчид хууль тогтоом

акид даасан сахилгын, захиргааны, эд хөрөнгийн болон эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

*26 дугаар зүйл.* Татварын байцаагчийн мэргэжлийн зэрэг, зэргийн нэмэгдэл, шагнал

1. Татварын байцаагч мэргэжлийн зэрэгтэй байх бөгөөд түүнд зэргийн нэмэгдэл олгоно.

2. Татварын байцаагчид ажлын үр дүнгийн шагнал олгоно.

3. Татварын байцаагчид сар тутам олгох мэргэжлийн зэргийн нэмэгдэл, ажлын үр дүнгийн шагналын нийлбэр нь түүний албан тушаалын сарын үндсэн цалингийн хэмжээнээс хэтрэхгүй байна.

4. Мэргэжлийн зэрэг тогтоох, зэргийн нэмэгдэл, ажлын үр дүнгийн шагнал олгох журмыг Засгийн газар тогтооно.

*27 дугаар зүйл.* Улсын татварын албаны төсөв

Улсын татварын албаны үйл ажиллагааны зардлыг төсвөөс санхүүжүүлэх бөгөөд татварын алба бие даасан төсөвтэй байж болно.

*28 дугаар зүйл.* Татварын байцаагчийн эрхийн баталгаа

1. Татварын байцаагч албан үүргээ гүйцэтгэж байх үедээ бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй. Бие хамгаалах тусгай хэрэгслийн жагсаалт, түүнийг хэрэглэх журмыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрснөөр Улсын татварын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тогтооно.

2. Татварын байцаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон, бусдын гэмтээр амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний ар гэрт доорхи буцаалтгүй тусламж, үндсэн цалингийн зөрүүг олгоно:

1) хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны турш албан тушаалын үндсэн цалингийн зөрүү;

2) тахир дутуу болсон тохиолдолд тахир дутуугийн тэтгэвэр, албан тушаалын үндсэн цалингийн зөрүү;

3) амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь хохирогчийн 3 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцаалтгүй тусламж.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан буцаалтгүй тусламж, үндсэн цалингийн зөрүүг төсвөөс олгож, уг хөрөнгийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### *Бусад зүйл*

*29 дүгээр зүйл.* Төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтны үүрэг

Төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтан татварын хяналтын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, хуульд заасны дагуу хамтран ажиллах үүрэгтэй.

*30 дугаар зүйл.* Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хууль 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

| | |
|---|---|
| **Монгол Улсын Их Хурлын дарга** | Н. БАГАБАНДИ |
| **Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга** | Н. РИНЧИНДОРЖ |

1992 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

# МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДААНЫ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬ

*1 дүгээр зүйл.* Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын импортоор авсан бараа, түүнчлэн борлуулсан эх орны үйлдвэрийн болон импортын бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд худалдааны албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл.* Худалдааны албан татварын хууль тогтоомж

Худалдааны албан татварын хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*3 дугаар зүйл.* Худалдааны албан татвар төлөгч, түүнийг бүртгэх

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа импортлож байгаа, түүнчлэн бараа үйлдвэрлэж, ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага худалдааны албан татвар төлөгч байна.

2. Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуульд заасны дагуу худалдааны албан татвар төлөгч болох тухай татварын албаны мэдэгдэл авснаас хойш 30 хоногийн дотор Улсын татварын албанд бүртгүүлнэ.

*4 дүгээр зүйл.* Худалдааны албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээ

Худалдааны албан татварыг дараах бараа, ажил, үйлчилгээнд ногдуулна:

1) импортын бүх төрлийн бараа;

2) худалдааны албан татвар төлөгчөөр бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын борлуулсан эх орны үйлдвэрийн болон импортын бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ.

*5 дугаар зүйл.* Худалдааны албан татвар тооцох үнэлгээ

1. Импортын барааны худалдааны албан татвар тооцох үнэлгээг уг барааны гаалийн үнэ, тээврийн зардал, даатгалын хураамжийг тухайн үед мөрдөж байгаа Монголбанкнаас тогтоосон валютын ханшаар төгрөгт шилжүүлсэн дүн дээр гаалийн болон онцгой албан татварыг нэмж тодорхойлно.

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний [illegible] албан татвар

тооцох үнэлгээг борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнэ, тарифыг үндэслэн тодорхойлно.

3. Үйл ажиллагааны хамаарал бүхий аж ахуйн нэгж, байгууллагад үндэслэлгүй доогуур үнэ, тарифаар бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн бол худалдааны албан татвар тооцох үнэлгээг хамааралгүй аж ахуйн нэгж, байгууллагад борлуулсан үнэ, тарифаар тодорхойлно.

4. Импортлосон болон борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний үнэ, тариф тодорхойгүй бол худалдааны албан татвар тооцох үнэлгээг Сангийн сайдын тогтоосон журмын дагуу импортын барааны тухайд гаалийн байгууллага, бусад бараа, ажил, үйлчилгээний тухайд Улсын татварын алба тодорхойлно.

*6 дугаар зүйл.* Худалдааны албан татварын хувь, хэмжээ

1. Худалдааны албан татварыг бараа, ажил, үйлчилгээний үнэлгээний 10 хувиар ногдуулна.

2. Экспортод гаргасан барааны худалдааны албан татварын хувь, хэмжээ тэг («0»)-тэй тэнцэнэ.

*7 дугаар зүйл.* Худалдааны албан татварт хамруулах, түүнээс чөлөөлөх, хөнгөлөх

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа үйлдвэрлэж, ажил гүйцэтгэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг худалдааны албан татварт ээлж дараалалтай хамруулах, албан татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

2. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн хөдөө аж ахуй, ой, ан агнуурын анхдагч түүхий эд болон гадаадын дипломат төлөөлөгчийн газарт худалдсан барааг худалдааны албан татвараас чөлөөлнө.

*8 дугаар зүйл.* Худалдааны албан татвар ногдуулах

1. Худалдааны албан татварыг дараахь хугацаанд ногдуулна:

1) импортын бараа Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирсэн тухай бүрд;

2) бараа борлуулсан болон түрээслэсэн тухай бүрд;

3) ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн буюу эдгээрийн үнэ, хөлсийг нэхэмжилсэн тухай бүрд.

2. Татвар ногдох барааг бусдад үнэ төлбөргүй шилжүүлсэн, өөрийн хэрэгцээнд ашигласан нь уг барааг худалдааны албан татвараас чөлөөлөх үндэслэл болохгүй.

3. Үйлдвэрлэлийг бүрмөсөн зогсоосон тохиолдолд үлдэгдэл бараанд зохих журмын дагуу худалдааны албан татвар ногдуулна.

*9 дүгээр зүйл.* Төсөвт төлөх худалдааны албан татварын хэмжээг тодорхойлох

1. Албан татвар төлөгчийн тухайн сард борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд ногдсон худалдааны албан татварын нийт дүнгээс мөн хугацаанд худалдааны албан татвар төлөгч бусад этгээдээс худалдаж авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд төлсөн худалдааны албан татварыг хасч уг албан татвар төлөгчээс төсөвт төлөх худалдааны албан татварын хэмжээг тодорхойлно. Ийнхүү төсөвт төлөх худалдааны албан татварын хэмжээг тодорхойлоход худалдааны албан татвар төлөгч бусад этгээдийн нэхэмжлэл, холбогдох баримтыг үндэслэнэ.

2. Худалдааны албан татвар төлөгчөөс бусад этгээдийн нэхэмжлэлийн дагуу тэдэнд төлсөн худалдааны албан татвар нь тухайн албан татвар төлөгчийн импортлосон болон борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд ногдсон худалдааны албан татвараас их байвал уг давсан хэсгийг дараагийн сард төсөвт төлөх худалдааны албан татвараас суутган тооцно.

*10 дугаар зүйл.* Худалдааны албан татвар төсөвт төлөх, тайлагнах

1. Бараа импортлогч худалдааны албан татварыг уг бараанд ногдуулсан гаалийн албан татварын хамт тогтоосон хугацаанд гаалийн байгууллагын дансанд оруулна. Гаалийн байгууллага худалдааны албан татварыг 3 хоногийн дотор улсын төсөвт шилжүүлнэ.

2. Аж ахуйн нэгж, байгууллага тухайн сард импортлосон болон борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд ногдсон худалдааны албан татварыг дараа сарын 5-ны дотор төсөвт төлнө. Татварын алба их хэмжээний худалдааны албан татвар бүхий аж ахуйн нэгж, байгууллагад албан татварыг урьдчилан төлөх хугацаа тогтоон өгч болно.

*11 дүгээр зүйл.* Худалдааны албан татвар төлөгчийн эрх, үүрэг

Худалдааны албан татвар төлөгч дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

1) Татварын ерөнхий хуульд заасан татвар төлөгчийн эрх, үүрэг;

2) борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд ногдох худалдааны албан татварыг бусдаас нэхэмжлэн авах;

3) худалдаж авсан бараа, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээнд ногдох худалдааны албан татварыг төлөх.

*12 дугаар зүйл.* Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хууль 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

1992 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

# МОНГОЛ УЛСЫН АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬ

*1 дүгээр зүйл.* Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл.* Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль тогтоомж

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар (цаашид «албан татвар» гэх)-ын хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*3 дугаар зүйл.* Албан татвар төлөгч

Монгол Улсын нутаг дэвсгэрт автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага албан татвар төлөгч байна.

*4 дүгээр зүйл.* Албан татвар ногдох автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл

Дараах автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд албан татвар ногдуулна:

1) бүх төрлийн ачааны автомашин;

2) автобус;

3) суудлын автомашин;

4) мотоцикл;

5) тусгай зориулалтын автомашин (кран, засвар үйлчилгээний болон лабораторийн зориулалтаар тоноглогдсон гэх мэт);

6) трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл.

*5 дугаар зүйл.* Албан татварын хэмжээ

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг дараах хэмжээгээр ногдуулна:

| № Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл | Жилд ногдуулах албан татвар (төгрөгөөр) | |
|---|---|---|
| | Уланбаатар, Дархан, Эрдэнэт, Чойр хот | Бусад газарт |
| 1. 2 дугуйтай мотоцикл | 200 | 180 |
| 2. 3 дугуйтай мотоцикл | 300 | 280 |
| 3. Суудлын автомашин | 3000 | 2000 |
| 4. Микроавтобус (15 хүртэл суудалтай) | 7000 | 6000 |
| 5. Автобус | 10500 | 9000 |
| 6. Ачааны автомашин: | | |
| 1) 1 хүртэл тн-ын даацтай | 5000 | 4000 |
| 2) 1—2 тн-ын даацтай | 7000 | 6000 |
| 3) 2—3 тн-ын даацтай | 9000 | 8000 |
| 4) 3—4 тн-ын даацтай | 11000 | 10000 |
| 5) 4—5 тн-ын даацтай | 13000 | 12000 |
| 6) 5—8 тн-ын даацтай | 16000 | 15000 |
| 7) 8—10 тн-ын даацтай | 18000 | 17000 |
| 8) 10 тн-оос дээш даацтай | 20000 | 19000 |
| 7. Тусгай зориулалтын автомашин | 16000 | 15000 |
| 8. Трактор, өөрөө явагч бусад хэрэгсэл | 7500 | 6000 |
| 9. Бага оврын трактор | 4000 | 2000 |

Тайлбар: Ачааны автомашины даацын хэмжээ 2 ангилалд давхацсан тохиолдолд өмнөх ангиллаар тооцож албан татвар ногдуулна.

*6 дугаар зүйл.* Албан татвар ногдуулах

1. Улсын бүртгэлд байгаа автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд тэдгээрийг ашиглаж байгаа эсэхийг үл харгалзан албан татвар ногдуулна.

2. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл ашиглалтаас хасагдсан тохиолдолд улсын бүртгэлээс хассан тухай албан ёсны баримт бичгийг үндэслэн түүнд ногдох албан татварыг дараа улирлаас эхлэн зогсооно. Албан татвар төлөгч автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд түүний албан татвар төлөх үүрэг дараа улирлаас эхлэн дуусгавар болно.

*7 дугаар зүйл.* Албан татвар төлөх хугацаа

1. Иргэн нь автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор төсөвт төлнө.

2. Аж ахуйн нэгж, байгууллага автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор багтаан төсөвт төлж дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор тайланг татварын албанд ирүүлнэ.

3. Татвар төлөгч дараа улирал, жилийн албан татварыг урьдчилан төлж болно.

*8 дугаар зүйл.* Албан татварын талаар замын хөдөлгөөн зохицуулах байгууллагын үйл ажиллагаа

1. Замын хөдөлгөөн зохицуулах байгууллага нь албан татвар төлөгчийн автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэл, шилжилт, хөдөлгөөний мэдээг тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд улирал тутам гаргаж өгнө.

2. Замын хөдөлгөөн зохицуулах байгууллага автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг хураах ажилд туслалцаа үзүүлнэ. Татварын алба, замын хөдөлгөөн зохицуулах байгууллага автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн техникийн үзлэг, татварын хяналт шалгалтын ажлыг хамтатган зохион байгуулна.

*9 дүгээр зүйл.* Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хууль 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

1992 оны 12 дугаар сарын 1-ний өдөр

Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬ

*1 дүгээр зүйл.* Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүн амын орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл.* Хүн амын орлогын албан татварын хууль тогтоомж

Хүн амын орлогын албан татвар (цаашид «албан татвар» гэх)-ын хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль болон түүнтэй нийцүүлэн гарсан энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*3 дугаар зүйл.* Албан татвар төлөгч

1. Монгол Улсын иргэн, Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн (энэ хуульд цаашид «иргэн» гэх) албан татвар төлөгч байна.

2. Монгол Улсад 183 хоног, түүнээс дээш хугацаагаар оршин сууж байгаа иргэнийг Монгол Улсад байнга оршин суугч гэнэ.

3. Байнга оршин суугч нь Монгол Улсад болон гадаадад олсон орлогоосоо албан татвар төлнө.

4. Түр оршин суугч нь Монгол Улсад олсон орлогоосоо албан татвар төлнө.

5. Албан татвар ногдох орлого бүхий иргэн Улсын татварын албанд бүртгүүлж бүртгэлийн дугаар авна.

*4 дүгээр зүйл.* Албан татвар ногдох орлого

1. Албан татвар төлөгчийн жилд олсон дараахь орлогод албан татвар ногдоно:

1) цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого:

а) аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр үндсэн ажлын хэлбэрээр ажиллаж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлого;

б) үндсэн ажлын гадуур бусад аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, адилтгах бусад орлого;

в) тэтгэвэр, тэтгэврийн нэмэгдэл, тэтгэмж;

2) хувиараа хөдөлмөр эрхэлсний орлого;

3) хувиараа аж ахуй эрхэлсний орлого;

4) хувиараа бусад үйл ажиллагаа явуулснаас олсон орлого;

5) хөрөнгийн хөдлөл, эрхийн орлого;

а) хувьцаа, үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого, адилтгах бусад орлого;

б) хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого, хадгаламжийн хүүгийн орлого, хөрөнгө түрээслүүлсний орлого, адилтгах бусад орлого;

6) зохиогчийн шагнал;

7) энэ хуульд албан татвараас чөлөөлөхөөр зааснаас бусад орлого.

2. Албан татвар ногдох орлогод мөнгөн (үндэсний болон гадаад валютаар) болон биет хэлбэрээр олсон зүйлийг оруулна. Биет хэлбэрээр олсон зүйлийг тухайн орон нутаг (аймаг, нийслэл)-ийн биржийн дундаж үнээр үнэлнэ. Гадаад валютаар олсон орлогыг тооцохдоо уг валютыг банкинд худалдах буюу Монголбанкнаас тогтоосон ханшаар төгрөгт шилжүүлнэ.

5 дугаар зүйл. Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

Албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:

1) цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг:

а) энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн «а»-д заасан орлогын нийлбэр дүнгээр;

б) энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн «б»-д заасан орлогын нийлбэр дүнгээр;

в) тэтгэвэр, тэтгэврийн нэмэгдэл, тэтгэмжийн дүнгээр;

г) гэр бүлээрээ буюу хамтарч гэрээгээр ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн нөхцөлд иргэн тус бүрт ногдох орлогыг өөрсдийнх нь тодорхойлсноор, хэрэв ингэж тодорхойлох боломжгүй бол гэрээнд оролцогчдын тоонд хуваасан дүнгээр;

2) хувиараа хөдөлмөр, аж ахуй эрхлэгчийн орлогыг:

а) хувиараа хөдөлмөр эрхэлж олсон нийт орлогоос баримтаар нотлогдож буй зардал (түүхий эд, үндсэн болон туслах материал, хагас боловсруулсан зүйл, уур, ус, эрчим хүч, түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэл, сав, баглаа боодлын зардал, түрээсийн болон банкны зээлийн хүүгийн төлбөр, худалдан авсан барааны үнэ, нийгмийн даатгалын шимтгэл)-ийг хассан зөрүүгээр;

б) хувиараа аж ахуй эрхэлж олсон нийт орлогоос баримтаар нотлогдож буй зардал (түүхий эд, үндсэн болон туслах материал, хагас боловсруулсан зүйл, уур, ус, эрчим хүч, түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэл, сав, баглаа боодлын зардал, түрээсийн болон банкны зээлийн хүүгийн төлбөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, томилолтын зардал, нийг-

мийн даатгалын болон үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэл), авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, онцгой албан татвар, байгалийн нөөц ашигласны төлбөрийг хассан зөрүүгээр.

Гэр бүлийн гишүүдэд олгосон хөдөлмөрийн хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хэмжээтэй хувь тэнцүүлэн бодож зардалд тооцно.

Хувиараа хөдөлмөр, аж ахуй эрхлэгч нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээнээс өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулсан байвал тэдгээрийг зардалд тооцохгүй;

в) гахай, шувуу, туулай, зөгийн аж ахуй, тэдгээртэй адилтгах аж ахуй, газар тариалангийн болон хувиараа бусад үйлдвэрлэл эрхлэгч нь албан татвар ногдуулах орлогоо энэ зүйлийн 2-ын «а», «б»-д заасны дагуу өөрөө тодорхойлно.

Албан татвар ногдуулах орлогоо тодорхойлоогүй буюу тодорхойлох боломжгүй бол албан татвар ногдуулах орлогыг байгаль, цаг уур, зах зээлийн нөхцөл, ижил үйлдвэрлэгчтэй харьцуулсан жишгээр татварын алба тодорхойлно;

3) хөрөнгийн хөдлөх, эрхийн орлогыг:

а) үл хөдлөх хөрөнгө худалдсаны орлогоос уг хөрөнгийг худалдан авсан буюу барьж байгуулсан зардлыг хассан зөрүүгээр;

б) хувьцаа худалдсаны орлогоос уг хувьцааг анх худалдан авсан үнийг хассан зөрүүгээр;

в) хөрөнгө түрээслүүлснээс олсон орлогын дүнгээр;

г) хувьцааны ногдол ашгийн дүнгээр, хувь хүртэгчид ногдсон орлогын дүнгээр, хадгаламжийн хүүгийн дүнгээр.

*6 дугаар зүйл.* Хувийн мал бүхий иргэний албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

Хувийн мал бүхий иргэний мал аж ахуйн бүтээгдэхүүний албан татвар ногдох орлогыг малын толгойн тоог бодод шилжүүлэн тодорхойлно.

Үхэр, адуу, тэмээ тус бүрийг нэг бод, 7 хонь буюу 9 ямаа тус бүрийг нэг бод (зөвхөн татварын тооцоонд) гэж тооцно.

*7 дугаар зүйл.* Албан татварын хэмжээ

1. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1—4, 7-д заасан болон хөрөнгө түрээслүүлсний орлогын дүнгээс дараахь хэмжээгээр албан татвар ногдуулна:

| Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ (төгрөгөөр) | Албан татварын хувь, хэмжээ |
|---|---|
| 24001—48000 | 2 хувь |
| 48001—96000 | 480 төгрөг дээр 48000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 5 хувийг нэмнэ |
| 96001—192000 | 2880 төгрөг дээр 96000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 15 хувийг нэмнэ |
| 192001—384000 | 17280 төгрөг дээр 192000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 27 хувийг нэмнэ |
| 384001—768000 | 69120 төгрөг дээр 384000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 40 хувийг нэмнэ |
| 768001, түүнээс дээш | 222720 төгрөг дээр 768000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 45 хувийг нэмнэ |

2. Засгийн газрын үнийн өсөлтийн түвшинг харгалзан албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээг өөрчилнө.

3. Гадаадад ажиллаж байгаа Монгол Улсын иргэний төрөөс авдаг цалин, хөдөлмөрийн хөлсний орлогод ногдуулах албан татварын хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоож байна.*

4. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчид татвар ногдуулах журмыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтоож байна.*

*6 дугаар зүйл.* Албан татварын тусгайлан ногдуулах хувь, хэмжээ

Албан татварыг дараах хувь, хэмжээгээр тусгайлан ногдуулна:

1. шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл зохиогч болон патентын эрх эзэмшигч, шинэ бүтээл, оновчтой санал

---

* 1992 оны 12 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Монгол Улсын Хүн амын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу өөрчлөн найруулав.

гаргагч, загвар зохион бүтээгч нарын 60000 хүртэл төгрөгийн шагналд 3 хувиар, 60001, түүнээс дээш төгрөгийн шагналд 5 хувиар;

2) хувьцааг биржээр борлуулсан бол албан татвар ногдуулах орлогод 10 хувиар, биржээр дамжуулаагүй бол үнийн дүнгийн 2 хувиар;

3) үл хөдлөх хөрөнгө борлуулсны албан татвар ногдуулах орлогод эзэмшигчийн ашигласан хугацааг харгалзан:

а) 2 хүртэл жил ашигласан бол 40 хувиар;

б) 2—5 жил ашигласан бол 30 хувиар;

в) 5-аас дээш жил ашигласан бол 20 хувиар;

4) хувьцааны ногдол ашиг, хувь хүртээгчийн орлогод 15 хувиар, хадгаламжийн хүүгийн орлогод 15 хувиар;

5) хувийн мал бүхий иргэний мал аж ахуйн бүтээгдэхүүний орлогын албан татварыг энэ хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон бод тутамд 50 төгрөгөөр. Тухайн жилд орлогын албан татвар ногдуулах малын тоог өмнөх жилд тоологдсон малын тоогоор авна.

*9 дүгээр зүйл.* Албан татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх

1. Албан татвар төлөгчийн дараах орлогыг албан татвараас чөлөөлнө:

1) 24000 хүртэл төгрөгийн цалин, хөдөлмөрийн хөлс, тэтгэвэр, тэтгэмж, адилтгах бусад орлого;

2) Тэтгэмжийн хуулийн дагуу олгож байгаа хөдөлмөрийн чадвар түр алдсан, жирэмсний болон амаржсаны тэтгэмжээс бусад тэтгэмж, Алдарт эхийн I, II зэргийн одонгийн шагнал, ардын хувьсгалын партизаны тэтгэвэр, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайнд оролцогчдод олгох тэтгэмж, хүүхдийн тэтгэлгийн орлого;

3) Монгол Улсын төрийн болон нэрэмжит шагнал, Засгийн газрын шагнал, Монгол Улсын Ардын буюу гавьяат цолтны шагнал, нэмэлтийн шагнал, донор болон эхийн сүүнд олгож буй нөхөн олговор, томилолтоор ажиллах хугацааны зам хоногийн зардалд олгосон мөнгө;

4) даатгалын нөхцөлөөр олгож буй тэтгэвэр, хохирол нөхсөний орлого;

5) Засгийн газрын зээллэгийн нөхөн олговор болон хүүгийн орлого;

6) хууль тогтоомжийн дагуу олгож байгаа хөдөлмөр хамгаалалын хувцас, сүүний үнэ, дүрэмт хувцас, тэдгээртэй адилтгах бусад хангамжийн өртөг, гамшгийн аюул, онцгой нөхцөл байдлын улмаас Засгийн газар болон орон нутгийн байгууллага

лага, улаан загалмайн нийгэмлэг, гадаад орнуудаас иргэдэд үзүүлж буй тусламж;

7) мал бүхий иргэний өрхийн ам бүл тутамд 2 бод.

Тухайн жилд албан татвар ногдуулсан мал нь байгалийн гамшиг, гэнэтийн аюул, гоц халдварт өвчний улмаас хорогдсон бол зохих баримтыг үндэслэн албан татвараас чөлөөлнө;

8) хувиараа хөдөлмөр, аж ахуй эрхлэж тахир дутуу иргэдэд зориулсан эмнэлэг эрхтэн, гажиг засах техник хэрэгсэл үйлдвэрлэснээс олсон орлого.

2. Хувиараа хөдөлмөр, аж ахуй эрхлэгчийн орлогод ногдуулсан албан татварыг дараахь хувиар хөнгөлнө:

1) үр тариа, гурил, талхыг үйлдвэрлэж эрхэлж олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар;

2) харалгүй, дүлий болон тулах эрхтний гэмтлийн улмаас тахир дутуугийн I, II зэрэг тогтоолгосон ногдд ажилладаг хувиарла эрхлэх аж ахуйн албан татварыг нийт ажиллагсдад тахир дутуу иргэдийн эзлэх хувиар.

*10 дугаар зүйл.* Албан татвар ногдуулах төсөвт төлөх

1. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 6, 7-д заасан орлогод 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 1-д тодорхойлсон хувь, хэмжээгээр албан татвар ногдуулна.

Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1-ийн «б»-д заасан орлогод 3,5 хувиар суутгал хийнэ.

Аж ахуйн нэгж, байгууллага нь иргэнд орлого шилжүүлэх бүрдээ албан татварыг тооцон суутган авч энэ тухай орлого, татвар тодорхойлох хуудсанд тэмдэглэл хийж баталгаажуулна.

Хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг иргэний цалин, хөдөлмөрийн хөлсөнд ногдох албан татварыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага сарын эцэст суутган авна. Уг албан татварын тооцоог жилээр хийж энэ тухай орлого, татвар тодорхойлох хуудсанд нь тэмдэглэл хийж баталгаажуулна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс суутган авсан албан татварыг дараа сарын 10-ны дотор төсөвт шилжүүлнэ.

Тухайн сард суутган авсан албан татварын хэмжээ нь 1000 төгрөгөөс бага байвал суутган авсан уг албан татварыг дараа сарын албан татвартай нэгтгэн төсөвт шилжүүлнэ.

2. Арилжааны банк иргэний хадгаламжид хүү бодох бүрдээ энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4-т заасан хувиар албан татвар ногдуулан суутган авч, төсөвт шилжүүлнэ.

3. Аж ахуйн нэгж, байгууллага иргэнд хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлогыг тавьж олгохдоо энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4-т заасан хувиар албан татвар ногдуулан суутган авч, төсөвт шилжүүлнэ.

4. Биржийн байгууллага биржээр дамжуулан борлуулсан хувьцааны орлогод энэ хуулийн 8 дугаар зүйлийн 2-т заасан хувиар албан татвар ногдуулан суутган авч, төсөвт шилжүүлнэ.

5. Албан татвар төлөгч дараахь орлогод албан татвар өөрөө ногдуулан доор дурдсан хугацаанд төлнө:

1) хувийн мал бүхий иргэн албан татвараа 7 дугаар сарын 25, 12 дугаар сарын 15-ны дотор хоёр хуваан төсөвт төлнө. Татварын алба албан татвар төлөгчтэй тохиролцсоноор албан татварыг урьдчилан төлүүлж болно.

Хувийн мал бүхий иргэн албан татвараа мал сүрэг нь байнга байгаа нутаг дэвсгэрийн орон нутгийн төсөвт төлнө.

2) үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татварыг борлуулснаас хойш 10 хоногийн дотор;

3) хөрөнгө түрээслүүлсний орлогод ногдох албан татварыг дараа улирлын эхний сарын 15-ны дотор;

4) биржээр дамжуулаагүй борлуулсан хувьцааны орлогод ногдох албан татварыг нийхүү борлуулснаас хойш 10 хоногийн дотор;

5) хувиараа хөдөлмөр, аж ахуй эрхлэгч өөрийн орлогод энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь, хэмжээгээр улирал тутам албан татвар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны дотор төсөвт төлнө;

6) иргэн нэгээс дээш аж ахуйн нэгж, байгууллагаас энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 3, 4, 7, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 5-ын «б»-д заасан хөрөнгө түрээслүүлсний орлого авдаг бол орлого, татвар тодорхойлох хуудсаар уг орлогод албан татвар ногдуулан төлж, албан татварын жилийн тооцоо хийнэ.

*11 дүгээр зүйл.* Албан татварын тайлан тушаах хугацаа

1. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1, 2, 4, мөн зүйлийн 5 дахь хэсгийн 3, 5-д заасан албан татварын тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор, мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан албан татварын тайланг дараа оны 4 дүгээр сарын 10-ны дотор татварын албанд тушаана.

2. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 2, 4-т заасан албан татварын тайланг албан татвар төлснөөс хойш 15 хоногийн дотор татварын албанд тушаана.

3. Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан орлого, татвар тодорхойлох хуудсыг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор татварын албанд тушаана.

4. Орлого, татварын тайлан болон орлого, татвар тодорхойлох хуудасны маягт, түүнийг хэрэглэх зааврыг Сангийн сайд батална.

*12 дугаар зүйл.* Хууль хүчин төгөлдөр болох

1. Энэ хууль 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4-т заасан хадгаламжийн хүүгийн орлогод албан татвар ногдуулах тухай заалтыг 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

1992 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬ

*1 дүгээр зүйл.* Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь аж ахуйн нэгж, байгууллагын орлогод албан татвар ногдуулах, уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл.* Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хууль тогтоомж

Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар (цаашид «албан татвар» гэх)-ын хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*3 дугаар зүйл.* Албан татвар төлөгч

Дараахь аж ахуйн нэгж, байгууллага албан татвар төлөгч байна:

1) Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа өмчийн бүх төрөлд хамаарагдах компани, хоршоо, гадаадын дагнасан болон хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж;

2) Монгол Улсад орлого олж байгаа гадаадын аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газар;

3) арилжааны банк, зээл, даатгалын болон тэдгээртэй адилтгах бусад байгууллага.

*4 дүгээр зүйл.* Албан татвар ногдох орлогын төрөл

1. Албан татвар төлөгчийн дараахь орлогод албан татвар ногдоно:

1) үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний орлого;

2) арилжааны банкны болон зээлийн үйл ажиллагааны орлого;

3) даатгалын үйл ажиллагааны орлого;

4) бирж, брокерын үйл ажиллагааны орлого;

5) барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны орлого;

6) үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого;

7) хөдлөх хөрөнгө борлуулсны орлого;

8) хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого;

9) хувьцааны ногдол ашиг, хувь хүртэгчийн орлого;

10) зээллэгийн хүүгийн орлого;

11) хөрөнгө түрээслүүлсний орлого;

12) зуучлах үйл ажиллагааны орлого;

13) хонжворт сугалаа, таавар, тоглоомын орлого;

14) банкнаас авсан хүүгийн орлого;

15) албан татвар ногдох бусад орлого.

2. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2-т заасан албан татвар төлөгчийн зөвхөн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж олсон орлогод албан татвар ногдуулна.

3. Гадаад валютаар олсон орлогыг төгрөгт шилжүүлэхдээ уг валютыг банкинд худалдах буюу Монголбанкнаас тогтоосон ханшийг үндэслэнэ.

4. Даатгалын үйл ажиллагааг даатгалын хураамжийн орлогоос санхүүжүүлэх хувь, хэмжээг Засгийн газар тогтооно.

5 дугаар зүйл. Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

1. Албан татвар төлөгчийн албан татвар ногдуулах орлогыг дараах байдлаар тодорхойлно:

1) энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1—5, 10—12-д заасан орлогоос баримтаар нотлогдож буй шууд зардал, үүнд цалин, хөдөлмөрийн хөлс, бүх төрлийн материалын зардал (түүхий эд, үндсэн болон туслах материал, хагас боловсруулсан зүйл, уур, ус, эрчим хүч, түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэл, сав, баглаа боодлын зардал), нийгмийн даатгалын болон үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэл, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, түрээсийн төлбөр, зээлийн хүү, хөрөнгө оруулагчдаас тогтоосон хэмжээний захиргааны зардал, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, газар, байгалийн нөөц ашигласны төлбөрийг хассан зөрүүгээр. Төсөвт төлсөн онцгой албан татварыг албан татвар ногдуулах орлогоос хасч тооцно.

Хөрөнгө оруулалт болон засварын зардал, даатгалын хураамж, бараа, материалын хэвийн хорогдол, хугацаа хэтэрсэн зээлийн хүү, бүх төрлийн торгууль болон албан татвар төлөгчийн буруугаас бусдад учруулсан хохирлыг нөхсөн төлбөрийг албан татвар ногдуулах орлогоос хасахгүй.

Хуулиар тогтоосон, заавал даатгах ухсан даатгалын хураамжийг албан татвар ногдуулах орлогоос хасна.

Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэл байгуулах хувь, хэмжээг Засгийн газар тогтооно;

2) энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6—7-д заасан орлогоос уг хөрөнгийн үлдэгдэл өртгийг хассан зөрүүгээр;

3) бусдаас худалдаж авсан хувьцааг [illegible] борлуулсны орлогоос уг хувьцааг худалдаж авсан үнийг [illegible] зөрүүгээр;

4) энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 13-д заасан орлогоос уг орлогыг олохтой холбогдон гарсан баримтаар нотлогдох зардал, хонжворт олгосон хөрөнгийг хассан зөрүүгээр;

5) энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9, 14-д заасан орлогын нийт дүнгээр.

2. Бараа харилцан солилцсон, бараа, хөдлөх ба үл хөдлөх хөрөнгийг зах зээлийн үнээс доогуур үнээр борлуулсан, ажил, үйлчилгээний үнэ, тарифыг багасгаж хэрэглэсэн тохиолдолд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо зах зээлийн тухайн үеийн үнэ, тарифыг үндэслэнэ.

*6 дугаар зүйл.* Албан татварын хувь, хэмжээ

1. Албан татвар ногдуулах жилийн орлогод дараахь хувь, хэмжээгээр албан татвар ногдуулна:

1) энэ хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан болон хөдлөх хөрөнгө борлуулсны орлогод:

| Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ (төгрөгөөр) | Албан татварын хувь, хэмжээ |
|---|---|
| 0—300000 | 15 хувь |
| 300001—700000 | 45000 төгрөг дээр 300000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 25 хувийг нэмнэ |
| 700001—1500000 | 145000 төгрөг дээр 700000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 35 хувийг нэмнэ |
| 1500001-ээс дээш | 425000 төгрөг дээр 1500000 төгрөгөөс дээш орлогын дүнгийн 45 хувийг нэмнэ |

Албан татварын нийт хэмжээ албан татвар ногдуулах орлогын 40 хувиас хэтэрч болохгүй;

2) хувьцааны ногдол ашиг, хүү, хүртээгчийн орлогод 15 хувиар:

Төр нь өмчдөө ногдох ашиг болон хувьцааны ногдол ашгийг бүрэн буюу хэсэгчлэн төсөвт дайчлах эрхтэй. Энэ хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр тухай бүр Улсын Их Хурал тогтооно;

3) биржээр борлуулсан хувьцааны албан татвар ногдуулах орлогод 10 хувиар, биржээр дамжуулаагүй борлуулсан хувьцааны борлуулалтын орлогод 2 хувиар;

4) бүх төрлийн төлбөрт тоглоом, видео болон аудио хуурцаг, түүний бичлэгийн хэлсний үйлчилгээ, видео үзвэр болон компьютер сургалт, таавар орлогод 60 хувиар;

5) үл хөдлөх хөрөнгө борлуулсны албан татвар ногдуулах орлогод түүнийг эзэмшигчийн ашигласан хугацааг харгалзан:

а) 2 хүртэл жил ашигласан бол 40 хувиар;
б) 2—5 жил хүртэл ашигласан бол 30 хувиар;
в) 5-аас дээш жил ашигласан бол 20 хувиар;
6) банкнаас авсан хүүгийн орлогод 10 хувиар.

2. Гадаадын дагнасан болон хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн орлогод Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуульд заасан хувь, хэмжээгээр албан татвар ногдуулна.

*7 дугаар зүйл.* Албан татвараас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх

1. Албан татвар төлөгчийн дараах орлогыг албан татвараас чөлөөлнө:

1) тахир дутуу хүмүүст зориулсан хиймэл эрхтэн, техник, гэмтэл засах хэрэгсэл үйлдвэрлэж олсон орлого;

2) Засгийн газрын зээлдэгчийн хүүгийн орлого.

2. Албан татварын хэмжээг дараах хувиар хөнгөлнө:

1) хүнсний анхдагч түүхий эд-мах, сүү, үр тариа, түүнчлэн гурилын үйлдвэрлэлээс олсон орлогод ногдох албан татварыг 50 хувиар;

2) хүүхдийн тэжээлийн үйлдвэрлэлийг дагнан эрхэлж байгаа бол албан татварыг 100 хувиар;

3) хараагүй, дүлий болон тулах эрхтний гэмтлийн улмаас тахир дутуугийн I, II зэрэг тогтоолгосон хүмүүс ажилладаг аж ахуйн нэгжийн албан татварыг нийт ажиллагсдад тахир дутуу хүмүүсийн эзлэх хувиар;

4) нийт ажиллагсдын 70-аас доошгүй хувийг 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй хүмүүс эзэлдэг ахмадуудын санаачилгаар үүсгэн байгуулсан аж ахуйн нэгжийн албан татварыг 50 хувиар.

3. Шинэ технологи нэвтрүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүнийг дотоодод үйлдвэрлэх, бүс нутгийн хөгжлийг жигдрүүлэх зэрэг чиглэлээр Засгийн газраас тусгай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх иж бүрэн арга хэмжээнд хамрагдах аж

ахуйн нөгөөд албан татварын хөнгөлөлт үзүүлэх буюу түүнийг албан татвараас чөлөөлнө. Энэ тохиолдолд албан татвараас чөлөөлөх буюу албан татварын хөнгөлөлт үзүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тухай бүр шийдвэрлэнэ.

*8 дугаар зүйл.* Албан татвар төлөх, тайлагнах журам

1. Албан татвар төлөгч албан татварын хэмжээг шигтлан бодох бүртгэлийн үлирэл, жилийн тайлан тэнцлийг үндэслэн жилийн эхнээс өссөн дүнгээр өөрөө тодорхойлж төсөвт төлнө.

2. Албан татвар төлөгч тайлангийн жилд төлөх албан татвараа сар, улирлын хуваарийн дагуу сар бүр 25-ны дотор урьдчилан төлж, улирлын албан татварын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор Улсын татварын албанд тушааж, албан татварын эцсийн тооцоо хийнэ.

Жилийн 500000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлоготой албан татвар төлөгч нь албан татвараа дээрх хугацаанд багтаан улиралд нэг удаа төлж болно.

3. Үл хөдлөх хөрөнгө, хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татварыг уг хөрөнгө, хувьцаа, үнэт цаасыг борлуулснаас хойш 10 хоногийн дотор төсөвт төлнө.

*9 дүгээр зүйл.* Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хууль 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын
дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын ерөнхий
нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

1992 оны 12 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

# МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### *Нийтлэг үндэслэл*

*1 дүгээр зүйл.* Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төсвийг зохиох, хянах, батлах, төсвийн орлогыг бүрдүүлэх, төсвийн хөрөнгийг хуваарилах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл.* Төсвийн хууль тогтоомж

Төсвийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*3 дугаар зүйл.* Төсөв, түүний бүрэлдэхүүн

1. Төр чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэр бий болгох зорилгоор тухайн төсвийн жилд өөрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж зарцуулах мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын төлөвлөгөөг Монгол Улсын төсөв гэнэ.

2. Монгол Улсын төсөв нь улсын төвлөрсөн төсөв, орон нутгийн төсвөөс бүрдэнэ:

1) Засгийн газрын мэдэлд төвлөрүүлэн зарцуулах Монгол Улсын төсвийн хэсгийг улсын төвлөрсөн төсөв гэнэ. Засгийн газрын тусгай зориулалтын сан улсын төвлөрсөн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна;

2) аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын мэдэлд төвлөрүүлэн зарцуулах Монгол Улсын төсвийн хэсгийг орон нутгийн төсөв гэнэ. Орон нутгийн төсвийг аймаг, нийслэлийн төсөв, сум, дүүргийн төсөв гэж ангилна.

3. Аймаг, нийслэлийн төсвийн хувьд улсын төвлөрсөн төсөв, сум, дүүргийн төсвийн хувьд аймаг, нийслэлийн төсөв дээд шатны төсөв байна.

*4 дүгээр зүйл.* Төсвийн жил

Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

*5 дугаар зүйл.* Төсвийн захирагч, түүний бүрэн эрх

1. Төсвийн захирагчийг ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, шууд захирагч гэж ангилна:

1) төсвийн хөрөнгийг төвлөрүүлэх, хуваарилан зарцуулах эрх бүхий этгээдийг төсвийн ерөнхийлөн захирагч гэнэ. Улсын

төвлөрсөн төсвийн ерөнхийлөн захирагч нь Засгийн газар, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга байна;

2) харьяа төсөвт байгууллагын төсвийн хөрөнгийг хуваарилан зарцуулах эрх бүхий этгээдийг төсвийн төвлөрүүлэн захирагч гэнэ. Төсвийн ерөнхийлөн захирагч шаардлагатай гэж үзвэл төсөвт байгууллагыг төвлөрүүлэн захирагчтай байхаар тогтоож болно;

3) төсвийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах эрх бүхий этгээдийг төсвийн шууд захирагч гэнэ;

4) Засгийн газар тусгай зориулалтын сангийн төвлөрүүлэн захирагчийг тухай бүрд нь томилно.

2. Төсвийн ерөнхийлөн захирагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) улсын төвлөрсөн төсвийн төслийг Улсын Их Хуралд, орон нутгийн төсвийн төслийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

2) тухайн шатны төсөвтэй харьцах байгууллага, аж ахуйн нэгжийг тогтоох;

3) төсвийн орлогыг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх;

4) батлагдсан төсвийг хуваарилан зарцуулах;

5) төсөвт хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;

6) батлагдсан төсвийн орлого, зарлагад төсвийн жилийн дунд үр өөрчлөлт оруулах шаардлага гарвал саналаа улсын төвлөрсөн төсвийн хувьд Улсын Их Хуралд, орон нутгийн төсвийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;

7) батлагдсан төсвийг төсвийн анги, салбар, дэд салбар, бүлгийн хооронд шилжүүлэн зарцуулах. Улсын Их Хурал болон тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хязгаар тогтоон баталсан төсвийн зарлагад энэ заалт хамаарахгүй;

8) төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн төсвийн төсөл, гүйцэтгэлийн тайланг хүлээн авч хянах;

9) төсвийн төслийг боловсруулах, гүйцэтгэлийг хангах, хяналт тавих ажлыг улсын төвлөрсөн төсвийн хувьд Сангийн яамаар, орон нутгийн төсвийн хувьд тухайн шатны Засаг даргын тамгын газрын санхүүгийн хэлтэс, тасгаар гүйцэтгүүлэх;

10) аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нутаг дэвсгэртээ байгаа улсын төвлөрсөн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагаас улсын төвлөрсөн төсөвт орох орлогыг, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч нутаг дэвсгэртээ байгаа аймаг, нийслэлийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, бай-

гуулдагаас аймаг, нийслэлийн төсөвт орох орлогыг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;

11) төсвийн шууд захирагчийн тухайн жилийн төсөвт тусгагдсан арга хэмжээ бүрэн хэрэгжиээгүй, эсхүл төсвийн норм, норматив, үнэ, тарифт өөрчлөлт орсноос хэмнэгдсэн төсвийн хөрөнгийг хураан авч зарлагаа төсөвт оруулах;

12) төсвийн хууль тогтоомж зөрчсөн төсвийн төвлөрүүлэн захирагч болон шууд захирагчийн данснаас зарлагын гүйлгээ хийхийг түр зогсоох.

3. Төсвийн шууд захирагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) төсвийг түүний зүйлийн хооронд шилжүүлэн зарцуулах. Харин төсвийн бусад зүйлээс цалинд мөн Засгийн газрын тусгай зориулалтын санг өөр зүйлд шилжүүлэн зарцуулахыг хориглоно;

2) төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах;

3) энэ зүйлийн 2 дахь хэсгийн 11-д зааснаас бусад хэмнэлтийг захиран зарцуулах;

4) төсвийн төслийг үндэслэлтэй зохиох;

5) төсвийн гүйцэтгэлийн тайланг тогтоосон хугацаанд гаргах.

4. Төсвийн төвлөрүүлэн захирагч энэ зүйлийн 2 дахь хэсгийн 4, 5, 8, 11-д заасан ерөнхийлөн захирагчийн бүрэн эрх, мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан шууд захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### *Төсвийн орлого, зарлага*

*6 дугаар зүйл.* Төсвийн орлого, зарлагын ангилал

Төсөв зохиох, гүйцэтгэлийн тайлан гаргахдаа төсвийн орлого, зарлагыг анги, салбар, дэд салбар, бүлэг, зүйлээр ангилна. Төсвийн орлого, зарлагын ангиллыг Сангийн сайд тогтооно.

*7 дугаар зүйл.* Төсвийн орлого

Төсвийн орлого татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ:

1) татварын орлого Татварын ерөнхий хуулиар тодорхойлсон албан татвар, хураамж, төлбөрөөс бүрдэнэ;

2) татварын бус орлого төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг (дивиденд), төрийн өмчийн эд хөрөнгийг борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орох бусад орлогоос бүрдэнэ.

*8 дугаар зүйл.* Улсын төвлөрсөн төсвийн орлого

1. Улсын төвлөрсөн төсвийн татварын орлого дараахь орлогоос бүрдэнэ:

1) гаалийн албан татвар;

2) импортын барааны худалдааны болон онцгой албан татвар;

3) Засгийн газраас улсын төвлөрсөн төсөвтэй харьцахаар тогтоосон аж ахуйн нэгж, байгууллагын орлогын, худалдааны болон онцгой албан татвар.

2. Улсын төвлөрсөн төсвийн татварын бус орлого улсын төвлөрсөн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагын дараахь орлогоос бүрдэнэ:

1) төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг (дивиденд);

2) төрийн өмчийн эд хөрөнгийг борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

3) хууль тогтоомжийн дагуу улсын төвлөрсөн төсөвт орох бусад орлого.

*9 дүгээр зүйл.* Орон нутгийн төсвийн орлого

1. Аймаг, нийслэлийн төсвийн татварын орлого дараахь орлогоос бүрдэнэ:

1) аймаг, нийслэлийн Засаг даргаас аймаг, нийслэлийн төсөвтэй харьцахаар тогтоосон аж ахуйн нэгж, байгууллагын орлогын, худалдааны болон онцгой албан татвар;

2) хотын албан татвар;

3) ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр;

4) газрын төлбөр;

5) ус ашигласны төлбөр.

2. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3, 4, 5-д заасан албан татвар, төлбөрийн орлогыг сум, дүүргийн төсөвт бүрэн буюу хэсэгчлэн оруулахаар шийдвэрлэж болно.

3. Аймаг, нийслэлийн төсвийн татварын бус орлого аймаг, нийслэлийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагын дараахь орлогоос бүрдэнэ:

1) төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг (девиденд);

2) төрийн өмчийн эд хөрөнгийг борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

3) хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт орох бусад орлого.

4. Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараахь орлогоос бүрдэнэ:

1) аймаг, нийслэлийн Засаг даргаас сум, дүүргийн төсөвтэй харьцахаар тогтоосон аж ахуйн нэгж, байгууллагын орлогын, худалдааны болон ашгийн албан татвар;

2) хүн амын орлогын албан татвар;

3) авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар;

4) өв залгамжлал, бэлэглэлийн албан татвар;

5) үл хөдлөх хөрөнгийн албан татвар;

6) бууны албан татвар;

7) нийтийг хамарсан спорт, урлаг сайхны арга хэмжээний орлогын албан татвар;

8) хот суурин газрын нохойны албан татвар;

9) улсын тэмдэгтийн хураамж;

10) замын хураамж;

11) ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж;

12) ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж;

13) байгальтай харьцахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж;

14) захын нэг удаагийн хураамж;

15) ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр;

16) түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр;

17) рашаан ашигласны төлбөр;

18) энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3, 4, 5-д заасан орлогоос сум, дүүргийн төсөвт оруулах орлого.

5. Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого сум, дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагын дараахь орлогоос бүрдэнэ:

1) төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг (дивиденд);

2) төрийн өмчийн эд хөрөнгийг борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

3) хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого.

6. Аж ахуйн нэгж, байгууллагын тодорхой нэр төрлийн татварын болон татварын бус орлого хэд хэдэн төсөвт хуваагдан орохоор байвал дээд шатны төсөвт орох орлогыг тэргүүн ээлжинд төлнө.

*10 дугаар зүйл.* Төсвийн зарлага

1. Төсвөөс дараахь зардлыг санхүүжүүлнэ:

1) төрийн төв, орон нутгийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын зардал;

2) боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, эрүүл мэнд, биеийн тамир, зоо мал эмнэлгийн зардал;

3) улс орныг батлан хамгаалах арга хэмжээний зардал;

4) байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх болон улсын захиалгат геологи хайгуулын зардал;

5) хүн, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал;

6) эдийн засгийн суурь дэд бүтцийг хөгжүүлэх, нийгмийн зориулалттай арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсвөөс зарцуулах хөрөнгө оруулалтын зардал;

7) бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг жигдрүүлэх, хүн амын цөөнх зарим үндэстэн, ястны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгалийн гамшиг, гэнэтийн бусад зүүд, ган, зуд болон хүн, малд учирсан гоц халдварт өвчний хохирлыг арилгах, үйлдвэрлэлийг урамшуулах зорилгоор дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээнд зарцуулах Засгийн газрын нөөц хөрөнгө, төсвийн бусад зардал;

8) Монгол Улсын хууль тогтоомжид төсвөөс санхүүжүүлэхээр заасан бусад зардал.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3-т заасан зардалд тухайн байгууллагын төлбөртэй ажил, үйлчилгээний болон өөрийн бусад орлогын эх үүсвэрээр нөхөгдөх зардал хамаарахгүй.

3. Засгийн газрын төслийг хэрэгжүүлэх арга хэмжээнд төсвийн хөрөнгийг эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж болно. Төсвийн хөрөнгийг эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах журмыг Засгийн газар тогтооно.

*11 дүгээр зүйл.* Улсын төвлөрсөн төсвийн зарлага

Улсын төвлөрсөн төсвөөс дараахь зардлыг санхүүжүүлнэ:

1) хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зардал;

2) шинжлэх ухаан, технологи хөгжүүлэх зардал;

3) байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, геологи хайгуулын улсын болон бүс нутгийн шинж чанартай арга хэмжээний зардал;

4) төрийн байгууллагын зардал;

5) улс орныг батлан хамгаалах арга хэмжээний зардал;

6) Засгийн газраас улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэхээр тогтоосон боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, биеийн тамирын байгууллага (эдгээр салбарт төвлөрүүлэн хуваарилж зарцуулах арга хэмжээний зардлыг оролцуулан)-ын зардал;

7) зээл, хүүгийн төлбөр болон гадаад арга хэмжээний зардал;

8) Засгийн газрын нөөц хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний зардал;

9) Засгийн газрын тусгай зориулалтын санд улсын төвлөрсөн төсвөөс өгөх татаас;

10) улсын зээллэгийн төлбөр;

11) хууль тогтоомжийн дагуу улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх бусад зардал.

*12 дугаар зүйл.* Орон нутгийн төсвийн зарлага

1. Аймаг, нийслэлийн төсвөөс дараахь зардлыг санхүүжүүлнэ:

1) хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зардал;

2) байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, геологи хайгуулын орон нутгийн шинж чанартай арга хэмжээний зардал;

3) аймаг, нийслэлийн Засаг даргаас аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэхээр тогтоосон боловсрол, шинжлэх ухаан, соёл урлаг, эрүүл мэнд, биеийн тамирын байгууллагын зардал;

4) засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн орон нутгийн удирдлагын зардал;

5) бусад зардал.

2. Сум, дүүргийн төсвөөс дараахь зардлыг санхүүжүүлнэ:

1) хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зардал;

2) байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх сум, дүүргийн шинж чанартай арга хэмжээний зардал;

3) аймаг, нийслэлийн Засаг даргаас аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжүүлэхээр тогтоосноос бусад нийгэм, соёлын байгууллагын зардал;

4) засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын зардал;

5) бусад зардал.

*13 дугаар зүйл.* Төсвийн тэнцэл, улсын төвлөрсөн төсөв, орон нутгийн төсвийн харьцаа

1. Төсөв зохиох, хянах, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах явцад бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгох, төсөвт зардлыг хэмнэх, төсвийн орлого нь зарлагаа нөхөж байх зарчмыг баримтлан тодорхой арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.

2. Төсвийн санхүүжилтэд улсын зээллэг, үнэт цаас, зээл, тусламжийн хөрөнгийг ашиглаж болно.

3. Төсвийн тухайн жилийн орлого, зарлага, төсвийн нөөцийн болон бусад мөнгөн хөрөнгө, зээл тусламж, Засгийн газрын ор,

авлагыг төсөв зохиох, гүйцэтгэлийн тайлан гаргахад бүрэн тусгаж харуулна.

4. Шаардлагатай тохиолдолд дээд шатны төсвөөс доод шатны төсөвт татаас өгч, санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### *Төсөв зохиох, хянах, батлах*

*14 дүгээр зүйл.* Төсвийн төсөл зохиох, хянах

1. Санхүүгийн төлөвлөгөө, төсвийн төслийг зохиохдоо энэ хууль, бусад хууль тогтоомж, эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас авах арга хэмжээ, төсвийн норм, норматив, үнэ, тариф болон бусад оронтой зээл, тусламжийн талаар байгуулсан гэрээ, хэлэлцээр зэргийг үндэс болгоно.

2. Зөвлөмжийг эрүүлж тогох баталгааг Засгийн газрын зөвшөөрснөөр Сангийн сайд гаргана. Төсвөөс санхүүжилт шаардагдах гэрээ хэлэлцээрийг зөвхөн Сангийн сайдын зөвшөөрснөөр байгуулна.

3. Аж ахуйн нэгж, төсөвт байгууллагууд дараа жилийн санхүүгийн төлөвлөгөө, төсвийн төслийг зохиож жил бүрийн 8 дугаар сарын 10-ны дотор харилцагч санхүүгийн байгууллагад ирүүлнэ.

4. Сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч тухайн шатны төсвийн төслийг хянан нэгтгэж жил бүрийн 9 дүгээр сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.

5. Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч сум, дүүргийн төсвийн төсөл, өөрийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн төлөвлөгөө, төсвийн төслийг хянан нэгтгэж аймаг, нийслэлийн төсвийн төслийг боловсруулан жил бүрийн 9 дүгээр сарын 20-ны дотор Сангийн яаманд ирүүлнэ.

6. Төвлөрүүлэн захирагч харьяа байгууллагын төсвийн төслийг хянан нэгтгэж жил бүрийн 9 дүгээр сарын 20-ны дотор Сангийн яаманд ирүүлнэ.

7. Засгийн газрын тусгай зориулалтын сангийн орлого, зарлагын төслийг Засгийн газраас томилсон байгууллага энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд Сангийн яаманд ирүүлнэ.

8. Санхүүгийн төлөвлөгөө, төсвийн төслийг тогтоосон хугацаанд зохиож ирүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллагын төсөвт

төлөх орлого, тэдгээрт төсвөөс олгох санхүүжилтийн хэмжээг төсвийн ерөнхийлөн захирагчдаас тодорхой тооцож төсвийн төсөлд тусгах бөгөөд энэ талаар гарсан маргааныг ерөнхийлөн захирагч хариуцахгүй.

9. Сангийн яам аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчдаас зохиож ирүүлсэн төсвийн төслийг хянан, улсын төвлөрсөн төсвийн төсөл, улсын төвлөрсөн төсвөөс аймаг, нийслэлийн төсөвт олгох татаас, санхүүгийн тусламж дэмжлэгийн талаархи саналын хамт жил бүрийн 10 дугаар сарын 20-ны дотор Засгийн газарт оруулна.

10. Засгийн газар Сангийн яамнаас оруулсан улсын төвлөрсөн төсвийн төслийг хянан хэлэлцэж, авах арга хэмжээний санал, хуулийн төсөл болон холбогдох судалгаа, материалын хамт 11 дүгээр сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

*15 дугаар зүйл.* Төсөв батлах

1. Засгийн газраас өргөн мэдүүлсэн улсын төвлөрсөн төсвийн төслийг Улсын Их Хурал хянан хэлэлцэж батална.

2. Улсын Их Хурал Засгийн газраас өргөн мэдүүлсэн улсын төвлөрсөн төсвийн төслийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор хэлэлцэн улсын төвлөрсөн төсвийн орлогын нийт дүн (орлогын нэр төрлөөр), улсын төвлөрсөн төсвийн зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт (шинээр эхлэх барилга, объектын төсөвт өртгийн хамт), удирдлага, батлан хамгаалах арга хэмжээний зардал, Засгийн газрын тусгай зориулалтын сан, улсын төвлөрсөн төсвөөс олгох татаас, Засгийн газраас тогтоосон төвлөрүүлэн захирагч байгууллагын төсвийн санхүүжилт, улсын төвлөрсөн төсвөөс аймаг, нийслэлийн төсөвт олгох татаасын хэмжээг баталж хууль гаргана.

Улсын төвлөрсөн төсвийг энэ хэсэгт заасаас дэлгэрэнгүй нэр төрлөөр батлах эрхийг Улсын Их Хурал эдэлнэ.

3. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын өргөн барьсан төсвийн төслийг төсвийн жил эхлэхээс өмнө хянан хэлэлцэж аймаг, нийслэлийн төсвийн орлогын нийт дүн (орлогын нэр төрлөөр), зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт (шинээр эхлэх барилга, объектын төсөвт өртгийн хамт), удирдлагын зардал, аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгох татаасын хэмжээг баталж тогтоол гаргана.

4. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын өргөн барьсан төсвийн төслийг төсвийн жил эхлэхээс

өмнө хянан хэлэлцэж сум, дүүргийн төсвийн орлогын нийт дүн (орлогын нэр төрлөөр), зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт (шинээр эхлэх барилга, объектын төсөвт өртгийн хамт), удирдлага, захиргааны зардлын хэмжээг баталж тогтоол гаргана.

5. Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах явцад шинээр бий болсон орлогын нэмэгдэл эх үүсвэрийн дунд багтаан цалин, удирдлага, батлан хамгаалах арга хэмжээний зардлаас бусад шаардлагатай зардлыг нэмэгдүүлэн санхүүжүүлж болно.

6. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөв батлахдаа улсын төвлөрсөн төсвөөс аймаг, нийслэлийн төсөвт, аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт өгөх татаасын хэмжээг нэмэгдүүлж болохгүй.

*16 дугаар зүйл.* Төсвийн нэгтгэл

Засгийн газар Улсын Их Хурлаас баталсан улсын төвлөрсөн төсөв болон орон нутгийн төсвийг нэгтгэн Монгол Улсын төсвийн хэмжээг гаргана.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

*Төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах*

*17 дугаар зүйл.* Төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах, хяналт тавих

1. Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн гүйцэтгэлийг сар, улирлаар зохион байгуулж, төсвийн орлогын биелэлтээс хамааруулан төсөвт зардлыг санхүүжүүлнэ.

2. Засгийн газар улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг гарган, түүнд зохих дүн шинжилгээ хийж, авах арга хэмжээний саналын хамт улирал тутам Улсын Их Хуралд танилцуулж байна.

3. Төсвийн шууд захирагч батлагдсан төсвийг гагцхүү төсвийн дансаар зарцуулна.

4. Улсын төвлөрсөн төсвөөс аймаг, нийслэлийн төсөвт өгөх татаас, санхүүгийн тусламж дэмжлэгийн хөрөнгийн хуваарийг тэдний саналыг харгалзан Сангийн яам, аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт өгөх татаас, санхүүгийн тусламж дэмжлэгийн хөрөнгийн хуваарийг тэдний саналыг харгалзан аймаг, нийслэлийн Засаг дарга сар, улирлаар тус тус тогтооно

5. Засгийн газрын тусгай зориулалтын сангийн гүйцэтгэлийг Засгийн газраас томилсон байгууллага зохион байгуулж улсын төвлөрсөн төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө хариуцна.

6. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө, улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг Засгийн газар Улсын Их Хурлын өмнө хариуцна.

7. Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг сум, дүүргийн Засаг дарга дараа сарын 1-ны дотор аймаг, нийслэлийн Засаг даргад, аймаг нийслэлийн Засаг дарга дараа сарын 3-ны дотор улсын төвлөрсөн төсвийн ерөнхийлөн захирагчид тус тус мэдээлнэ.

*18 дугаар зүйл.* Төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулахад банкны байгууллагын гүйцэтгэх үүрэг

Төсвийн орлого, зарлагын өдөр тутмын гүйлгээг Банкны хуулийн дагуу банкны байгууллагууд гүйцэтгэнэ.

*19 дүгээр зүйл.* Төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах, батлах

1. Төсвийн захирагчид төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн орлого, зарлагын ангиллаар гаргана.

2. Төсвийн шууд захирагч төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, жилээр гаргаж, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны дотор харьяалагч ерөнхийлөн буюу эсвэл төвлөрүүлэн захирагчид ирүүлнэ.

3. Сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч сум, дүүргийн төсвийн гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, хагас жилийн тайланг 7 дугаар сарын 25-ны дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 5-ны дотор аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.

4. Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч аймаг, нийслэлийн төсвийн гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, хагас жилийн тайланг 8 дугаар сарын 5-ны дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 20-ны дотор Сангийн яаманд ирүүлнэ.

5. Төсвийн төвлөрүүлэн захирагч төсвийн гүйцэтгэлийн тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, хагас жилийн тайланг 8 дугаар сарын 5-ны дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 20-ны дотор Сангийн яаманд ирүүлнэ.

6. Засгийн газрын тусгай зориулалтын сангийн удирдах зөвлөл, байгууллага уул сангийн гүйцэтгэлийн тайланг улирал

болон жилээр гаргаж, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн тайланг дараа оны 3 дугаар сарын 1-ний дотор Сангийн яаманд ирүүлнэ.

7. Улсын төвлөрсөн төсвийн ерөнхийлөн захирагч улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн тайланг 9 дүгээр сарын 1-ний дотор, жилийн тайланг дараа оны 3 дугаар сарын 15-ны дотор гаргана.

8. Засгийн газар улсын төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн жилийн тайланг Улсын Их Хурлын дараа оны хаврын чуулганд оруулна.

9. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга төсвийн гүйцэтгэлийн тайланг ирэх оны төсвийн төсөлтэй хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулна.

10. Улсын Их Хурал болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсвийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн баталж тогтоол гаргана.

11. Улсын төвлөрсөн төсвийн ерөнхийлөн захирагч улсын төвлөрсөн төсөв, орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэн Монгол Улсын төсвийн жил бүрийн гүйцэтгэлийг гаргана.

## ТАВДУГААР БҮЛЭГ

*Бусад зүйл*

*20 дугаар зүйл.* Төсвийн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

Төсвийн хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

*21 дүгээр зүйл.* Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хууль 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын эрхлэх ерөнхий бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

1992 оны 12 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1992 оны 12 дугаар
сарын 27-ний өдөр

Улаанбаатар
хот

# МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хянан хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Хүн амын орлогын албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

«3. Гадаадад ажиллаж байгаа Монгол Улсын иргэний төрөөс авдаг цалин, хөдөлмөрийн хөлсний орлогод ногдуулах албан татварын хэмжээг Засгийн газрын оруулсан саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоож байна.

4. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгчид татвар ногдуулах журмыг Засгийн газрын оруулсан саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоож байна.»

Монгол Улсын Их Хурлын
дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
хэлтсийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

| | |
|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр | Улаанбаатар хот |

## МОНГОЛ УЛСЫН 1993 ОНЫ УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн 1993 оны улсын төвлөрсөн төсвийн төслийг хэлэлцээд Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

*Нэг.* 1993 оны улсын төвлөрсөн төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг доор дурдсанаар баталсугай:

(мянган төгрөгөөр)

| | |
|---|---|
| Улсын төвлөрсөн төсвийн орлого—Бүгд | 31701298,1 |
| 1. Албан татвар | 24227224,5 |
| Үүнээс: 1) орлогын албан татвар | 9137442,3 |
| 2) гаалийн албан татвар | 6525000,0 |
| 3) худалдааны албан татвар | 5074645,2 |
| 4) онцгой албан татвар | 3490137,0 |
| 2. Татварын бус орлого | 2584073,6 |
| 1) хувьцааны ногдол ашиг | 2548827,2 |
| 2) бусад орлого | 4925246,4 |

*Хоёр.* 1993 оны улсын төвлөрсөн төсвийн зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт, үндэслэгээ, батлан хамгаалах арга хэмжээний зардал, Засгийн газраас тогтоосон төлөөрүүлэн захирагчийн төсвийн санхүүжилт, Засгийн газрын тусгай зориулалтын сан, аймаг, нийслэлийн төсөвт өгөх татаасын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

(мянган төгрөгөөр)

| | |
|---|---|
| Улсын төвлөрсөн төсвийн зарлага—Бүгд | 38733852,1 |
| 1) цалингийн сан | 1951642,5 |
| 2) хөрөнгө оруулалт | 3532953,3 |

Үүнээс: шинээр эхлэх барилга, объектын төсөвт өртөг

| | |
|---|---|
| 3) удирдлагын зардал | 1728327,6 |
| 4) батлан хамгаалах арга хэмжээний зардал | 2493318,1 |
| 5) шүүхийн байгууллагын зардал | 73059,9 |
| 6) улсын аюулгүй байдлыг хангах байгууллагын зардал | 1145007,2 |
| 7) Засгийн газрын тусгай зориулалтын санд олгох татаас—бүгд | 3819400,0 |
| Үүнээс: а) тэтгэврийн санд олгох татаас | 3699400.0 |
| б) амьдрал ядуу, бага орлоготой айл өрх, иргэдэд туслах санд олгох татаас | 120000,0 |
| 8) аймаг, нийслэлийн төсөвт өгөх татаас—бүгд | 6476721,0 |

*Гурав.* Улсын төвлөрсөн төсвөөс аймаг, нийслэлийн төсөвт өгөх татаасын хэмжээг дор дурдсанаар тогтоосугай:

(мянган төгрөгөөр)

| | |
|---|---|
| 1) Архангай | 457216,3 |
| 2) Баян-Өлгий | 378776,7 |
| 3) Баянхонгор | 402054,5 |
| 4) Булган | 258497,8 |
| 5) Говь-Алтай | 385681,2 |
| 6) Дорноговь | 282853,6 |
| 7) Дорнод | 41845.8 |
| 8) Дундговь | 289806,1 |
| 9) Завхан | 542248,3 |
| 10) Өвөрхангай | 509176,0 |
| 11) Өмнөговь | 224547,4 |
| 12) Сүхбаатар | 226410,7 |
| 13) Сэлэнгэ | 228635,6 |
| 14) Төв | 393541,4 |
| 15) Увс | 344176,1 |
| 16) Ховд | 363667,9 |
| 17) Хөвсгөл | 588270,6 |
| 18) Хэнтий | 337501,8 |
| 19) Дархан | 48530,1 |
| 20) Улаанбаатар | 41485,6 |

| | |
|---|---|
| 21) Эрдэнэт | 40271,1 |
| 22) Чойр | 81526,4 |

Монгол Улсын Их Хурлын дэд дарга — **Ж. ГОМБОЖАВ**

**Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий** нарийн бичгийн дарга — **Н. РИНЧИНДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр — Улаанбаатар хот

# ТЭТГЭВРИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Тэтгэврийн хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 3 дахь хэсгийн 1 дэх дэд хэсэг, 11 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1) 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

«2. Нийтдээ 32 жил ажилласан 55 насанд хүрсэн эрэгтэйчүүд, 27 жил ажилласан 50 насанд хүрсэн эмэгтэйчүүд сонгосон хүсвэл тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.»;

2) 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх дэд хэсэг:

«1) зэвсэгт хүчин, улсын аюулгүй байдлыг хангах, цагдаагийн болон засан хүмүүжүүлэх хэлтэс, байгууллагын генерал, офицер, удирсан албан хаагч, цэрэг, хилийн, хил хамгаалах, түүнчлэн цэргийн албан хаагчаар 25-аас доошгүй жил (энэ хугацаанд цэргийн жинхэнэ алба хаасан хугацааг оруулан тооцно), байлдааны шалгах тэргүүний нисгэгчээр 25-аас

доошгүй жил, байлдааны тийрэлтэт сөнөөгч онгоцны экипажид нисгэгчээр 20-иос доошгүй жил алба хаасан эрэгтэй»;

3) 11 дүгээр зүйл:

*«11 дүгээр зүйл.* Эхчүүдийн насны тэтгэвэр тогтоолгох эрх

Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөж хүмүүжүүлсэн эхчүүд 15-аас доошгүй жил ажилласан 50 насанд хүрсэн буюу 20-иос доошгүй жил ажилласан 55 насанд хүрсэн бол тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.»

Хоёр. Тэтгэврийн хуульд дор дурдсан агуулгатай $11^1$ дүгээр зүйл нэмсүгэй:

*«$11^1$ дүгээр зүйл.* Өнчин хүүхэдтэй эцгийн насны тэтгэвэр тогтоолгох эрх

Төрсөн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан 16 хүртэл насны дөрөв, түүнээс дээш өнчин хүүхэдтэй үлдэж, хүүхдүүдээ 6 настай болтол нь дангаараа өсгөж хүмүүжүүлсэн эцэг 20-иос доошгүй жил ажилласан 50 насанд хүрсэн бол тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.»

Гурав. Энэ хуулийг 1993 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дөрөв. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй байхаар тогтоосугай.

Монгол Улсын Их Хурлын дэд дарга — Ж. ГОМБОЖАВ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

| | |
|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр | Улаанбаатар хот |

# ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Хөдөлмөрийн хуулийн 21 дүгээр зүйл, 95 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1) 21 дүгээр зүйл:

«*21 дүгээр зүйл.* Ажлаас халагдсаны тэтгэмж

Захиргаа нь ажлаас халагдсан ажилтанд доор дурдснаас бусад тохиолдолд нэг сараас доошгүй хугацааны дундаж цалинтай тэнцэх тэтгэмж олгоно:

1) хамтын болон хөдөлмөрийн гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр хөдөлмөрийн гэрээг цуцалсан;

2) энэ хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, 7 (эрүүл мэндийн болон мэргэжлийн хувьд тэнцэхгүй болсноос бусад шалтгаанаар эрх бүхий байгууллагын шаардлагаар ажлаас халагдсан), 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 5-д заасан үндэслэлээр ажлаас халагдсан»;

2) 95 дугаар зүйл:

«*95 дугаар зүйл.* Хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих байгууллага

Хөдөлмөрийн хууль тогтоомжийн биелэлтэд төрийн хяналт шалгалтыг Засгийн газар, бүх шатны Засаг дарга, Монгол Улсын хууль тогтоомжоор эрх олгосон бусад байгууллага тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ.»

Хоёр. Хөдөлмөрийн хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т «удаа дараа зөрчсөн» гэсний дараа», эсхүл хөдөлмөрийн ха

рилцааг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд заасан ноцтой зөрчил гаргасан» гэж нэмсүгэй.

Гурав. Хөдөлмөрийн хуулийн 36 дугаар зүйлийн заалтыг мөн зүйлийн 1 дэх хэсэг болгож, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь хэсэг нэмсүгэй:

«2. Чөлөөтэй байсан хугацаанд ажилтанд тэтгэмж олгох эсэх асуудлыг хамтын гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.»

Монгол Улсын Их Хурлын
дэд дарга — Ж. ГОМБОЖАВ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1993 оны 1 дүгээр
сарын 8-ны өдөр

Улаанбаатар
хот

## ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас 1991 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Бонн хотноо байгуулсан «Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хооронд хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай гэрээ»-г соёрхон батласугай.

Монгол Улсын Их Хурлын
дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1992 оны 12 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 34 | Улаанбаатар хот

# БҮГД НАЙРАМДАХ БОСНА-ГЕРЦЕГОВИНА УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Ард түмний өөртөө засан тохинох эрхийг хүндэтгэх зарчмыг үндэслэн Бүгд Найрамдах Босна-Герцеговина Улсын тусгаар тогтнолыг Монгол Улс хүлээн зөвшөөрсүгэй.

2. Бүгд Найрамдах Босна-Герцеговина Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн тухай тус Улсын Засгийн газарт мэдэгдэж дипломат харилцаа тогтоох талаар хэлэлцээ хийхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

Дарга — Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1992 оны 12 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 35 | Улаанбаатар хот

# БҮГД НАЙРАМДАХ ХОРВАТ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Ард түмний өөрийгөө засан тогтнох эрхийг хүндэтгэх зарчмыг үндэслэн Бүгд Найрамдах Хорват Улсын тусгаар тогтнолыг Монгол Улс хүлээн зөвшөөрсүгэй.

2. Бүгд Найрамдах Хорват Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн тухай тус Улсын Засгийн газарт мэдэгдэж дипломат харилцаа тогтоох талаар хэлэлцээ хийхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

Дарга — Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 36 | Улаанбаатар хот |

# БҮГД НАЙРАМДАХ СЛОВЕНИ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Ард түмний өөртөө засан тохинох эрхийг хүндэтгэх зарчмыг үндэслэн Бүгд Найрамдах Словени Улсын тусгаар тогтнолыг Монгол Улс хүлээн зөвшөөрсүгэй.

2. Бүгд Найрамдах Словени Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн тухай тус Улсын Засгийн газарт мэдэгдэж дипломат харилцаа тогтоох талаар хэлэлцээ хийхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

*Дарга* Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1992 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр | Дугаар 37 | Улаанбаатар хот

# МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Татварын ерөнхий хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай:

1) Засгийн газрын болон яам, тусгай газрын шийдвэрийг Татварын ерөнхий хуульд нийцүүлэх арга хэмжээг 1993 оны 1 дүгээр сарын 1-ний дотор авах;

2) гүйлгээний татвар, ангийн бууны хураамж, улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээ тогтоохтой холбогдсон санал боловсруулж 1992 оны 12 дугаар сарын 25-ны дотор Улсын Их Хуралд оруулах.

Дарга — Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 38 | Улаанбаатар хот |

# ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

«Тээврийн хэрэгсэл эзэмшигчдээс хураах татварын тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1959 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 90 дүгээр зарлигийн 11-р зүйлээс бусад зүйлийг 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

| | |
|---|---|
| **Дарга** | **Н. БАГАБАНДИ** |
| **Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** | **Н. РИНЧИНДОРЖ** |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 39 | Улаанбаатар хот |

### ДҮҮРГИЙН НЭРИЙГ ӨӨРЧЛӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

«Улаанбаатар (нийслэл) хотын район, хороог татан буулгаж, шинээр дүүрэг байгуулах тухай» Улсын Их Хурлын 1992 оны 18 дугаар тогтоолын хоёрдугаар зүйлийн 6-д «Сонгино» дүүрэг гэснийг «Сонгино хайрхан» дүүрэг гэж өөрчилсүгэй.

**Дарга** — **Н. БАГАБАНДИ**

**Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** — **Н. РИНЧИНДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 40 | Улаанбаатар хот |

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасны дагуу улсын төвлөрсөн төсөв, аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвтэй харьцах аж ахуйн нэгж, бай-

гууллагыг 1992 онд багтаан тогтоохыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

2. Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан төсвийн хөрөнгийг эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах журмыг 1993 оны I улиралд багтаан боловсруулж гаргахыг Засгийн газар (П. Жасрай)-т даалгасугай.

3. «БНМАУ-ын Төсвийн эрхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын 1989 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн тогтоолыг 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

| | |
|---|---|
| Дарга | Н. БАГАБАНДИ |
| Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 42 | Улаанбаатар хот |

## Д. БЯМБАСҮРЭНГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Дашийн Бямбасүрэнг гаргасан хүсэлтийг нь харгалзан Монгол Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

| | |
|---|---|
| Дарга | Н. БАГАБАНДИ |
| Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

1992 оны 12 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 44 | Улаанбаатар хот

# БҮГД НАЙРАМДАХ СЛОВАК УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, ТУС УЛСТАЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа зарласан Бүгд Найрамдах Словак Улсын тусгаар тогтнолыг Монгол Улс 1993 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүлээн зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Словак Улстай дипломат харилцаа тогтоосугай.

3. Бүгд Найрамдах Словак Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрснийг мэдэгдэж, тус улстай дипломат харилцаа тогтоосонтой холбогдох ажлыг ёсчлон гүйцэтгэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

Дарга — Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 45 | Улаанбаатар хот |

# БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, ТУС УЛСТАЙ ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа зарласан Бүгд Найрамдах Чех Улсын тусгаар тогтнолыг Монгол Улс 1993 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүлээн зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улстай дипломат харилцаа тогтоосугай.

3. Бүгд Найрамдах Чех Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрснийг мэдэгдэж, тус улстай дипломат харилцаа тогтоосонтой холбогдох ажлыг ёсчлон гүйцэтгэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай.

| | |
|---|---|
| Дарга | Н. БАГАБАНДИ |
| Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

| | | |
|---|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр | Дугаар 01 | Улаанбаатар хот |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 1993 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын 1993 оны зардлын төсвийг 61853,0 мянган төгрөгөөр баталсугай.

**Дарга** **Н. БАГАБАНДИ**

**Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** **Н. РИНЧИНДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

| | | |
|---|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр | Дугаар 02 | Улаанбаатар хот |

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН 1993 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1993 оны зардлын төсвийг 1991,9 мянган төгрөгөөр баталсугай.

**Дарга** **Н. БАГАБАНДИ**

**Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** **Н. РИНЧИНДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

| | | |
|---|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр | Дугаар 03 | Улаанбаатар хот |

# ЦАЛИНГИЙН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 1992 оны 12 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дэд дарга, Ерөнхий сайдын орлогч, Улсын Их Хурлын байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүний сарын цалинг 60 хувиар нэмэгдүүлсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын 1992 оны 20 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн дарга, гишүүний сарын цалинг 60 хувиар нэмэгдүүлсүгэй.

3. Монгол Улсын Их Хурлын 1992 оны 13 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

| | |
|---|---|
| **Дарга** | **Н. БАГАБАНДИ** |
| **Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** | **Н. РИНЧИНДОРЖ** |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1993 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр | Дугаар 04 | Улаанбаатар хот

## ЗАРИМ ХҮНИЙГ АЖИЛД ТОМИЛОХ, АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Цэрэндоржийн Балдоржийг Төрийн тов хэвлэл «Ардын эрх» сонины ерөнхий эрхлэгчээр томилсугай.
2. Батмөнхийн Лигдэнг «Ардын эрх» сонины ерөнхий эрхлэгчийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

**Дарга** — **Н. БАГАБАНДИ**

**Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** — **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1993 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр | Дугаар 05 | Улаанбаатар хот

## Ч. ГАН-ӨЛЗИЙН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын сонгуулийн 18 дугаар тойрогт Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсон Ч. Ган-Өлзийн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

**Дарга** — **Н. БАГАБАНДИ**

**Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** — **Н. РИНЧИНДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр | Дугаар 06 | Улаанбаатар хот |

## ШҮҮГЧ, ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Шүүгчдийн цалинг 1 дүгээр хавсралтаар, прокурорын албан тушаалын цалинг 2 дугаар хавсралтаар тус тус баталж 1993 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн түр мөрдөж байхаар тогтоосугай.

2. Шүүгч, прокурор нарт 1993 оны 1 дүгээр сард олгох цалинг тэдний одоогийн албан тушаалын цалингийн 50 хувиар нэмэгдүүлэн тооцох нь зүйтэй гэж үзсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 10 дугаар тогтоолын 1 дэх заалтыг 1993 оны 2 дугаар сарын 1-нээс хүчингүй болсонд тооцсугай.

**Дэд дарга** — **Ж. ГОМБОЖАВ**

**Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга** — **Н. РИНЧИНДОРЖ**

Монгол Улсын Их Хурлын 1993 оны
06 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ШҮҮГЧДИЙН ЦАЛИН

| № | Албан тушаал | сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр) |
|---|---|---|
| | НЭГ. *Улсын дээд шүүх* | |
| 1. | Дарга (Ерөнхий шүүгч) | 11000 |
| 2. | Нэгдүгээр орлогч дарга | 9600 |
| 3. | Орлогч дарга | 9600 |
| 4. | Коллегийн дарга | 8800 |
| 5. | Гишүүд (шүүгч) | 8800 |
| | ХОЁР. *Нийслэл, Бүх цэргийн тусгай шүүх* | |
| | Дарга (Ерөнхий шүүгч) | 8800 |
| | Орлогч дарга | 7000 |
| | Гишүүн (шүүгч) | 7000 |
| | ГУРАВ. *Нийслэлийн дүүрэг, цэргийн гарнизоны тусгай шүүх* | |
| | Дарга (Ерөнхий шүүгч) | 7000 |
| | Шүүгч | 6500 |
| | ДӨРӨВ. *Аймаг, Дархан, Эрдэнэт, Чойр хот, Төмөр замын шүүх* | |
| | Дарга (Ерөнхий шүүгч) | 7600 |
| | Орлогч дарга | 6500 |
| | Гишүүн (шүүгч) | 6500 |
| | ТАВ. *Сум буюу сум дундын шүүх* | |
| | Дарга (Ерөнхий шүүгч) | 6500 |
| | Шүүгч | 6000 |

Монгол Улсын Их Хурлын 1993 оны
06 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРУУДЫН АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИН

| № | Албан тушаал | сарын цалингийн хэмжээ (төгрөгөөр) |
|---|---|---|
| | **НЭГ.** *Улсын прокурорын газар* | |
| 1. | Ерөнхий прокурор | 10800 |
| 2. | Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогч | 9400 |
| 3. | Ерөнхий прокурорын орлогч | 9400 |
| 4. | Ерөнхий прокурорын туслах | 8600 |
| 5. | Хяналтын прокурор | 6800 |
| | **ХОЁР.** *Нийслэл, цэргийн ерөнхий прокурорын газар* | |
| 1. | Прокурор | 8600 |
| 2. | Орлогч прокурор | 7000 |
| 3. | Туслах прокурор | 6400 |
| 4. | Хяналтын прокурор | 6200 |
| | **ГУРАВ.** *Нийслэлийн дүүрэг, цэргийн гарнизоны прокурорын газар* | |
| 1. | Прокурор | 6900 |
| 2. | Туслах прокурор | 6000 |
| | **ДӨРӨВ.** *Аймаг, Дархан, Эрдэнэт, Чойр хот, Төмөр замын прокурорын газар* | |
| 1. | Прокурор | 7500 |
| 2. | Орлогч прокурор | 6400 |
| 3. | Туслах прокурор | 6200 |
| | **ТАВ.** *Сум буюу сум дундын прокурорын газар* | |
| 1. | Прокурор | 6400 |
| 2. | Хяналтын прокурор | 5900 |

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр | Дугаар 07 | Улаанбаатар хот |

## «ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 1993 ОНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ»-ИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

НЭГ. «Төрөөс мөнгөний бодлогын талаар 1993 онд баримтлах чиглэл»-ийг хавсралтын ёсоор батлсугай.

ХОЁР. «Төрөөс мөнгөний бодлогын талаар 1993 онд баримтлах чиглэл» батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанкинд даалгасугай:

1) чөлөөт валютын тооцоонд шилжсэнээс хойшхи хугацаанд үүсэн гадаад зээлийн өр, төлбөрийн талаар болон улсын валютын нөөцийг сэргээх тодорхой санал боловсруулж энэ оны 3 дугаар сард багтаан Улсын Их Хуралд оруулах;

2) Монголбанкны гадаад активыг энэ оны эхний хагаст багтаан 10,0-аас доошгүй сая ам. доллараар нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

3) улсын эрдэнэсийн сангийн талаар төрөөс баримтлах бодлогын үндсийг боловсруулж Улсын Их Хурлын энэ оны хаврын чуулганд оруулах;

4) мөнгөний эргэлтийг түргэтгэх, төлбөр тооцоог шуурхай болгох шаардлагад нийцүүлэн банкны холбоо, мэдээллийн сүлжээг сайжруулах, найдвартай ажиллагааг хангах, төлбөрийн бэлэн бус тооцооны хэлбэрийг нэвтрүүлэх арга хэмжээ авах;

5) дор дурдсан хуулийн төслийг боловсруулж энэ оны эхний хагас жилд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх:

а) валютын тухай хууль;

б) зээл, тооцооны харилцааны тухай хууль;

в) мөнгөн хадгаламжийн тухай хууль;

б) Засгийн газраас авч явуулах бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулан арилжааны банкнаас олгох зээлд өрийн бичиг, баталгаа гаргаж өгөх.

ГУРАВ. Мөнгөний бодлогын хэрэгжилт, үр дүнг улирал тутам, мөнгөний статистик мэдээллийг сар тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк (Д. МОЛОМЖАМЦ)-ид даалгасугай.

ДӨРӨВ. Арилжааны банкны төлбөрийн чадварыг нийт активт эзлэх өөрийн хөрөнгийн хэмжээ, арилжааны банкнаас нэг зээлдэгчид олгох зээлийн дээд хэмжээ, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд ногдох түргэн борлогдох актив, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө, зээлийн харьцаа зэрэг үзүүлэлтээр дүгнэж байхаар тогтоосугай.

ТАВ. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж шаардлагатай туслалцаа үзүүлж байхыг Улсын Их Хурлын Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо (А. БАЗАРХҮҮ)-ид үүрэг болгосугай.

Дэд дарга — Ж. ГОМБОЖАВ

Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

Улсын Их Хурлын 1993 оны 07 дугаар тогтоолын хавсралт

## ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 1993 ОНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Төрөөс мөнгөний бодлогын талаар дараахь чиглэлийг баримтална:

— эдийн засгийг зах зээлийн харилцаанд шилжүүлэх үйл явцыг гүнзгийрүүлэх, эдийн засгийг тогтворжуулах шаардлагад нийцүүлэн мөнгөний нийлүүлэлтийг эдийн засгийн бодит өсөлтийн үзүүлэлттэй уялдуулах, үнийн өсөлтийг бууруулахад чиглүүлэн мөнгөний эргэлтийг түргэтгэх, шинэ дэвсгэрт гүйлгээнд гаргаж хэрэглээ хангах;

— Засгийн газрын төсвийн алдагдлыг дотоодын банкны зээлээр оны дундуур санхүүжүүлж оны эцэст зээлийн өргүй байлгах;

— гүйлгээнд нэмж гаргах мөнгөний хэмжээг шийт мөнгөний цэвэр өсөлтийн 25 хувиас хэтрүүлэхгүйгээр бэлэн мөнгөний гүйлгээг зохицуулах;

— арилжааны банкнаас олгох зээл нь эргэж төлөгдөх баталгаатай, эдийн засгийн илүү үр ашигтай арга хэмжээнд зориулагдаж байх, зээлжүүлэх объектын төрөл, хэлбэрийг өргөжүүлэхэд чиглүүлж, Засгийн газрын захиалгатай зарим томоохон объектын хөрөнгө оруулалтын санхүүжилтийг арилжааны банкуудын хооронд өрсөлдүүлэх замаар сонголт хийлгэх, зээлийн тусгай сан байгуулж хамтран зээлжүүлэх арга хэмжээ хэрэгжүүлэх;

— эдийн засгийн бүтцийг өөрчлөх, хувийн секторыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд зээл, хүүгийн бодлогыг чиглүүлэх, хаврын тариалалт, ургац хураалт, мал, мах бэлтгэл зэрэг ходоо аж ахуйн цаг үеийн ажлыг санхүүжүүлэхэд зориулан Монголбанкнаас арилжааны банкуудад олгох зээлийн хүүг хөнгөлөлттэй тогтоох;

— банкнаас төгрөгийн хадгаламжид төлөх ба олгох зээлийн хүүг зөрөг түвшинд хүргэж, банкин дахь хадгаламжийн хөрөнгийн худалдан авах чадварыг хамгаалах замаар банкны системд итгэх итгэлийг бэхжүүлэх;

— төлбөр тооцоо, банкны бүртгэл, мэдээллийн тогтолцоог олон улсын жишигт хүргэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;

— валютын зах зээлийг хөгжүүлэх үндсэн дээр төгрөгийн чөлөөт валюттай харьцах ханшны хөвөх системд шилжих;

— улсын валютын нөөцийг сэргээж 20-иос доошгүй сая ам. долларт хүргэх, үнэт зүйл, эрдэнэсийн сангийн нөөцийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулан зохих журмын дагуу батлуулж хэрэгжүүлэх ажил зохион байгуулах, Монголбанкны гадаад активыг 10,0 сая хүртэл ам. доллараар нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

— төрийн өмчийн буюу төрийн өмч давамгайлсан хувь нийлүүлэгчээс арилжааны банкинд хувь нийлүүлсэн хөрөнгийг хувьчлах хөтөлбөр боловсруулж Улсын Их Хуралд танилцуулж, зохих журмын дагуу хэрэгжүүлэх;

— Засгийн газраас Олон улсын валютын сантай байгуулсан «Эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөр»-ийн биелэлтийг

гаргаж, улмаар «Эдийн засгийн бүтцийг тохируулан өөрчлөх төсөл»-ийн хүрээнд мөнгөний бодлогын чанартай арга хэмжээ авч холбогдох үзүүлэлтийг харилцан тохиролцож хэрэгжүүлэх;

— арилжааны банкнаас олгох нийт зээлийн 15-аас доошгүй хувийг эдийн засгийн бүтцийг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх ядлыг дэмжих чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхэд зориулах.

---

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

| | | |
|---|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр | Дугаар 09 | Улаанбаатар хот |

## «МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 1993 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ»-ИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-г үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. «Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1993 онд хөгжүүлэх үндсэн чиглэл»-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. «Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1993 онд хөгжүүлэх үндсэн чиглэл»-ийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж, явцыг улирал тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Засгийн газарт үүрэг болгосугай.

| | |
|---|---|
| **Дэд дарга** | **Ж. ГОМБОЖАВ** |
| **Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга** | **Н. РИНЧИНДОРЖ** |

*Улсын Их Хурлын 1993 оны 09 дүгээр тогтоолын хавсралт*

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 1993 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

1. Эдийн засгийн уналтыг сааруулан зогсоох үндсэн дээр нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг 1992 оны түвшингээс бууруулахгүй байх, улсын төсвийн алдагдлыг дотоодын нийт бүтээгдэхүүний 10 хувиас хэтрүүлэхгүй байлгах зорилтыг хэрэгжүүлнэ.

Энэ зорилгод нийцүүлэн макроэдийн засгийн зохицуулалтын дараах арга хэмжээ авна:

— үнэт цаасны зах зээлийг 1993 оны эхний хагаст багтаан ажиллуулж эхлэх, зарим боломжтой үйлдвэр, барилга, байгууламжийг худалдах зэргээр өмч хувьчлалыг шинэлэг агуулгаар баяжуулан их хувьчлалыг үндсэнд нь дуусгах, орон сууцны хувьчлалыг зохих бэлтгэл хангасны үндсэн дээр улс, иргэдийн эрх ашигт нийцүүлэн явуулах;

— төсөв, татварын шинэ тогтолцоонд шилжих, мөнгө, зээл, валютын цогцтой бодлого явуулж инфляцийн өсөлтийг хязгаарлах асуудлыг байнгын хяналтад байлгах;

— төгрөгийн гадаад валюттай харьцах чөлөөт ханшийн тогтолцоонд шилжих;

— үнэ, тарифыг 1993 оны эхний хагаст багтаан чөлөөт тогтолцоонд бүрэн шилжүүлэх;

— үйлдвэрлэл, эргэлтийн хүрээнд дангаар ноёрхох, ажил үйлчилгээний үнэ, тарифыг зохиомлоор нэмэгдүүлэх явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох, энэ зорилгоор дангаар ноёрхохын эсрэг хууль боловсруулж Улсын Их Хурлын хаврын чуулганаар хэлэлцүүлэх;

— тэргүүлэх салбаруудын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн дэд бүтэц, ялангуяа түлш, эрчим хүчний хангамжийг сайжруулах, нийгмийн зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтын бодлогыг чиглүүлэх;

— эрдэм шинжилгээний ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох үндсэн дээр улсын захиалгаар гүйцэтгэх шинжлэх ухаан, технологийн төслүүдэд сонгон шалгаруулалт хийж, түүнд хүч хөрөнгийг төвлөрүүлэх;

— эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэн олон улсын валют-санхүүгийн байгууллагатай тохирсон хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгийг оновчтой хуваарилах, ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах.

2. Хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэд бүтцийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор үйлдвэрлэл-технологийн бодлогын дараахь арга хэмжээ авна:

— мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулж хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хөнгөн үйлдвэрийг түүхий эдээр баталгаатай хангах нөхцөлийг бүрдүүлэх;

— хүн амын хүнсний хангамжийг сайжруулахад бүх нийтийн хүч, анхаарлыг төвлөрүүлж, хот суурин газрын оршин суугчдад тодорхой хэмжээний эдэлбэр газрыг эзэмшүүлэх, үр, бордоо, суулгац, хөдөлмөрийн багаж, хэрэгсэл нийлүүлэх замаар иргэд хүнсний бүтээгдэхүүнийхээ зохих хэсгийг өөрсдөө хангах нөхцөлийг бүрдүүлэх;

— хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нөхцөл бололцоог дээд зэргээр дайчлахын зэрэгцээ зарим хүнсний бүтээгдэхүүнийг импортлоход гаалийн татвараас чөлөөлөх зэргээр дэмжлэг үзүүлэх;

— үйлдвэрлэлийн хүч чадал, түүхий эдийн нөөцийг боломжит хэмжээгээр дайчлан ашиглаж бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

— өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжид төрийн дэмжлэгтайгаар алт олборлох бололцоо олгох, дэмжлэг үзүүлэх замаар олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх;

— уул уурхайн үйлдвэрт техникийн шинэчлэлт хийх, зарим ордыг шинээр ашиглах замаар онгот болон хоовор металлын олборлолт, зэс, молибдены баяжмалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, цагаан тугалганы баяжмал хайлуулах үйлдвэрлэлийн технологийг эзэмших;

— эдийн засгийн тэргүүлэх салбаруудын тогтвортой ажиллагаа хангах, хүн амын үйлчилгээг сайжруулах шаардлагад нийцүүлэн дэд бүтцийг хөгжүүлэх.

3. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн үеийн сөрөг үр дагаврыг багасгах зорилгоор нийгмийн баталгааны шинэ тогтолцоог бүрдүүлнэ. Энэ зорилгоор:

— хүн амын амьжиргааны баталгаажих доод түвшинг хагас жил тутамд шинэчлэн тогтоож түүнийг хангах нөхцөлийг бүрдүүлэх, баталгаажих доод түвшингээс бага орлоготой хүмүүст туслах хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх;

— хөдөлмөрийн насны ажлын чадвартай, ажил эрхлээгүй хүмүүст хувиараа хөдөлмөр эрхлэхэд нь туслах зорилгоор «Ажил эрхлэлтэд туслах сан» байгуулах;

— гурил, будаа, даавимба, цууямбуу, брезент, шахмал ногоон цай, дүнсэн тамхины нийлүүлэлтийг нэмэгдүүлж хангамжийг сайжруулах;

— «Хүн» хөтөлбөр, эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах төслүүдийг хэрэгжүүлж эхлэх;

— соёл, боловсрол, эрүүл мэндийн салбарын бүтцийг боловсронгуй болгох, эрүүл мэндийн болон тэтгэврийн даатгалын тогтолцоонд үе шаттайгаар шилжих арга хэмжээ авах.

Үйлдвэрлэлийн уналтыг зогсоох, хүнсний хангамжийг сайжруулахад чиглэгдсэн зорилтыг хэрэгжүүлсэнээр эдийн засгийг цаашид тогтворжуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

---

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 10 | Улаанбаатар хот |

# ЦАЛИНГИЙН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн сарын цалинг 10400 төгрөгөөр тогтоосугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан БНМАУ-ын Бага Хурлын 1991 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 33 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 1993 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Дэд дарга — Ж. ГОМБОЖАВ

Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр — Дугаар 11 — Улаанбаатар хот

## МОНГОЛБАНКНЫ 1993 ОНЫ ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монголбанкны 1993 оны орлогыг 207 250,0 мянган, зарлагыг 199 650,0 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

2. Монголбанкны дүрмийг боловсруулж 1992 оны үйл ажиллагааныхаа тайлан тэнцлийн хамт Улсын Их Хурлын 1993 оны хаврын чуулганд өргөн мэдүүлэхийг Монголбанк (Д. МОЛОМЖАМЦ)-нд даалгасугай.

Дэд дарга — Ж. ГОМБОЖАВ

Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
**ЗАРЛИГ**

1992 оны 12 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 160 | Улаанбаатар хот

## Д. ЕНДОНГ ЭЛЧИН САЙДЫН ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Дармын Ендонг Монгол Улсаас Япон улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
**ЗАРЛИГ**

1992 оны 12 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 161 | Улаанбаатар хот

## Б. ДОЛЖИНЦЭРЭНГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол улсаас Япон улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Балдан-Очирын Должинцэрэнг томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 11-ний өдөр | Дугаар 162 | Улаанбаатар хот |

## Х. ЖҮГДЭРНАМЖИЛД ХОШУУЧ ГЕНЕРАЛ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Монголын ардын цэргийн ар талын дарга хурандаа Хас-Очирын Жүгдэрнамжилд хошууч генерал цол олгосугай.

**Монгол Улсын Ерөнхийлөгч** **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 12-ны өдөр | Дугаар 166 | Улаанбаатар хот |

## ЗАРЛИГ, ЗАРЛИГИЙН ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль батлагдсантай холбогдуулан «Амьсгал боогдуулах, нулимс асгаруулах тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглох тухай» БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1991 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 61 дүгээр зарлиг, «Олон нийтийн хэв журам зөрчиж танхайрагчдад хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай» БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1991 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 62 дугаар зарлиг, «Өргөн хэрэглээний бараа, хүнсний зүйлийг хуваарилах,

борлуулах ашгийг журамлах, дамын наймаа хийгчдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай» БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1991 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 63 дугаар зарлиг, «Хүн амын зарим хоол хүнсний зайлшгүй хэрэгцээт барааны үнийг зохицуулах тухай» Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1992 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 82 дугаар зарлигийн гуравдугаар зүйлийг 1992 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч — П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 167 | Улаанбаатар хот |

## Л. МУНДАГБААТАРЫГ ЭЛЧИН САЙДЫН ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Тэмдэглэлтэй хугацаа дууссантай нь холбогдуулан Лувсандоржийн Мундагбаатарыг Монгол улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч — П. ОЧИРБАТ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 168 | Улаанбаатар хот |

## ХАСБАЗАРЫН БЭХБАТЫГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол улсаас Бүгд Найрамдах Франц Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Хасбазарын Бэхбатыг томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 169 | Улаанбаатар хот |

## ШАГНАЛ НӨХӨН ОЛГОХ ТУХАЙ

1. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1984 оны 71 дүгээр зарлигаар хурааж, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1984 оны 15 дугаар тогтоолын дагуу устгасан дор дурдсан одон, медаль, үнэмлэхийг С. Жалан-аажавт нөхөн олгосугай:

1) БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1946 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 48 дугаар тогтоолоор шагнасан Алтан гадас одон, үнэмлэх;

2) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1966 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 92 дугаар зарлигаар шагнасан Алтан гадас одон, үнэмлэх;

3) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1969 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 185 дугаар зарлигаар шагнасан Халхын голын ялалтын 30 жилийн ойн медаль, үнэмлэх;

4) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 66 дугаар зарлигаар шагнасан Ардын армийн 50 жилийн ойн медаль, үнэмлэх;

5) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 103 дугаар зарлигаар шагнасан Ардын хувьсгалын 50 жилийн ойн хүндэт медаль, үнэмлэх;

6) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 135 дугаар зарлигаар шагнасан Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, үнэмлэх;

7) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1971 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 147 дугаар зарлигаар шагнасан Цагдан сэргийлэх байгууллагын 50 жилийн ойн хүндэт тэмдэг, үнэмлэх;

8) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1972 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 130 дугаар зарлигаар шагнасан Улсыг аюулаас хамгаалах байгууллагын 50 жилийн ойн медаль, үнэмлэх;

9) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1973 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 134 дугаар зарлигаар шагнасан Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, үнэмлэх;

10) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1975 оны 9 дугаар сарын 1-ний өдрийн 187 дугаар зарлигаар шагнасан милитарист Японыг ялсны 30 жилийн ойн медаль, үнэмлэх;

11) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1979 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 230 дугаар зарлигаар шагнасан Халхын голын ялалт медаль, үнэмлэх;

12) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1979 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 306 дугаар зарлигаар шагнасан Алтан гадас одон... 

13) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1981 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 71 дугаар зарлигаар шагнасан БНМАУ-ын зэвсэгт хүчний 60 жилийн ойн медаль, үнэмлэх;

14) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1981 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 205 дугаар зарлигаар шагнасан Монгол ардын хувьсгалын 60 жилийн ойн хүндэт медаль, үнэмлэх;

15) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1983 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 115 дугаар зарлигаар шагнагдсан Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, үнэмлэх;

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан «С. Жамбын шагналыг хураах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1984 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 71 дүгээр зарлигийг хүчингүй болгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1992 оны 12 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

## П. ДАМБИЙБАЗАРТ МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Дөрөвдүгээр цахилгаан станцын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахын төлөө мэргэжлийн сайдар ур чадвараа дайчлан хөдөлмөрийн гарамгай амжилт гарган ажиллаж байгааг үнэлж тус станцын турбины засварчин Пунцагийн Дамбийбазарт Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол олгож, Сүхбаатарын одон, «Алтан соёмбо» тэмдгээр шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 171 | Улаанбаатар хот |

## ЗАРИМ ХҮМҮҮСТ МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн хэвийн ажиллагааг хангах, үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэхийн төлөө мэргэжлийн ур чадвараа дайчлан ажиллаж хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж байгааг үнэлж доор дурдсан хүмүүст Монгол Улсын гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

*Монгол Улсын гавьяат уурхайчин цолоор:*

1. Цэндийн Долгоржав — Дорнод аймгийн Адуунчулууны нүүрсний уурхайн «Белаз» авто машины жолооч
2. Өлзийтийн Шаравхаан — Налайхын нүүрсний уурхайн ахмад уурхайчин

*Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолоор:*

1. Дашзэвэгийн Нэнжаа — Төвийн эрчим хүчний системийн реле хамгаалалтын ахлах инженер
2. Шагдаржавын Чогсомжав — Эрчим хүчний барилга угсралтын трестийн техникч

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 172 | Улаанбаатар хот |

# ЗАРИМ ХҮМҮҮСИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Түлш, эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж доор дурдсан хүмүүсийг Монгол **Улсын одон, медалиар шагнасугай.**

*Сүхбаатарын одонгоор:*

Жигжидийн Хишигт — Багануурын нүүрсний уурхайн дарга

*Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор:*

1. Марусигийн Баатархүү — Багануурын нүүрсний уурхайн экскаваторын машинч
2. Оросоогийн Өлзийхишиг — Төвийн эрчим хүчний системийн «ХЭМЖИЛ» үйлдвэрийн ерөнхий зохион бүтээгч инженер
3. Хоохоны Магмар — Шарын голын нүүрсний уурхайн «Белаз» автомашины жолооч
4. Үдаапоровын Зундуй — II цахилгаан станцын инженер
5. Лувсандоржийн Ядмаа — Мөн станцын ерөнхий инженер
6. Чогсомжавын Чулуунбаатар — III цахилгаан станцын засварчин
7. Чойнжуурын Норовсамбуу — Эрчим хүчний тоног төхөөрөмжийн засвар, салбарын үйлдвэрийн засварчин

6. Самбалхүндэвийн Сүхбаатар — Эрчим хүчний барилга угсралтын трестийн контрын дарга

*Алтан медалиар:*

1. Норовхоожавын Гомбосүрэн — Архангай аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн дарга
2. Хивдырханы Султанхан — Баян-Өлгий аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн дарга
3. Багасүрэнгийн Гарамжав — Говь-Алтай аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн засварчин
4. Билэгтийн Гомбо — Мөн үйлдвэрийн засварчин
5. Сангийн Бимбасүрэн — Дорнод аймгийн Чойбалсан хотын дулааны цахилгаан станцуудын засвар үйлчилгээний төвийн ерөнхий инженер
6. Балдандоржийн Даваадорж — Мөн аймгийн Адуунчулууны нүүрсний уурхайн ерөнхий маркшейдер
7. Бадарчийн Бадамханд — Завхан аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн мастер
8. Цоодолын Балсанжав — Өвөрхангай аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн ерөнхий инженер
9. Дунжуурын Хүралжав — Ховд аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн дарга
10. Жамбалын Мунхаа — Мөн үйлдвэрийн боловсон хүчний тасгийн дарга
11. Баатарын Батсуурь — Дорноговь аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн хэсгийн мастер
12. Чагнаагийн Халтар — Өмнөговь аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн ахлах инженер

13. Самбын Сугир — Мон үйлдвэрийн мастер
14. Дэнсмаагийн Баянцогт — Дархан-Сэлэнгийн цахилгаан шугам сүлжээний газрын дарга
15. Санжжавын Болд — Мон газрын ашиглалт нөүлгүй ажиллагааны байцаагч инженер
16. Жамбаагийн Содном — Дарханы дулааны станц, шугам сүлжээний газрын мастер
17. Үстийн Мандах — Дархан хотын техникийн коллежийн дэд захирал
18. Нацагийн Батсуурь — Шарын-Овоогийн нүүрсний уурхайн ерөнхий инженер
19. Сахиткааны Бавархаан — Налайхын нүүрсний уурхайн бохалгаачин малтагч байсан
20. Маамуудайн Нямгүр — II цахилгаан станцын засварчин
21. Гомбожамцын Эрдэнээ — IV цахилгаан станцын цахилгаан цехийн ашиглалтын мастер
22. Баттогтохын Шатар — Мон станцын дарга
23. Жамбалжавын Дорж — Цахилгаан шугам сүлжээний газрын монтёр
24. Лувсандоржийн Дарамбазар — Мон газрын дарга
25. Дугаржавын Нэрэнгэрэл — Мон газрын монтёр
26. Ендонгийн Хөйлог — Мон газрын мастер
27. Сэрээтэрийн Аюурсэд — Дулааны шугам сүлжээний газрын дарга
28. Сономын Чогсомжав — Мон газрын хэлтсийн дарга
29. Цагааны Бааст — Эрчим хүчний тоног төхөөрөмж засвар сэлбэгийн үйлдвэрийн засварчин
30. Буньжавын Балганжав — Төвийн эрчим хүчний системийн инженер
31. Нямдоржийн Сод-Эрдэнэ — Мон системийн инженер

32. Сарэнангийн Жигмиддорж — Мөн системийн дарга
33. Самдангийн Мялхаа — Эрчим хүчний барилга угсралтын трестийн дарга
34. Бэгзийн Нямдаваа — Мөн трестийн ангийн дарга
35. Ванжилын Санждорж — «Нүүрс» компанийн хэсгийн дарга
36. Намын Цэдэвдорж — Автомашин механизмын баазын жолооч
37. Гонгоржавын Рэнцэндорж — Уул уурхайн хүрээлэнгийн ахлах инженер
38. Түндэвийн Цэнд — Түлш, эрчим хүчний сайдын туслах
39. Содномдоржийн Санжжав — Мөн яамны ахмадын хорооны нарийн бичгийн дарга
40. Содовын Батхуяг — Монгол-Оросын хамтарсан «ТААСТ» компанийн болор резонатор үйлдвэрийн захирал
41. Бямбын Жигжид — Түлш, эрчим хүчний сайд
42. Өлзийбаярын Гүржав — Түлш, эрчим хүчний тэргүүн дэд сайд

*Хөдөлмөрийн хүндэт медальтар:*

1. Найдангийн Дамбийням — Архангай аймгийн Хайрхан сумын эрчим хүчний салбарын мастер
2. Рагчаагийн Эрдэнэ-Очир — Мөн аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн слесарьч
3. Нуралын Таберек — Баян-Өлгий аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн цехийн дарга
4. Байнүркегийн Шамей — Мөн үйлдвэрийн дулааны станцын машинч
5. Бүргэдийн Бүлтүү — Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын эрчим хүчний салбарын эрхлэгч
6. Билэгийн Дорж — Мөн салбарын моторчин

| | | |
|---|---|---|
| 7. | Янгины Дашзэгвэ | — Мөн аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн цахилгаан станцын дарга |
| 8. | Сүхбатын Ендон | — Мөн үйлдвэрийн орлогч дарга |
| 9. | Түндэвийн Балжинням | — Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын эрчим хүчний салбарын дизельчин |
| 10. | Найдангийн Нансалцог | — Мөн аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн слесарьч |
| 11. | Жанчивын Бадарч | — Мөн аймгийн Зээгтийн нүүрсний уурхайн бульдозерчин |
| 12. | Багасүрэнгийн Галбаатар | — Мөн уурхайн экскаваторчин |
| 13. | Шархүүгийн Сүхбаатар | — Дорноговь аймгийн Даланжаргалан сумын эрчим хүчний салбарын эрхлэгч |
| 14. | Батнасангийн Усаннаха | — Мөн аймгийн Мандах сумын эрчим хүчний салбарын эрхлэгч |
| 15. | Санзайн Төмөртогоо | — Дорнод аймгийн Чойбалсан хотын дулааны цахилгаан станцын ажилчин |
| 16. | Хүдэрбатын Чимэдрагзэн | — Мөн аймгийн дулааны станцуудын засвар үйлчилгээний төвийн ахлах инженер |
| 17. | Дамдинсүрэнгийн Чулуунбаатар | — Мөн төвийн цехийн дарга |
| 18. | Сэндэвгийн Батжаргал | — Мөн аймгийн Адуунчулууны нүүрсний уурхайн дарга |
| 19. | Цогдалгарийн Буян | — Мөн уурхайн экскаваторчин |
| 20. | Моломын Цагаан | — Мөн уурхайн ерөнхий нягтлан бодогч |
| 21. | Дэндэвийн Оргодолзангоат | — Дундговь аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн инженер |
| 22. | Наваанын Бадрах | — Мөн аймгийн Тагшийн төвийн нүүрсний уурхайн дарга |

| | |
|---|---|
| 23. Хавтгайн Оноорой | — Завхан аймгийн Сантмаргац сумын эрчим хүчний салбарын механикч |
| 24. Буян-Өлзийн Сүрэнжав | — Мөн аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн дулааны станцын дарга |
| 25. Бадбарын Таран | — Мөн үйлдвэрийн механикч |
| 26. Дорждэрэмийн Батчулуун | — Өвөрхангай аймгийн Баянтээгийн нүүрсний уурхайн экскаваторчин |
| 27. Цэрэндоржийн Борхүү | — Өмнөговь аймгийн Тавантолгойн нүүрсний уурхайн жолооч |
| 28. Алтангэрэлийн Жаргал | — Мөн уурхайн краз машины жолооч |
| 29. Мядагмаагийн Сэдномдаржаа | — Мөн уурхайн өрөмдөгч, тэсэлгээчин |
| 30. Гомбын Баярцангэл | — Өмнөговь аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн засварчин |
| 31. Жигмэдийн Ахатвасүрэн | — Сүхбаатар аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн цехийн дарга |
| 32. Сандагийн Базсан | — Сэлэнгэ аймгийн мод боловсруулах комбинатын дэргэдэх дулааны станцын дарга |
| 33. Цэдэнгийн Гармаа | — Мөн аймгийн Хүдэрийн дулааны станцын мастер |
| 34. Ойдовын Даваа | — Төв аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн монтёр |
| 35. Лувсангийн Сэдэд | — Мөн үйлдвэрийн механикч |
| 36. Тогоочийн Цэвэгмид | — Мөн үйлдвэрийн засварчин |
| 37. Ромоодойн Дэвээ | — Увс аймгийн Хартаргатайн нүүрсний уурхайн бульдозерчин |
| 38. Дүмбээгийн Хорхой | — Мөн аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн инженер |
| 39. Дэнзэнгийн Танк | — Ховд аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн механикч |

40. Галбадрахын Галтбадрал — Хэнтий аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн механикч
41. Дугарын Төмөр-Очир — Мөн үйлдвэрийн Мөрөнгийн дулааны цахилгаан станцын засварчин
42. Жигзэгийн Мөнхөр — Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын эрчим хүчний салбарын механикч
43. Занатын Ренчиндорж — Мөн аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн мастер
44. Базаргурийн Сандагхорол — Мөн үйлдвэрийн механикч
45. Дэлгэрдалайн Чимэддондов — Мөн аймгийн Хурхын дулааны цахилгаан станцын ахлах инженер
46. Пунцагийн Түшиг — Мөн аймгийн Чандган талын нүүрсний уурхайн тэсэлгээчин
47. Дарийн Пүрэв — Дархан хотын дулааны цахилгаан станцын цехийн дарга
48. Хэлтэрийн Ундгаа — Мөн станцын засварчин
49. Дашдэндэвийн Энхбиш — Мөн станцын лаборант
50. Чойнхорын Болд — Мөн хотын дулааны станц, шугам сүлжээний газрын слесарьч
51. Сүхийн Дэлгэр — Мөн газрын дарга
52. Содномын Хонхүү — Мөн газрын засварчин
53. Буянзагийн Мижид — Дархан-Сэлэнгийн шугам сүлжээний газрын монтёр
54. Хорлоогийн Сосорбазар — Мөн газрын жолооч
55. Дамирангийн Баяннамсрай — Шарын голын нүүрсний уурхайн хэсгийн дарга
56. Оюбын Дагвадорж — Мөн уурхайн дарга
57. Гэндэнгийн Хасбаатар — Мөн уурхайн ерөнхий механикч
58. Дорводхааны Жаахан — Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн экскаваторын машинч

59. Ахамжавын Сандаг — Эрдэнэт хотын дулааны цахилгаан станцын засварчин
60. Данзангийн Төмөрбаатар — Мөн станцын монтёр
61. Даваацэрэнгийн Хүрлээ — Мөн станцын цехийн дарга
62. Олзвойн Ганбаатар — Эрдэнэтийн цахилгаан шугам сүлжээний газрын инженер
63. Зандраагийн Алтансүх — Багануурын дулааны станцын засварчин
64. Очирын Баянгол — Багануурын нүүрсний уурхайн мастер
65. Пунцагийн Хуягдорж — Мөн уурхайн хэсгийн дарга
66. Норжинхандын Чулуунбат — Мөн уурхайн шатахууны эрхлэгч
67. Нямбарын Баярсайхан — Налайхын нүүрсний уурхайн комбайны машинч
68. Галдангийн Пүрэвдорж — Налайхын дулааны станцын мастер
69. Тахиагийн Батсүх — Улаанбаатарын II цахилгаан станцын монтёр
70. Норовын Цэдэндамба — Мөн станцын инженер
71. Өлзий-Утасын Адилбиш — III цахилгаан станцын мастер
72. Батсүхийн Бордух — Мөн станцын цехийн дарга
73. Жоншингийн Жамсран — Мөн станцын ерөнхий нягтлан бодогч
74. Балдангийн Очбадрах — Мөн станцын лабораторийн эрхлэгч
75. Чойжилдоржийн Сумъяа — Мөн станцын орлогч дарга
76. Шагдарсүрэнгийн Уранбилэг — Мөн станцын техникч
77. Цэрэндуламын Цэнд-Аюуш — Мөн станцын инженер
76. Чилхаажавын Дулмаа — IV цахилгаан станцын лаборант
79. Батмөнхийн Ирэхбаяр — Мөн станцын токарьчин
80. Тунгалагийн Очир — Мөн станцын ахлах машинч
81. Хавхарваагийн Очирбат — Мөн станцын инженер
82. Зундуйн Базарсүх — Дулааны шугам сүлжээний газрын инженер

83. Гэлжидын Гончиг — Мөн газрын засварчин
84. Ануударийн Дашдондог — Цахилгаан шугам сүлжээний газрын монтёр
85. Дагдангийн Уртнасан — Мөн газрын жолооч-монтёр
86. Батмөнхийн Нямжав — Эрчим хүчний тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын үйлдвэрийн тохируулагч
87. Ендонгийн Дэлгөөн — Мөн үйлдвэрийн тохируулагч
88. Жамцын Мөнхтогоо — Төвийн эрчим хүчний системийн эрчим хүчний тоног төхөөрөмжийн засвар сэлбэгийн үйлдвэрийн засварчин
89. Тасрангийн Адъяа — Эрчим хүчний барилга угсралтын трестийн монтёр
90. Лхамсүрэнгийн Ганболд — Мөн трестийн мастер
91. Сандагийн Дэлгэр — Мөн трестийн конторын дарга
92. Дашийн Чойжамц — Мөн трестийн мастер
93. Жамбын Доржсамба — Дизель зуухны угсралт засварын газрын мастер
94. Шушмаагийн Нацагдорж — Мөн газрын мастер
95. Төмөрийн Базардаргиа — Автомашин, механизмын баазын жолооч
96. Найдангийн Базарсад — Мөн баазын жолооч
97. Дуламын Батсуурь — «Нүүрс» компанийн ахлах мэргэжилтэн
98. Дугарийн Цэдэн — Мөн компанийн ерөнхий нягтлан бодогч
99. Гомбын Чимэддорж — Мөн компанийн мэргэжилтэн
100. Сейтийн Съезд — «Эрчим импекс» компанийн ерөнхий захирал
101. Өндгөний Буянцог — Төвийн эрчим хүчний системийн инженер
102. Дамбын Бямбажав — Мөн системийн инженер
103. Цэндажавын Очирням — Мөн системийн ерөнхий нягтлан бодогч
104. Гүрийн Халзан — Улаанбаатар төмөр замын эрчим хүч, ус хангамжийн нэгдсэн ангийн мастер

| | | |
|---|---|---|
| 105. | Чойнгийн Дашдорж | — Уурхайн барилгын трестийн хяналтын дарга |
| 106. | Жанцандоржийн Сосор | — Эрхүү хотод суугаа түлш, эрчим хүчний яамны төлөөлөгч |
| 107. | Галсанцэвээлийн Өлзийбат | — Түлш, эрчим хүчний яамны түшмэл |
| 108. | Цэдэнбалжирын Сэдбазар | — Мөн яамны албаны дарга |
| 109. | Зулын Хаянхярваа | — Мөн яамны албаны дарга |

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1992 оны 12 дугаар сарын 26-ны өдөр — Дугаар 174 — Улаанбаатар хот

## СҮХБААТАРЫН ОДОНГ ЭРГҮҮЛЭН ОЛГОХ ТУХАЙ

1. Монгол Улсын Дээд шүүхийн бүгд хурлын 1992 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 90 дүгээр тогтоолын нэгдүгээр заалтыг үндэслэн Дорноговь аймгийн Мандах сумын иргэн Жамбал овогтой Чимэдготовт Сүхбаатарын одон, үнэмлэхийг эргүүлэн олгосугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1982 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 143 дугаар зарлигийн «Жамбал овогтой Чимэдготов» гэснийг хассугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр — Дугаар 1 — Улаанбаатар хот

### ЗАРИМ ХҮНД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Бөхийн самбо барилдааныг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж, тив, дэлхийн аварга шалгаруулах болон олон улсын бусад тэмцээнд удаа дараа спортын өндөр амжилт гаргасныг нь үнэлж бөхийн самбо барилдааны улсын шигшээ багийн дасгалжуулагч Галсанжамцын Пүрэв-Очирт Монгол Улсын спортын гавьяат дасгалжуулагч цол, тамирчин Ганхуягийн Үүрцолмонд Монгол Улсын гавьяат тамирчин цол тус тус олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч — П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр — Дугаар 2 — Улаанбаатар хот

### ЗАРИМ ХҮНД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж, дуу, хөгжмийн урлагийг хөгжүүлэх, түүний урын санг баяжуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь өндөр үнэлж Ардын армийн

«Дайчин алдар» чуулгын удирдагч, хөгжмийн зохиолч Шагжийн Гунаажавт Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол, Ардын армийн дуу, бүжгийн чуулгын гоцлол дуучин Гончигийн Жанчивт Монгол Улсын гавьяат жүжигчин цол тус тус олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
**ЗАРЛИГ**

| | | |
|---|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар 3 | Улаанбаатар хот |

## ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа нь үнэлж доор дурдсан хүмүүсийг Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

*Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор:*

1. Долгорын Сандагсүрэн — Ардын армийн жанжин штабын үлгэр жишээ үлээвэр хөгжмийн эрдэлэх багш
2. Чадраабалын Тууд — Ардын армийн дуу, бүжгийн чуулгын гоцлол дуучин
3. Дэмбэрэлийн Жаргалсайхан — Мөр чуулгын хөгжимчин

*Алтан гадас одонгоор:*

1. Доржийн Болдбаатар — Ардын армийн жанжин штабын үлгэр жишээ үлээвэр хөгжмийн хөгжимчин

2. Гэндэвийн Ахгваа — Ардын армийн дуу, бүжгийн чуулгын хөгжимчин

*Цэргийн хүндэт медалиар:*

1. Балжирцогтын Болдхайч — Ардын армийн дуу, бүжгийн чуулгын дуучин
2. Жамъянгийн Баатарсүрэн — Мөн чуулгын дуучин
3. Түнэравийн Нацсал-Ордон — Мөн чуулгын бүжигчин
4. Цэдэндоржийн Энхдаваа — Мөн чуулгын бүжигчин

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр — Дугаар 4 — Улаанбаатар хот

## З. ГОНЧИГЖАВЫГ СҮХБААТАРЫН ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Хөдөө аж ахуйн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх болон ашиг шим сайтай мах-өөхний чиглэлийн «Үзэмчин» үүлдрийн хонь бий болгоход оруулсан хувь нэмрийг нь үнэлж Хөдөө аж ахуйн их сургуулийн багш Загдын Гончигжавыг Сүхбаатарын одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар 5 | Улаанбаатар хот |

# ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж, өндөр ашиг шимтэй шинэ үүлдрийн мал бий болгоход хөдөлмөрийн амжилт гаргасныг үнэлж доор дурдсан хүмүүсийг Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

*Сүхбаатарын одонгоор:*

Самбуугийн Дугаржав — Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн секторын эрхлэгч

*Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор:*

1. Гэлэгийн Мандал — Увс аймгийн үржил селекцийн станцын мэргэжилтэн
2. Дэмзэнгийн Эрдэнэ — Мөн аймгийн Малчин сумын ерөнхий мал зүйч асан (тэтгэвэрт)
3. Пүрэвдагвын Авирмэд — Дорнод тал нутгийн бүсийн хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан асан (тэтгэвэрт)

*Алтан гадас одонгоор:*

1. Гончигсүрэнгийн Баасанхүү — Говь-Алтай аймгийн Бугат сумын хонины үржлийн фермийн мал зүйч
2. Даваажавын Балжинням — Мөн сумын малчин
3. Чойндонгийн Дашдэлэг — Мөн аймгийн үржил селекцийн станцын мэргэжилтэн

4. Жамцрын Ойдовын Бор — Сүхбаатар аймгийн Түмэнцогтын «Ураншх» компанийн мал зүйч
5. Нямаарын Мөнхөө — Мөн аймгийн Эрдэнэцагаан сумын малчин
6. Бадарчийн Ноост — Увс аймгийн Зүүнговь сумын мал зүйч
7. Кламдааны Түвшин — Мөн аймгийн Малчин сумын малчин
8. Чүлтэмийн Арилдий — Хүнс, хөдөө аж ахуйн яамны мэргэжилтэн

*Хөдөлмөрийн хүндэт медалиар;*

1. Готовын Батаа — Баянхонгор аймгийн «Байдрага» компанийн малын бага эмч
2. Намбуугийн Чүлтэм — Мөн компанийн мал зүйч
3. Оршихын Халтар — Говь-Алтай аймгийн Бугат сумын малчин
4. Лхамжавын Самлан — Мөн сумын малчин
5. Далайн Янжмаа — Мөн сумын малчин
6. Өлзийбаярын Мүүхүү — Мөн аймгийн Цээл сумын малчин
7. Сүрэнгийн Эрдэнэчимэг — Дорнод талын бүсийн хөдөө аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн секторын эрхлэгч
8. Дамбийнямын Айлтгүй — Дорнод аймгийн Сумбэр сумын мал зүйч
9. Дагдангийн Дорж-Очир — Сүхбаатар аймгийн Түмэнцогт компанийн мал зүйч
10. Батаагийн Эрдэнэцогт — Увс аймгийн Малчин сумын үржлийн фермийн эрхлэгч
11. Дашаагийн Алтангэрэл — Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
12. Доржпаламын Чулуунбаатар — Хүнс, хөдөө аж ахуйн яамны мэргэжилтэн

**Монгол Улсын Ерөнхийлөгч** П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар 6 | Улаанбаатар хот |

## ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Барилга засварын нэгдсэн трестэд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлж доор дурдсан хүмүүсийг Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

*Алтан гадас одонгоор:*

1. Баатарын Баярмаа — Улаанбаатар хотын барилга засварын нэгдсэн трестийн бригадын дарга
2. Гончигийн Мягмар — Мөн трестийн барилгын техникч
3. Тугалын Мягмар — Мөн трестийн инженер-хүйн засагч

*Хөдөлмөрийн хүндэт медалиар:*

1. Гонгоржавын Бор — Мөн трестийн бригадын дарга
2. Дамбийн Бавуусүрэн — Мөн трестийн аж ахуйн нэгжийн дарга
3. Шагдаржавын Баярсайхан — Мөн трестийн засалчин
4. Шаравын Жавзан — Мөн трестийн засалчин
5. Балганы Баянбаатар — Мөн трестийн сантехникийн бригадын дарга
6. Дэхлэвийн Ганболд — Мөн трестийн засалчин

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар 7 | Улаанбаатар хот |

### Ч. БАТСҮХИЙГ ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Барилгын машин, механизмын баазад олон жил үр бүтээлтэй ажилласныг нь үнэлж Чимэдийн Батсүхийг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

**Монгол Улсын Ерөнхийлөгч** **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар 8 | Улаанбаатар хот |

### Б. БАЗАРРАГЧААГ ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Төс улсын банк, санхүүгийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлж Монгол даатгал банкны дэд захирал Балбарын Базаррагчааг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

**Монгол Улсын Ерөнхийлөгч** **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар 9 | Улаанбаатар хот

## Б. БАНЗРАГЧ, С. БАЯНДАЙ НАРЫГ ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Худалдааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, сүүлийн жилүүдэд ажлын тогтвортой амжилт гаргаж байгааг нь үнэлж Бөөний худалдааны компанийн дэд захирал Ваанжилын Банзрагч, нярав Суранзаагийн Баяндай нарыг Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч — П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1993 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар 10 | Улаанбаатар хот

## Д. ЭНХЖАРГАЛЫГ ШУДАРГА ЖУРАМ МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Усны аюулаас хүний амь аварч иргэний хүмүүнлэг үүргээ нэр төртэй биелүүлснийг үнэлж Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын «Сэлэнгэ» компанийн ажилчин Доржхандын Энхжаргалыг Шударга журам медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч — П. ОЧИРБАТ

# СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛӨӨС УНШИГЧИДДАА СОНОРДУУЛАХ НЬ

Эрхэм хүндэт уншигчид аа!

«Төрийн мэдээлэл» сэтгүүлийн 1993 оны анхны дугаар Таны гар дээр очиж байна. Төр, засгийн бодлого шийдвэрийг голлон сурталчилж Улсын Их Хурлаас батлан гаргаж буй хууль, тогтоол, Ерөнхийлөгчийн зарлигуудыг бүрэн эхээр нь уншигчдад хүргэдэг цорын ганц хэвлэл болох—«Төрийн мэдээлэл» сэтгүүл энэ оноос эхлэн нийтлэлийн бодлогодоо нэмэлт өөрчлөлт оруулахаар тогтов.

Манай сэтгүүл дугаар бүртээ Улсын Их Хурлаас батлан гаргаж буй хууль, тогтоолыг тайлбарласан хуульч, эдийн засагч зэрэг өндөр мэргэжлийн хүмүүсийн өгүүллийг *«тайлбар»* буланд нийтэлж байх болно. Түрчлэн уншигчдын хүсэлтээр энэ дугаараас эхлэн Улсын Их Хурлын Байнгын хороодын тухай танилцуулга, Улсын Их Хурлын гишүүдийн мэдээг «Улсын Их Хурлын үйл ажиллагаанаас» буланд нийтэлж байна. Мөн шинээр *«Ярилцлага»* хэмээх байнгын буланг сэтгүүлч Т. Баасансүрэн эрхлэн хөтөлж явуулна. Энэ дугаарт түүний бичсэн «Цахиагийн Элбэгдорж алтан хараацай мөн үү?», «Мэндийн Зангаа хүнд сурталтан гэж үү?» гэсэн хоёр ярилцлагыг нийтлэв.

Манай сурвалжлагч Улсын Их Хурлын бусад гишүүдтэй нэгбүрчлэн уулзаж ярилцан улс эх орныхоо тухай тэдний санаж бодож, сэдэж бүтээж байгаа зүйлс, цөөнгүй тохиолдолд тэдний эрхэлсэн ажил, хувийн амьдралын нарийн ширийнийг өөрийн сэтгүүлийн уншигчдад үргэлжлүүлэн өгүүлэх болно. Энэхүү сонирхолтой бөгөөд санаа авууштай цуврал ярилцлагыг уншигч та зөвхөн манай сэтгүүлээс л уншиж болох тул «Төрийн мэдээлэл» сэтгүүлээ өргөн олон нийтэд таниулж, өөрөө дугаар алдалгүй захиалж авахаа мартуузай. Тус сэтгүүлд нийтлэгдсэн болон хэвлэгдэж амжаагүй бусад ярилцлагыг нэгтгэж оны эцэст *«Далан зургаан ярилцлага»* хэмээх нэн сонирхолтой товхимлыг «Төрийн мэдээлэл» сэтгүүлээс өөрийн захиалагчиддаа тусгай нэмэлт дугаар болгож бэлэг болгон барихаар төлөвлөж байна. Үүнээс гадна Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаас хийсэн сурвалжлагын сонирхолтой нийтлэлийн дугаарыг бэлтгэхээр төлөвлөж буйг уншигчиддаа сонордуулахад таатай байна.

Эрхэм уншигч авгай нараас манай сэтгүүлд цөөнгүй захидал ирдэг юм. Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Байнгын хорооны дарга нар болон Улсын Их Хурлын гишүүд. Тамгын га-

зарт хэдэн арав, хэдэн зуун захиа ирж байна. Тэдгээрийг түүвэрлэж «Төрийн мэдээлэл» сэтгүүлийн *«Захидал хэлэлцэх»* буланд нийтэлж байх болсныг уншигчиддаа мэдээлье.

«Төрийн мэдээлэл» сэтгүүл уншигч Таны дуртай хэвлэлийн нэг болно гэдэгт бид итгэж байна. Сэтгүүлийн талаар өөрсдийн санал бодлоо манай редакцид ирүүлж бичээрэй.

## «ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ» СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

*Улсын Их Хурлын үйл ажиллагаанаас*

## ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ, ДЭД БҮТЦИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО ЮУ ЭРХЭЛДЭГ ВЭ?

Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хороо нь Улсын Их Хурлын хуулийн дагуу Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлэх зохион байгуулалтын нэгжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус байнгын хороо үндсэн ба туслах нийт 17 гишүүнтэй. Үүний 6 нь үндсэн гишүүн бөгөөд тэдгээрээс доктор 2, дэд эрдэмтэн 2, МҮАН-ын гишүүн 1, бусад нь МАХН-ын гишүүд юм. Гишүүдийн дундаж нас 47 байна.

Байнгын хороо нь Монгол орны эдийн засгийн амьдралд дүн шинжилгээ хийж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар баримтлах төрийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээртэй холбогдох эрх зүйн үндсийг тогтоох, биелэлтэд нь хяналт тавих чиг үүрэгтэй ажиллаж байна.

Монгол орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн нэгдсэн бодлогын хүрээнд тус улсын эдийн засгийн үндэсний хөгжлийн үзэл баримтлал, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, өмчийн бүх сектор болон хүн амын нийгмийн хөгжлийн нөхцөлийг хангах, бүх нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, шинжлэх ухаан, технологийн бодлого, гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, эдийн засгийн чөлөөт бүсийн бодлого, зам, тээврийн нэгдсэн сүлжээ, барилга, хот байгуулал-

тын бодлого, түлш, эрчим хүч гэх мэт үйлдвэрлэлийн дэд бүтцийн оңцлогууд зэрэг олон асуудлыг хамарч байна.

Шилжилтийн үеийн хямрал, бэрхшээл, эдийн засгийн уналтыг зогсоон тогтворжуулах, зах зээлийн харилцаа үүсэн бүрэлдэх нөхцөлийг хангахад тус байнгын хороо нэлээхэн анхаарч байна. Энэ талаар тус байнгын хороо 1993 онд шударга өрсөлдөөнийг дэмжих, дангаар ноёрхлыг хязгаарлах, хэлцлийн, аж ахуйн нэгжүүдийн тухай, өмч хувьчлалын, гадаадын хөрөнгө оруулалт, эдийн засгийн чөлөөт бүсийн тухай, статистикийн тухай, архитектур, хот байгуулалтын тухай зэрэг хуулийг шинээр буюу шинэчлэн батлуулахаар бэлтгэж байна.

Хувийн секторыг хөгжүүлэх, түүний эдийн засагт гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, төрөөс тодорхой хугацаанд дэмжин туслах, түүнтэй холбогдох эрх зүйн үндсийг тогтоох нь тус байнгын хорооны нэг чухал үүрэг болж байна.

Байнгын хороо хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар Түлш, эрчим хүчний яам, Худалдаа үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээвэр, холбооны яам, Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, дүгнэлт гаргах, санал зөвлөмж өгөх, мөн тухайн салбарт ажиллах чадвартай удирдах боловсон хүчнийг шилж сонгох, томилох, чөлөөлөх асуудалд санал дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх эрхээ хэрэгжүүлж байна.

Байнгын хороонд иргэд, байгууллагаас ирсэн хүсэлт, саналыг шуурхай шийдвэрлэх, шинээр ба шинэчлэн боловсруулах зарим хуулийн төслийг хөдөлмөрчдөөр хэлэлцүүлэх, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг сурталчлах, хууль боловсруулах чиглэлээр судалгаа, шинжилгээ тогтмол хийхэд анхаарч байна.

Ажил төрлийн холбоотой яам, газар, түүний харьяа байгууллага, орон нутагт ажиллах, сонгогчидтойгоо уулзах, тэдний санал хүсэлтийг авах, шийдвэрлэх явдал тус байнгын хорооны гишүүдийн ажлын чухал хэсэг болно.

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА, ЭДИЙН ЗАСГИЙН УХААНЫ ДОКТОР Г. ЦЭДЭНДАГВА

# ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ, ДЭД БҮТЦИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ҮНДСЭН ГИШҮҮДИЙН НАМТАР

## *РАВДАНГИЙН ЦАГААНХҮҮ*

1933 онд Өмнөговь аймгийн Ханбогд сумын 4 дүгээр багийн нутагт төрсөн. Малчин гаралтай, халх үндэстэн.

Бага сургууль, хөдөө аж ахуйн техникум, эдийн засгийн дээд сургууль төгссөн. Мэргэжлийн эдийн засагч. Эдийн засгийн ухааны доктор.

Бага наснаас мал маллаж, мөн галч, цэвэрлэгч зэрэг ажил хийж байгаад 1953 оноос эдийн засгийн мэргэжлийн чиглэлээр улсад хөдөлмөрлөж эхэлсэн байна.

Дээд сургууль төгссөнөөс хойш Монгол Улсын төлөвлөгөөний төв байгууллагад мэргэжилтэн, орлогч даргын ажлыг нийтдээ 8 жил хийжээ. Тус улсын хөдөө аж ахуйн яаманд орлогч, нэгдүгээр орлогч сайдын үүрэгт ажлыг 14 жил, МАХН-ын Төв Хороонд хэлтсийн эрхлэгчээр 5 жил ажиллаж байсны зэрэгцээ олон улсын эрдэм шинжилгээний байгууллагад таван жил ажилласан. Улсад нийтдээ гуч гаруй жил хөдөлмөрлөсөн 1992 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогджээ.

## *ТАУХЕЙН СУЛТААН*

1944 онд Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын нутагт төрсөн. 1956 онд мөн сумын бага сургуулийг, 1962 онд Өлгий хотын нэгдүгээр 10 жилийн дунд сургуулийг төгсөөд Улаанбаатар хотод эдийн засгийн дээд сургуульд элсэж 1966 онд төгссөн байна. Худалдааны эдийн засагч мэргэжилтэй. МАХН-д 1966 онд элссэн.

1981 онд эдийн засгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан. Эрдэм шинжилгээний нэг сэдэвт зохиол 2, өгүүлэл 60, уран зохиолын 4 ном (хоёр роман, өгүүллэг, туужийн ном) туурвисан байна. МЗЭ-ийн гишүүн.

Дээд сургууль төгссөнөөс хойш Архангай аймагт Худалдаа бэлтгэлийг удирдах газрын дарга, орлогч, Худалдаа бэлтгэлийн яаманд мэргэжилтэн, Улаанбаатар хотын худалдаа, нийтийн хоолны удирдах газрын нэгдүгээр орлогч дарга, дарга, нийслэл хотын МАХН-ын хорооны хэлтсийн эрхлэгч, Сүхбаатарын районы намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, 1988 оноос Баян-Өлгий аймгийн МАХН-ын хорооны хоёр, нэгдүгээр нарийн бичгийн даргаар тус тус ажиллаж байв.

1992 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогджээ. Түүнийг хөдөлмөр зүтгэлийг төр улсаас үнэлж Алтан гадас одон, олон медалиудаар шагнажээ. Ах дүү долуулаа. Эхнэр Казармина Мачий багш мэргэжилтэй. Олон жил багшилж байгаад 1992 онд тэтгэвэрт гарчээ.

## ГҮРЖАВЫН ЦЭДЭНДАГВА

Г. Цэдэндагва 1946 онд Баянхонгор аймгийн Баян-овоо сумонд төрсөн. 1955—1959 онд тус сумын бага сургуулийг, 1959—1962 онд аймгийн төвийн 10 жилийн сургуулийн 7-р ангиг төгссөн. 1962—1965 онд Улаанбаатар хотын Санхүү эдийн засгийн техникумд суралцаж хөдөө аж ахуйн нягтлан бодогчийн мэргэжлээр, 1968—1973 онд Монгол Улсын Их сургуульд суралцаж аж үйлдвэрийн инженер-эдийн засагчийн мэргэжлээр дүүргэсэн. 1972 онд МАХН-д гишүүнээр элссэн. 1979—1932 онд ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны академийн аспирантурт суралцаж, эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн, улмаар 1990 онд «Монголын эдийн засгийн өөрчлөн байгуулалтад аж үйлдвэрийн гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх нь» сэдвээр докторын зэрэг тус тус хамгаалсан байна.

1965—1966 онд Баянхонгор аймгийн нэгдсэн дундын үйлдвэрт нягтлан бодогч, 1966—1968 онд Батлан хамгаалах яамны ёдлын үйлдвэрт нягтлан, 1973—1990 онд МАХН-ын Төв Хорооны дэргэдэх намын дээд сургууль ба Улсын Их Хурлын дэргэдэх улс төрийн дээд сургуульд багш, секторын эрхлэгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1990—1992 онд Баянхонгор аймгийн Ардын хурлын тэргүүлэгчдийн гүйцэтгэх захирганы даргаар тус тус ажиллаж байв. 1992 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон. Одоо Улсын Их Хурлын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хорооны даргын үүрэгт албыг хашиж байна.

Эхнэр, 4 хүүхдийн хамт амьдардаг.

## ЖУГДЭРИЙН ДЭЛГЭРЦЭЦЭГ

Ж. Дэлгэрцэцэг 1946 онд Завхан аймгийн Ургамал суманд төрсөн. 1969 онд ЗХУ-ын Киев хотноо хөнгөн үйлдвэрийн дээд сургуулийг төгсч, механик-инженерийн мэргэжил эзэмшсэн байна.

1972 онд МАХН-д гишүүнээр элсчээ. 1969—1971 онд Улаанбаатарын хивсний баримга захиалагчийн газар механикч, 1971—1977 онд Улаанбаатарын хивсний үйлдвэрт ерөнхий механикч, ерөнхий инженер, 1977—1980 онд ноос, нэхмэлийн үйлдвэрийн дарга, 1980—1992 он хүртэл Эрдэнэтийн хивсний комбинатын даргаар тус тус ажиллаж байв.

1992 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон.

Эхнэр, 3 хүүхдийн хамт амьдардаг.

## ТҮВДЭНГИЙН ОЧИРХҮҮ

Т. Очирхүү 1948 онд Говь-алтай аймгийн Шарга суманд төрсөн. 1972 онд ЗХУ-ын Ленинград хотын Улсын их сургуулийг эдийн засагчийн мэргэжлээр төгсчээ. 1976 онд МАХН-д гишүүнээр элссэн. 1980 онд ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн ухааны академийн аспирантурт суралцаж төгссөн байна.

1972—1975 онд Улсын төлөвлөгөөний комиссын үнийн хороонд мэргэжилтэн, 1975—1977 онд Үнэ, стандартын эрдэм шинжилгээний институтэд секторын эрхлэгч, 1980—1990 онд МАХН-ын Төв Хорооны боловсон хүчин, эдийн засгийн хэлтсүүдэд зааварлагч, улмаар Нийгэм, эдийн засгийн хөгжлийн улсын хороонд газрын даргаар ажиллаж байв. 1990—1992 онд Улсын Бага Хурлын байнгын хорооны даргаар ажиллаж байсан. 1992 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогджээ.

Эхнэр, 2 хүүхдийн хамт амьдардаг.

## *ДАВААДОРЖИЙН ГАНБОЛД*

1957 онд Улаанбаатар хотод төрсөн. Халх. МҮАН-ын тэргүүн. 1974 онд Москвагийн 127 дугаар дунд сургууль төгсч 1974 оны 9-р сард Москвагийн улсын их сургуульд орж 1979 оны 7 дугаар сард эдийн засагч мэргэжлээр төгссөн байна. 1979 оны 9 дүгээр сараас Монгол Улсын их сургуульд улс төр, эдийн засгийн ухааны багшаар ажиллаж байгаад 1984 оны 10 дугаар сараас 1987 оны 12 дугаар сар хүртэл Москвагийн улсын их сургуулийн аспирантурт суралцаж дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. 1988 оны 2 дугаар сарын 1-нээс 1990 оны 9 дүгээр сарын 5 хүртэл Улс төрийн дээд сургуульд багшилсан байна. 1990 оны Ардын Их Хурлын сонгуульд Ардын Их Хурлын 5 дугаар тойргийн депутатаар сонгогдож улмаар Улсын Бага Хурлад (Төрийн байгуулалтын байнгын хороонд) орж ажиллажээ. 1990 оны 9 дүгээр сард Улсын Бага Хурлаас Засгийн газрын тэргүүн шадар сайдаар томилогдож 1992 оны 8 дугаар сар хүртэл уг албан тушаалд ажилласан байна. 1992 онд Хэнтий аймгаас Улсын Их Хурлын гишүүнээр сонгогджээ. 1990 оны 5 дугаар сараас МҮДН-ын зөвлөлийн даргаар сонгогдон ажиллаж байгаад 1992 оны 10 дугаар сарын 22-нд МҮДН-ын II их хурлаар намын зөвлөлийн даргаар дахин сонгогдсон байна. 1992 оны 10 дугаар сарын 25, 26-нд Ардчилсан намуудын нэгдсэн их хурал болж Монголын Үндэсний Ардчилсан Нам байгуулагдаж, МҮАН-ын тэргүүнээр сонгогджээ.

1990—1992 онд Засгийн газрын тэргүүн шадар сайдын үүрэгт ажил гүйцэтгэж байхдаа Улсын өмч хувьчлалын комиссын дарга, Засгийн газрын гадаадын зээл тусламж зохицуулах комиссын дарга, Монгол, Зөвлөлтийн Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн дарга зэрэг ажлыг хавсран гүйцэтгэж байв.

Эхнэр Оюун нь гадаад хэлний дээд сургуульд багш, охин Булган 11 настай, дунд сургуулийн сурагч. Охин Мишээл 2 настай.

Д. Ганболд загас барих, дугуй унах, марк, жижиг машины модель цуглуулах их сонирхолтой.

*Ярилцлага*

## МЭНДИЙН ЗЭНЭЭ ХҮНД СУРТААЛТАН ГЭЖ ҮҮ?

*— Сүүлийн хоёр жилд монголчуудын улс төрийн идэвх ихэд сэргэжээ. Улс төрийн давалгаан үүссэн гэхэд хилсдэхгүй биз. Түүнд өртөгдөөгүй хүн бараг үгүй байх. Тэр дотроос Та монголын улс төрийн амьдралд бүр ч гүнзгий хутгалдсан. Үүний учир шалтгаан юунд байна?*

— Энэ нь Монгол оронд өрнөсөн ардчилалтай шууд холбоотой. Олон ургальч үзэл, хүний эрхийн тухай анх хөндөхөд миний бие эргэлзэх зүйлгүйгээр түүнийг дэмжсэн нэгэн. Анхны цуглаан, жагсаалд алдалгүй очиж, залуусын хэлж ярихыг сонсдог байлаа. Санаа нь маш сайхан юм. Зөв замаар яваасай гэж хүсч байв. Миний бие тэднээс нэлээд хэдэн оймс илүү элээсний хувьд бусад улс орны ардчиллын замналыг бага сага ч гэсэн гадарладаг байсан. Эдийн засгийн өндөр хөгжил, ухамсартай сахилга бат, зохион байгуулалтад тулгуурлаж ардчиллыг хөгжүүлсэн улс орон түргэн хөгждгийг бар болсон улсуудын түүх бэлээхнээ харуулчихсан тийм үед Монгол оронд ардчиллын салхи сэвэлзэж эхэлсэн юм. Тэрхүү зүйл тогтлыг умартаж ядуу эдийн засгаа уландаа гишгэчиж, ард түмнийхээ хөлс хөдөлмөрөөр бүтээж бий болсон бүхнийг үгүйсгэж, өнгөрсөн үеэ басамжлан доромжлох нь утга учиргүй хэрэг байлаа. Манай ардчилал эхнээсээ туйлшрах хандлага руу хальтран орох вий гэж эмээж байв.

*— Олон ургальч үзэл бодол дэлгэрсэн үед янз янзын бодол санаа байхыг үгүйсгэх аргагүй.*

— Тийм ээ. Олон ургальч үзэл үнэхээр хэрэгтэй. Энэ бол маш том ололт. Хэрэв тиймгүй байсан бол Мэндийн Зэнээ ч өнөөдөр ингэж зоригтой ярьж чадахгүй л байсан. Тэгэхдээ хэт туйлшрахыг зөвтгөж бас болохгүй. Хэн нэг нь өөрийн үзэл бодлыг үнэмлэхүй үнэнд тооцож бусдад тулгах эрхгүй. Бусдын санаа бодлыг үл ойшоож доромжлох нь зохисгүй. Янз бүрийн үзэл бодол байж л байг. Уралдаг!

Тэгээд аль амьдрах чадвартай нь ялж гараг. Цаг хугацаа аяндаа л шүүгээд өгнө. Жишээ нь, социализмын тухай үзэл бодол байна. Энэ бүхэл бүтэн цогц үзэл санааг чинь хүн төрөлхтөн өөрөө бий болгож үе үеийн шилдэг ухаантнууд өөрсдийн санаа бодлоо нэмэрласэн юм шүү дээ. Социализмыг гажуудуулсан тухайд бол огт өөр ойлголт. Харин тэр үзэл са-

наанд итгэдэг хүмүүсийг буруутгаж, тэднийг хоцрогсод гэж шоовдорлож болно гэж үү! Олон үргальч үзэл бодолд энэ чинь нийцэхгүй шүү дээ.

Нэг л хүүхдийн нулимсан дээр тогтож байгаа бол тэр нийгмийг би хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй гэж та бидний сайн мэдэх нэг ухаантны хэлсэн үг бий. Нэг ч болсон хүнийг мөлжиж, тэрхүү мөлжлөг дээр тулгуурлан хөгжиж байгаа нийгмийг би хувьдаа хүнлэг, ардчилсан, иргэний нийгэм гэж үзэхгүй байна. Социализмыг эцсийн энэрэнгүй зорилгын нь хувьд би хүнлэг, ардчилсан, иргэний нийгэм байх ёстой гэж болдог. Хүн хүн өөрийнхөөрөө ойлгодог байх л даа.

— *Хүнлэг, ардчилсан, иргэний нийгэм байгуулах тухайд бол бараг бүх нам, эвсэл, хөдөлгөөн санал нийлж байх шиг санагддаг. Түүнд хүрэх, хэрэгжүүлэх арга нь харин өөр өөр байж болох юм.*

— Хүнлэг нийгмийг хүнлэг чанараар нь хэмжинэ. Хөгжил дэвшлийнх нь эхлэлээр ч тандаж болно. Монгол Улсыг муу ч, сайн ч дөчин жил удирдаад хүний нутагт насан өөд болсон Ю. Цэдэнбал гуайг эх оронд нь нутаглуулахаар авчрах үед зарим хүн юу гэж хашгирч байлаа. Түүхийн хүнд эргүүлэг, цагийн хүчин зүйлсэд хувь заяаны эрхээр осорлогдсон тэр хүн алтан дэлхийд амьд явсны эцэст эх орныхоо алгын чинээхэн газарт шингэж үлдэх эрхгүй байсан гэж үү! Энэ чинь монгол заншил юм уу? Ханийнхаа хорсон цогцсыг эх нутагт нь оршуулахаар уй гашуу болж ирсэн авгайг урдаас нь мэнд усыг нь мэдэж уулзахын оронд эрүү үүсгэн хэрэгт татах гэж төрийн нэрийн өмнөөс хүрч очдог чинь хүнлэг ёсонд хэр зэрэг таарч нийцэж байна вэ? Хүний эрхийн тухай ярьж чаддаг атлаа хэрэгжүүлж чадахгүй байгаагийн илрэл биш үү?

Хүнлэг нийгэм байгуулах гэж анхны алхмыг хийж байгаа биз дээ, бид чинь. Анхнаасаа л алдаж эхэлбэл юунд хүрэх билээ. Өмчийн олон хэлбэрийг адил тэгшээр хүлээн зөвшөөрнө гэж тунхагласан. Гэтэл байдал өнөөдөр ямар байна. Ганцхүү хувийн өмчийг бурханчлан шүтээд өмчийн бусад хэлбэрийг, ялангуяа улсын өмчийг улаантан үзсэн адил шоовдорлож, дайрч давшилж, нураах дэвсэлж байна. Энэ бүхнийг чинь дув дуугүй хараад амандаа ус балгачихсан юм шиг суугаад байж таарахгүй. Эргэцүүлж бодсоны эцэст ард түмэндээ хандаж үгээ хэлэхээс өөр аргагүй болсон. Улс төртэй хутгалдаж эхэлсний учир энэ гэж хэлж болно.

*— Шаниад нь багагүй юм дуулж, нилээ хэлмэгдүүлж байна уу. Та ч Монгол даяар «нэрд» гартлаа «хараалгаж», бас «ерөөлгөж» явах шив дээ. Санаа сэтгэлээр унтарч тунь дах уу? Гэр оршихон, төрөл төрөгсдөд чинь нэг ч их сайхан байдалгүй байлгүй.*

— Хүн амьд явах эрхтэй. Хөдөлмөрлөх эрхтэй гэцгээдэг. Тэдгээрээс дутахгүй өөр нэг эрх бол үзэл бодлоо илэрхийлж үгээ хэлэх эрх юм. Та түүн эмзэг дүйлийг надаас асуулаа. 1990 оны дундаас 1991 оны сүүлч хүртэл би байнгын заналхийлэлд өртөж сэтгэлийн дарамтад байсан. Үл мэдэх хүмүүс утсаар «Чамайг устгана», «Хол дайралдсан газарт чинь ална» гэж занаж сүрдүүлдэг байлаа. Эхний үед холбоонд хэлж гүйж гуйвшиж үзсэн. Ямар утаснаас ярьж байгааг олж мэдэх санаатай, тэр хүмүүстэй уулзаж нүүрээрээ уулзаж учрах бодолтой сурагласан хэрэг. Хүлээж авлагүй. Хүний эрхийн асуудал. Хэлж өгөхөө аль хэдийнээ больсон шүү дээ гэж хариулсан даа.

Мэдээж авгай, хүүхэд юунд баярлах билээ. Үг хэл таталсан энэ хэрэггүй «хэрүүлээ» орхиж үз гэж гуйцгаасан. Муу ээж минь л хамгийн их айж эмээж сэтгэл түгшсэн дээ. Одоо ч ялгаагүй, битүү шаналгаатай л явна. Амин хувиа хичээж, хар цагаан хэл аманд өртөхөөс айвал би улс төрийн бүлэглэлүүдэд нүүр алдахгүй, хэн хэнд нь ая тал засаад хэл ам татлагагүй явж болох шүү дээ. Ингэж чадсангүй. Эх орондоо би хайртай. Монголын ард түмний төлөө цохилох зүрх миний цээжинд бий. Би ард түмэн, эх орноороо ямагт дутна. Харин Монгол Улс надаар дутахгүй. Ингэхлээр үнэнийг нуулгүй хэлэхээс л өөр аргагүй болсон.

*— Үл мэдэх хүмүүсийн сүрдүүлэг, заналхийлэл 1991 оны сүүл хүртэл үргэлжилсэн гэж Та хэллээ. Одоо ямар үү, намжсан юм бол?*

— Энэ бас учиртай. «Хэрэв миний энэ нас үргэлжвэл энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд хоёртой холбоотой» гэсэн утгатай зүйл бичээд гурап хувилж тус бүрийг П. Очирбат, Д. Бямбасүрэн болон Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газрын даргад хүргүүлэв. Үүний дараахан Ерөнхий сайд Д. Бямбасүрэн намайг хүлээн авч уулзаж бүтэн 2 цаг гучин минут ярилцсан. Ярианы тэмдэглэл нь энэ. (төмөр шүүгээнээсээ 6 хуудас зүйл гаргаж ирэв. Эл ярианы тухай урьд нь хэвлэлд нийтлэгдээгүй тул уншигчдад сонин байж болзошгүй гэсэн сэтгэлийн үүднээс зөвшөөрөлтэйгээр бүрэн эхээр энд сийрүүлэв) Үзэж болно шүү.

**1991 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 14.00 цагаас 16.30 цаг хүртэл Ерөнхий сайд Д. Бямбасүрэнтэй М. Зэнээ уулзахдаа ярьсан зүйлийн протокол**

Дэргэд МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Н. Багабанди, Засгийн газрын референт генерал Нацагдорж нар байв.

Д. Б: — Зэнээгийн бичсэн мэдэгдлийг уншлаа. Надад 3 зүйл санагдлаа.

1. Орос, буриад, хасаг, хятадын эрлийз гэж үндэстэн ястнаараа бүлгэрхэж, төрийн сүлдэн дээрээ бие зассан уу? гэдэг дээр бодмоор байсан юм биш байгаа.

2. Амь насанд чинь үнэхээр аюул учраад байна уу? гэдгийг тодруулмаар байна.

3. Энэ бүхнийг төр, засгийн удирдлага дахь тодорхой хүмүүс хүлээнэ гэж хэнийг хэлж байна гэдэг дээр санал солилцмоор байна.

НЭГ, М. З: — Мэдэгдэл биш, мэдээлэл юм шүү. Ялгаж ойлгох биз ээ.

Орос, хасаг, буриад, хятадын эрлийз гэдэг үгийн хувьд бүх ястан, үндэстнийг биш эрлийз хүмүүсийг, хоёрт бүгдийг биш тодорхой хүмүүсийг, монголыг монголд нь дайсан болгодог хүмүүсийг хэлж байгаа юм.

Монгол улс олон мянган жилийн түүхийг туулахдаа дотроо задарч, бие биенээ үгүйсгэж, эв найрамдалгүй явж ирснээс энэ олон монголд хуваагдсан нь Манж, хятадын «нэг бүдүүлгийн гарт могой бариулж, нөгөө бүдүүлгийг захирах» бодлоготой холбоотой. Энэ бодлого одоо ч ил далд хэлбэрээр урсан орж ирсээр байна. Үүнийг хэрэгжүүлэх гэсэн нууц гар, хол шинэ нөхцөлд шинэ баг өмсөж гарч ирээд 2 сая монголыг дотор нь хагалж бутаргаад 2—300 нам, янсэл холбоонд хуваагаад байхад та бид эх орон, ард түмнийхээ төлөө юу харж, юу бодож, юу хийж яваадаа дүгнэлт хийх болсон юм биш байгаа. Буриадын холбоо, хасагийн холбоо, дөрвөдийн холбоо гээд элдэв холбоо гарч ирж хэний төлөө, эсвэл хэний эсрэг юу хийх гэж байна гэдгийг ч бодох хэрэгтэй болсон биш үү.

Д. Б: — Буриадын холбоо гэж байхгүй байх. Харин Буриадын соёлын холбоо гэж бий байх. Би мэдэхгүй.

М. З: — Ямар ч нэртэй байсан Буриадын холбоо бодитой байгаа нь та бидэнд тодорхой биш үү. Өнөөдөр эдийн засгийн өндөрлөг хэний гарт шилжиж байна. Улс орны улс төрийн

тусгаар тогтнол алдагдах аюул нүүрлэж байгаа юм биш үү! Монгол-Зөвлөлтийн найрамдлыг хэн ийм байдалд хүргэж байна, н. П. Очирбат, Д. Бямбасүрэн та хоёр Монгол-Зөвлөлтийн найрамдлын асуудлаар бүтэн жил гаруй өлигтөй үг хэлэхгүй, бусад түрэмгий нөхдийг чимээгүй өөгшүүлж ирлээ.

Саяхан МАХН-ын Төв Хорооны гишүүд та хоёрыг хүчтэй шүүмжилснээр та хоёр депутатын бүсийн зөвлөлгөөн дээр найрамдалд үнэнч байдгаа харуулах гэж оролдсон байх аа.

Д. Б: — Миний бүтэн жил энд тэнд ярьсан зүйлийг Зөвлөлт эргэж үзээрэй. Би энэ найрамдлын төлөө ярьдаг.

М. З: — Улс түмний найрамдлыг ард түмэн бусниулдаггүй. Тодорхой удирдах нөхөд л бусниулдаг шүү. Хятад ямар нөхөр болохыг бид мэдне, Өвөг дээдэс минь захиж гэрээслэж өгсөн одий төдий захиас гэрээс бий шүү. Өвөг дээдэс минь ухаан муутайдаа ЗХУ-тай ойртуулж орхиогүй гэдгийг монгол хүн бүр бодох ёстой.

Өнөөдөр эдийн засгийн өндөрлөг хэний гарт шилжиж эхэлж байгааг ард түмэн маань харж байгаа байх. Эдийн засгийн хувьд тусгаар тогтнолоо алдвал улс орны тусгаар тогтнолыг алдах аюултайг та ойлгох байлгүй дээ.

Монголын баруун хэсгийг таслах, Гурван голын сав бол Хасагийн уугуул нутаг гэж ярьж баталдаг хасаг хүмүүс хэний хүчээр өдий болчихоод, хэний төлөө, хэний эсрэг ажиллаж байгааг олон түмэн ойлгох байх аа.

Төрийн сүлдэн дээр бие засч, түмний эхээ машинаар дайрч, төрхгүй хүүхдээр төр засагт айл гэр болгон тоглуулж байгааг хэн өөгшүүлж байна вэ?

Д. Б: — Төрийн сайдынхаа машиныг дайрч гэж бас хэлмээр байна. Р. Гончигдоржийн машиныг дайрч эвдлээ.

М. З: — Улс төрийн хүчний залуус дотор сайн залуус, ухаалаг залуус бий. Бид тэдэнтэй уулзаж учирч явдаг. Залуусын эх орноч сэтгэлийг өндөр нэр, албан тушаал олж авах хэрэглүүр болгон ашиглаж байгаа хуучин дарга нарын удам сударт ард түмнээр тоглохыг би зөвшөөрөхгүй байна. Хоёрхон сая хүнийг ингэтэл нь бужигнуулж байж өөрчлөлт хийх ямар албатай юм бэ? Тайван тогтуун хийж явсан болдоггүй юм бэ. Энэ бүхнийг төр, засгийн удирдлагын хүмүүс явсаад бодохгүй байна. Төр нь төр шиг чанга, хуулийн өмнө бүх хүн тэгш эрхтэй байх ёстой биш үү. Танхайрагчдыг хэн өөгшүүлж байна гэдгийг ч бодох л ёстой.

Д. Б: — Э. Бат-Үүл Засгийн газар өөрт юу хийх гэж байна гэж орж ирж асуугаад мэдэж аваад дараа нь Засгийн газар тийм ч юм хийхгүй байна, ийм ч юм хийхгүй байна гэж шүүмжилж, сонин хэвлэлд бичээд эцэст нь бидний шаардлагаар хийсэн гэж оноо авдаг болдоо. Би саяхан Америк явахдаа сүүдрийн засгийн бага хувилбар хийж явсан. Үүнийг Э. Бат-Үүл ард хойно өмнө нь хэдэн юм залгаад өөрийн нэрээр МоЛХ-ны үзэл баримтлал болгон «Ардчилал» сонинд хэвлүүлсэн. Д. Ганболд, Э. Бат-Үүл нар хоорондоо эвдэрч над дээр орж ирсэн. Бат-Үүл юу хийх гэж байна гэхээр Ганболд чи сонин дээрээ хуулаад бичдэг гээд хэлж чадаагүйгээс болсон юм билээ. Бид одоогоос хойш цус урсахыг тойрч өнгөрөөлөө. Олон хүн мөргөлдөөнд дуудсан, хүссэн.

М. З: — Ард түмнээ мөргөлдөөнд турхирдаг хариуцлагагүй этгээд гарч ирээд хашгираад байна. Үүн дээр бодлоо анзаарч байгаа биз дээ. Ард түмэн бол хэн дуртай хүний тоглоом биш шүү.

Д. Б: — Зоригоо Засгийн газрын ордны цонхоор бие зассан нь үнэн юм шиг байна билээ.

М. З: — «Үнэн» юм шиг биш. Үнэн юм.

Д. Б: — Хуулийн байгууллага шийдэх байх.

М. З: — МАХН-ыг муулах хараах нэрийн дор өнгөрсний хүмүүсийн алдааг өнөөдрийн бидэнд хүлээлгэх ёсгүй. Ю. Цэдэнбал, тойрон хүрээлэгчидтэй тооцоо хийдэг юм байгаа биз. Жирийн намын гишүүдийг дайрч доромжлохыг зөвшөөрөхгүй байна.

Д. Б: — Та намын ахмад туршлагатай хүн. Асуудалд бүүрэлтэй хандана биз.

М. З: — Би МАХН-д элсээд жил гаруй болж байгаа шинэ хүн. Гэхдээ өвөг дээдэс минь уламжилж үлдээсэн энэ нам, түүний жирийн гишүүдийг удирдлагаас салгаж ойлгодог. Намайг хуучинсаг, Цэдэнбалын гар хөл гэж хэлэх ёсгүй байх аа.

Ер нь улс орны удирдлагад ардын, эвгэй, эд мөнгөнд эрүү татагдаагүй байсан нас намба суусан, улс төрийн ноён нуруутай тухайлбал, тан шиг насны хүн байх ёстой байх. Хүүхэд тоглоод байдаг төр, насагтай ард түмэн байх ёсгүй. Үлдсэн хэдэн насаа эх орон, ард түмэндээ зориулчих «монгол» хүн байх нь зүйтэй болов уу гэж боддог.

Д. Б: — Намууд хоорондоо эвсэж ажиллах явдал их чухал байна. МҮДН, МоАН хоёр МАХН-тай эвсэж чиг барьж байгаа.

М. З: — Эх орон, ард түмний төлөө эвсэж ажиллахыг хүсэхгүй хэн байх билээ. Гэхдээ МАХН, түүний гишүүдийг дайрч доромжилж, «Ард түмний дайсан» болгон зарлаж, коммунистуудтай тэмцээ дуусгах тухай ярьж, өнгөрсөн алдаа гажуудлыг өнөөдрийн хүмүүст тохох нь аль хэр зөв юм бэ? Ийм неофашист хүнийг хэн өөгшүүлж байна вэ? Биднийг хэлдэн аргаар дайрч доромжилсон үгээ буцааж, уучлалт гуйвал эвсэж болохгүй яахав.

Д. Б: — Буруугаа хүлээнэ гэвэл МАХН-д хүлээх буруу их бий. Ингэвэл тохирохгүй байх аа.

М. З: — Буруугаа хүлээх чадваргүй бол эвсэж ажиллах чадвар ч дутна.

Д. Б: — МАХН хүлээх олон буруугаа лах вэ?

М. З: — Цаг үеийн нь хүмүүс цаг үед нь хүлээх, тэр алдааг нуулахдаа биш түүнээс бид суралцах ёстой. Өчигдрийн алдааг өнөөгийн жирийн гишүүдэд хүлээлгэх ёсгүй. МАХН ямар шүү байсан, яаж явж байсан. Ёс суртахууны ялзралд удирдах хүмүүс нь хэрхэн орж байсныг МАХН хүлээсэн, засч залруулж байгааг бид мэднэ. Бид үүнд бусдын адил дургүй байсан. Энэ бүх буруугаа засч залруулах ажилд ороод байгаа нь юу буруу билээ. Буруугаа бид хүлээх ч ёстой. Засах ч ёстой. Улс төрийн ямар ч хүч байсан бид зөв ажиллавал дэмжинэ. Буруу байвал МАХН-ыг ч шүүмжилнэ. Эх орон, ард түмэндээ хайртай эрүүл саруул хүч үнэхээр байдаг юм бол өнөөдөр ард түмнийг ингэж бужигнуулах ёсгүй.

ХОЁР. М. З: — Амь насанд халдах тухай сүрдүүлэг бүтэн жил гаруй явж байна. Энэ ганц М. Занаагийн асуудал биш. Хөдөлмөрийн баатар Намхайнямбуу 8 хүүхэдтэй нь алнa гэснийг та бид их хурал дээр чихээрээ сонссон. Энэ тухай Ерөнхийлөгчид бичиж, одоо нэг хувь нь тэр хүнд байгаа байх. Ямар арга хэмжээ авсан бэ? Л. Түдэв рүү дайрч, авгай хүүхдийг нь хэлмэгдүүлж, ШУА-ийн дэд ерөнхийлөгч, боловсон хүчний хэлтсийн даргыг барьцаанд авч, эрх чөлөөнд нь халдсан. Ямар арга хэмжээ авсан бэ? Данзанг алнa хэднэ гэж утасдаж, албаны утсыг нь Д. Сүх-Эрдэнэ тасалсныг, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгийн шагналыг нь төр, засаг хассаныг юу гэж үзэх вэ? Танхайчууд улс төрөөр тоглож болдог юмуу? Нэг хэлмэгдүүлэлтийг нөгөө хэлмэгдүүлэлтээр сольж болох уу?

Д. Б: — Данзан бол алтны асуудлыг эхэлсэн хүн. Улсын төсвөөс их хэмжээний бэлэн мөнгө хүнд зээлүүлсэн. Худлаа

мөнгө бичиж баик нээсэн. Хууль шударга бол Данзан шийтгэл хүлээх ёстой.

ГУРАВ. М. З: — Хуулийн өмнө бүх хүн тэгш эрхтэй байхыг ардчилал гэдэг болохоор хэн буруутай бол тэр шударгаар шүүгдэх нь зөв биз ээ. Хууль зөрчигчид, завшуулагчид олширох хандлагатай байгаа нь ч нууц биш ээ. Ардчилал, олон ургальч үзэл, хүний эрх гэж ярьж гарч ирээд өөр үзэл бодлыг хавчиж гадуурхаж, амыг нь таглах гэж оролдох, айлган сүрдүүлэх оролдлого хийж байгаа учир амь насаа хамгаалуулах, улс төрийн хэлмэгдүүлэлт хийх оролдлогыг зогсоохыг төр, засагт хүсэлт болгож байна. Хоёрхон сая хүнийг бужигнуулахгүй, бужигнуулах оролдлого хийж байгаа тодорхой нөхдөд хариуцлага тооцохгүй дураар авирлуулж байгаагийн цаана хэн байгааг олон түмэн гадарлах биз ээ. Хууль нь хууль шиг, төр нь төр шиг байгаасай гэж хүсч байна. Генерал Нацагдорж гуай намайг хамгаалалтандаа авах биз ээ.

Д. Б: — Улс төрийн хүч болж янз бүрийн юм гарвал амь нас хариуц! гэсэн үг үү. Хувийн аюулгүй байдлаа хамгаалж өгөөч! гэж байгаа юм уу?

М. З: — Би улс төрийн хүчний зарим удирдах нөхөд шиг өндөр нэр, албан тушаал хөөцөлдсөн бэртэгчин биш. Надад албан тушаал хэрэггүй. Ганцхүү ард түмэндээ үнэнийг хэлэх ёстой гэж ойлгосон жирийн ядуу малчин айлын хүүхэд. Төр, засгийн эсрэг тэмцэж тушаал суудал булаацалдагч биш гэдгийг ойлгох биз ээ. Миний хувьд төр, засгаа бөхжүүлэх тухай хаана ч өчсөн ярьж явдаг. Гэхдээ ард түмний төлөө байгуулагдсан төр, улс төрийн ашиг хонжоо хайгчдын тоглоомын талбар болох ёсгүй гэж ойлгодог.

Энэ бүх эмх замбараагүй байдлыг хэн өөгшүүлж байгааг олон түмэн хэлэх биз гэж бодож байна гэснээр харилцан бие биедээ талархаж яриа төгсөв. Ярианы талаар Н. Багабанди, генерал Ш. Нацагдорж нар товч тэмдэглэв.

*Ярианаас зарч ирээд товч тэмдэглээд хөтөлсөн* — *М. ЗЭНЭЭ*

*Ярианд суусан МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга* — *Н. Багабанди*

*Засгийн газрын референт, генерал* — *Ш. Нацагдорж*

*— Сонин яриа болжээ. Улс төр рүү сүрхий хутгалдсаны нэг ноцолгоо галтай. Тэгэхдээ л би нэг зүйлийг асуумаар санагдсаад байна. Та бол эрдэмтэн хүн. Эрдэм шинжилгээнийхээ ажлыг хөөцөлдөвөл хэл амгүй гэлдэрч явсан бол хамаагүй дээр байсан биш үү?*

— Эрхэлж ирсэн эрдэм шинжилгээний ажилд маань нэг өвөрмөц онцлог бий. Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө амь хайргүй тэмцэгчдийн түүхийг би олон жил судалж байна. Манлайбаатар Дамдинсүрэн, чин ван Ханддорж, ардын Хатанбаатар Магсаржав, аймшиггүй чин зоригт Дамдины Сүхбаатар, Тогтох тайж, Ану хатан, Чингүнжав, Амарсанаа, Галдан бошигт... Монголын төлөө бие сэтгэл, амь насаа зориулсан энэ хүмүүсийн сэтгэлийн их тэнхээ, хатамжит тэвчээрийг бишрэвч барахгүй. Өвөг дээдсийн үүх түүхийг судлан сэтгэл татагдах тусам тэднээс бидэнд үлдээсэн хамгийн эрхэм зүйл-улс орны тусгаар тогтнол, ард түмний бие даасан байдлын төлөө тэмцлийн үзэл санаа яс, маханд улам бүр нэвт шингэдэг юм. Тэрхүү нөөс урван тэрсэлж огт болохгүй.

*— Та бид хоёрын яриа улс орны тусгаар тогтнолын тухай ойлголт руу гулсчихлаа. Тэгэхлээр жаахан түнэгийрүүлж хойд, урд хөрштэйгээ ямар байдлаар харилцах, тэрчлэн бусад улс оронтой тогтоосон найрамдалт хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэх асуудлаар өөрийн чинь бодлыг сонсвол сонин байхсан.*

— Болноо. Өвөг дээдсийн маань тэмцлийн түүх бол өмнөд, хойт хөрштэйгөө харилцаагаа зохицуулахын төлөө хийсэн шударга тэмцэл байсан юм шүү гэдгийг хэлмээр байна. Дэлхийн хамгийн том хоёр улстай Монгол Улс хил залган оршиж байгаагаа хэзээ ч мартаж болохгүй. Ард түмнүүдийн харилцааны олон зууны уламжлал байна. Түүнийг анхааралтай судлан сургамж авах ёстой. Орос, Хятадын ард түмэнтэй эрх тэгш найрсаг харилцааг эрхэмлэвэл зохилтой. Тэдний дотоод асуудалд хондлонгоос хошуу дүрэн дургүйг нь хүргэх хэрэггүй. Хэл амаа олдоцож сайн хөршийн харилцааг хөгжүүлэхээс эрхэм зүйлгүй. Ардчиллын давалгаанд хөөсөрч, архи уусан мэт согтож явахдаа зарим маань Орос ахыг хэлэх, хэлэхгүй үгээр шоовдорлож доромжилсон нь бий. Гомдоосон доо. Тэрнийхээ шанг хүртэж л байна. Та нарт бид хэрэггүй бол ялаа гээд л буцаагаасан. Тэдний орон зайг өнөөдөр хэн дүүргэж байна вэ гэдгийг эрүүл саруул ухаанаар эргэцүүлэн бодох л хэрэгтэй болно. Хоёр аваргын дунд оршдог хоёрхон сая монголчуудад хувь заяаны тэрлэг зовлон гаж бий. Үүнийг өвөг дээдэс маань машид на-

райвчлан тооцоолж тэнцвэрт харьцааг эрхэмлэж байжээ. Эхлээд хоёр хөрштэйгээ эхэлж тэнцвэрт харилцааг хөгжүүлэхийн хамт гурав дахь түрний ашиг сонирхлыг Монголд бий болгох ёстой болов уу. Энэ бол зайлшгүй. Америк, Япон, Английн ч юмуу ашиг сонирхлыг Монголын газар нутаг дээр бий болгож тогтворжуулах ёстой. Тэгэж байж сая тэнцвэрт харилцааны тухай ойлголт бүрэн утгаараа илэрнэ. Улс орны тусгаар тогтнол ч бэхжинэ. Хөгжил дэвшлийн түргэн замд шилжинэ. Улс орны удирдлагын жолоог барилцаж байгаа хүн бүр үүнийг сайтар ойлгосон байх хэрэгтэй.

*— Улсын Их Хурлын гишүүний хувьд Та ч тэдний нэг болж таарна. Ер нь анх нэрээ яах гэж дэвшүүлсэн юм бэ?*

— Улсын Их Хурлын гишүүн болчихно гэж үнэндээ би бодож явсангүй. 1990 оны сонгуульд депутатаар нэрээ дэвшүүлнэ үү гэж тавал газраас хүссэн. Зөвшөөрөөгүй. Сонгууль болоод өнгөрсөн. Хүн ардын итгэл найдварыг хүлээж депутат болсон хүмүүсийг харсан чинь зарим нэг нь итгэмээргүй байсныг нуух юун. Даанч дээ гэмээр ганц нэг хүн төрийн төлөөлөгч, ард түмний элч нэр зүүчихээд хүн хүн өөр үсчиж дураар дургиж эхэлсэн.

Тэгэхэд л би сая улс төрөөс ухарч болдоггүй юм байна. Улс орноороо ч тоглуулж болзошгүй юм байна гэдгийг ойлгосон. Ийм учраас дараагийн сонгуульд орохоос татгалзах үндэс байгаагүй. Намын Төв Хороо надад эхэлж санал болгосон. Энд тэнд нэг бус газраас миний нэрийг дэвшүүлсэн юм байлээ. Ингэж л Улсын Их Хурлын гишүүн болсон юм. Дарга даамал болж машин тэрэг унья гэсэндээ биш ээ. Эх орон, хүн ардынхаа төлөө өчүүхэн биеийг зориулъя гэсэндээ Улсын Их Хурлын гишүүнд нэрээ дэвшүүлсэн юм. Төв аймгийн 32 мянган хүн миний төлөө саналаа өгсөн. 65,4 хувийн санал авсан санагдана.

*— Сонгогчдынхоо захиа даалгаврыг яаж биелүүлж байна даа. Тэдэнтэйгээ уулзаж учирдаг уу?*

— Улс орныг хямралаас аль болох түргэн хугацаанд хохирол багатай гаргах нь шинээр сонгогдсон Улсын Их Хурал, Засгийн газрын эн тэргүүний зорилт. Үүний тулд Улсын Их Хурлын гишүүний үүргээ биелүүлэх ёстой гэж бодож зүтгэж явна. Энэ бол сонгогч олон түмний маань захиас шүү дээ. Улсын Их Хурлын гишүүн болсноос хойш сонгогчидтойгоо 3 удаа очиж уулзлаа. Илэн далангүй ярилцдаг. Чанартай сайн хууль гаргаж, сахилга, зохион байгуулалтыг бэхжүүлэх шаард-

лага их тавьдаг. Удахгүй Улсын Их Хурлын намрын чуулган завсарлана. Тэр үеэр сумдаар явах бодолтой. Төр, засгийн бодлогыг тайлбарлана. Улс төржүүлж хэт туйлшралгүй, улс орныг эдлэв үймээн бужигнаангүйгээр сайн сайхан замд нь оруулахад хүн бүрийн хүчин зүтгэл, хувь нэмэр хэрэгтэй биз ээ. Үндэсний эрх ашгийг нэгдүгээрт тавих ёстой. Аль нэг намын явцуу эрх ашгийг урьтал болгож болохгүй.

*— Нам тэхээс Таныг МАХН-ын хуучныг баримтлагч талын хүн гэж бичиж, ярилцах нь бий. МАХН-ыг шинэчлэхэд хувь нэмэр оруулж байна уу?*

— Тийм хаяг надад зүүгээстэй байдаг юм. МАХН-ыг учир зүггүй хамгаалагч гэдэг. Би энэ намын сайн, мууг аль алиныг нь мэднэ. МАХН-д элсэх гэж арван жил хүсэлт гаргаад элсэж чадаагүй, ардчиллын эхэн үетэй золгосон гэдгээ Танд хэлбэл итгэх болов уу. Удирдах дарга нараа шүүмжилчихдэг «ужиг» өвчинтэй байснаас болсон гэж боддог. Намын Төв Хороонд хүртэл өргөдөл бичээд бараагүй юм.

ЗХУ-д өөрчлөн байгуулалт эхэлж, шинэчлэлийн уур амьсгал Монголд урсан орж ирсний ачаар 1989 онд би МАХН-д элссэн билээ. Өргөдөлдөө «социализмын бүтээн байгуулалтын тэргүүн эгнээнд бусдыг үлгэрлэн манлайлна» гэж бичээгүй. Харин «МАХН-ыг дотроос нь шинэчлэх гэж элсэж байна» гэдгээ тов тодорхой хэлсэн. Тэр үйлсэд хүчин зүтгэж явла. МАХН шинэчлэгдэж байна. Тэгэхдээ удаавтар байна. Алдаж буй зүйл ч байна.

*— Дотроос шинэчилнэ гэсэн тэр үгнээс чинь айж болгоомжлоогүй юу?*

— Асууж давлаж, эргэлзэж тээнэгэлзэж байсан шүү. Сүхбаатарын дүүргийн намын хороон дээр бол бүр эмзэглэж байсныг сайн санаж байна. Тэгэхдээ л өөрчлөлт манай оронд нэгэнт айлчихаад байсан. Үг хэлж болдог болоод байлаа.

*— Өөрчлөн байгуулалтыг Монгол оронд хэн эхлүүлсэн юм бэ? Ардчиллыг авчрагчдыг талархдаг уу?*

— Ардчиллыг ард түмэн өөрсдөө эхэлсэн гэж хариулмаар байна. Мэдээж ЗХУ, дорнод европт болсон өөрчлөлт нөлөөлсөн. Монгол Улсын сүүлийн 70 жилийн түүхэн он жилүүд хүмүүсийг үүнд бэлтгээд байсан юм. Хүн амын соёл, боловсролд гарсан их өөрчлөлт, ялангуяа бүхэл бүтэн залуу үеийг европын улс оронд сургаж бэлтгэсэн нь ийм хорс дэвсгэрийг бий болгожээ. Монголд ардчиллыг цөөхон хүн хэрэгжүүлсэн. Тэд бол алтан хараацайнууд гэж сүүлийн үед ярьж бичих боллоо. Түүх

үнэнээрээ байх шиг сайхан юм байхгүй. Ардчиллыг Монголд МАХН-ын дэвшилт хүчин эхлүүлсэн юм. Тэр дотроос «Үнэн» сонины гүйцэтгэсэн үүргийг цохон тэмдэглэх ёстой. Яагаад ч юм өнөөдөр үүнийг зарим нь мартахыг хүсч байна. Сэтгүүлчид их үүрэг гүйцэтгэсэн юм шүү. Анхны мэсийг эхэлж задах үед дув дуугүй явсан улс, үүрнээсээ ч цухуйгаагүй хүмүүс алдар гавьяаг өмчлөх гэж оролдвол муухай. Хүмүүсийн хийж бүтээснийг хоцрохгүйгээс оролцож хувьдаа завших болохгүй. Өнгөрсөн түүхээ хараар будаж, өөрсдийгөө цагаанаар ялсан «алтан хараацай» нарыг би хүлээн зөвшөөрөхгүй.

Үйл явцыг түргэвчлүүлэхэд нөлөөлж, нэг бус тохиолдолд санаачилгыг гартаа авч эр зориг гаргасан гэвэл өөр хэрэг. Үүнийх нь төлөө хүндэтгэж болно. Их үйлсийг зөв эхэлж, зөв үргэлжлүүлэх ёстой. Үүн дээр алдаж байж мэдэшгүй. Ардчиллыг алдар нэр, албан тушаал, өмч хөрөнгө болгон хувиргаж болохгүй.

— *Урьд нь Та зөвхөн шүүмжлэгчийн байр суурингаас аливаа зүйлд хандаж байсан. Тэр нь тун амархан байсан байж болох юм. Өнөөдөр бол төр, засгийн цлирдлагыг хуваалцаж ачааны хүндийг үүрэлцэж явна. Хуваь нэмрээ хэрхэн яаж оруулж байна вэ? Монгол Улсын ойрын ирээдүйг хэрхэн төсөөлж байна?*

— Улс орноо хямралаас түргэн гаргахад хэшүүрэг болохуйц хуулиудыг Улсын Их Хурлаас баталж гаргаж зах зээлийн харилцаанд эргэлт буцалтгүй шилжих эрх зүйн үндсийг тавьж өгөх ёстой. Эдгээр хууль эрхийн актад өргөн олон түмний санаа бодол шингэсэн байвал улам нөлөөтэй болно. Ийм бодлын үүднээс Улсын Их Хурлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож санал бодлоо чөлөөтэй хэлж байна. Юуны өмнө эдийн засгийн бат бааз хэрэгтэй. Үүнийг хүн ямар ендөр соёл боловсрол, дээд зэргийн сахилга, зохион байгуулалтгүйгээр хэрэгжүүлж чадахгүй. Үндэсний эрх ашиг үүнийг шаардаж байгаа юм. Гэтэл ардчилал манайд буруу хөгжиж байна. Амаар хөгжиж байна. Ярьж хэлж, шүүмжилж чадаж байна. Ажил хийхгүй байна. Үйлдвэрлэлээ хөгжүүлж байж л улс орноо мандуулна. Наймаагаар хөгжлөг улс гэж байхгүй. Цөөн хэдэн хүний түрийвч л зузаарахаас цаашгүй. Харамсалтай нь Монгол Улс энэ замаар явж байна.

Өмнөх үеийнхнийхээ хийж бүтээсэн бүхнийг хайр найргүй нураах аянлад сэтгэлийн хөрлөөр орсны уршгийг өнөөдөр амсаж байна. Эдийн засгийн уналт бараг ядуурлын цэгтээ хүрээд байгаа бололтой. Ядаж ухаантай улсын үгийг сонсохгүй юм. Хийж бү-

залхан дээрээ нөмөр болсон зэмээр уриалгадуулна шүү гэж манай Ерөнхий сайдын дэргэд ажиллаж байсан хэсгийн [illegible] нэг бус удаа анхааруулсныг ч [illegible]согүй. Эсрэгээр нь хатууруулж байж эм-нээр гэж л хүлээсэн. Тэр [illegible] нутаг буцахдаа «монголчууд тоть шувуу гэж ярьдаг юм». Тэгэхээр бүх зүйл өнгөрөөгүй. Монголын ард түмний хувь заяа дутаа их юм. Сайн зохион бай-гуулж чадвал [illegible] 1994 оноос амьдрал сайжрах эхний шинж тэмдэг илэрч эхлэх ёстой.

Ард түмний сайн сэтгэлийг эрж олох шалгал маш чухал байна. Тэр, засагтаа итгэх итгэл, ажиллах урам зориг суулайг сулруулаад алдарсан. Үүнийг сэргээх ёстой. Хууль журмыг амьд-ралд хэрэгжүүлэх ёстой. Улсын Их Хурлаас сайн хууль гарч, Засгийн газар биелэлтийг сайн зохион байгуулахаас их зүйл шалтгаална. Улсын Их Хурлын үйл ажиллагаа удаан байна. Засгийн газар зогсонги түвшинд ажиллахгүй байна. Гэхдээ П. Жасрай өөр шонгүй, [illegible] хоосон суугаад барахгүй. Түүний баг жигд ажиллаж, гүйцэтгэх аппарат сайн тусах учиртай. Ерөнхийлөг-чөөс ч, Улсын Их Хурлаас ч гүйцэтгэх засаглал уяулах тус-ламж дутмаг байна.

*— Та ер нь дэмждэг шүүмжлэхээс үйлдэхгүй хүн юм аа. Шинэ жилийн уламжлал дээр улсын Ерөнхийлөгчийн хэлсэн үгийг «бут ниргэсэн» байна лээ. Түүнээс болж бас бөөхөн шүүмжлэлд өртсөн. Юунд итгэж ингэж хүчээр оролдож байдаг юм бэ?*

— Би хүнээр, тэр тусмаа Ерөнхийлөгчөөр оролддог хүн биш ээ. Хүнийх нь хувьд би П. Очирбатыг ч, Д. Бямбасүрэнг ч хүн-дэтгэнэ. Тадантай хувийн л өөр харилцдаг. Харин улс орны хувь заяатай холбоотой зарим асуудлаар үзэл бодол зөрөх удаа бий. Энэ бол огт өөр асуудал. «Дээрээ суудлаа олохгүй бол до-роо гүйдлээ олохгүй» гэсэн ухаант ардын [illegible] мэргэн үг бий. Хүн хичнээн ухаантай ч хэлэхээс нааш ухаарахгүй ч гэж ярилц-даг. Тийм учраас би хэлэхсэн бодсоноо ил хэлдэг.

Одоо бол тэр бариацаж байгаа торгийн түшээ хүний хувьд ярьдаг. Шударга ёсны талаа бид [illegible]. Тийм болохоор шударга бус шийдлийн дэргэдүүр дуугүй өнгөрөх эрх надад байхгүй. Тэгэх юм бол ард түмний итгэлийг хүлээсэн Их Хурлын гишүүн байх хэрэггүй. Ерөнхийлөгчийг шүүмжилсэн миний мэдэгда-лийн тухайд гэвэл би хэлэх л ёстой юмаа хэлсэн, үүргээ биелүүл-сэн гэж бодож байна. Ерөнхийлөгч ч гэсэн хүн. Алдаа гаргавал түүнд хэлж өгөх ёстой. Ард түмнээс дээд оршихуй удирдлага гэж үгүй. Ард түмний хэлж [illegible] байгаа зүйлийг л өөрийнхөө мэ-дэгдэлд илэрхийлж [illegible]. Өөр [illegible] байхгүй. Олон түмний

бухимдлыг ямар нэг хэлбэрээр илэрхийлсэн хэрэг. Үнэн л юм хэлсэн дээ. Дайрч доромжлоогүй юм. Хатуухан хэлсэн байж магадгүй. Гэхдээ доромжлоогүй. Улсынхаа ерөнхийлөгчийг нүцгэрсэн бар барьсан зогсож байгаагаар, эсвэл Ерөнхий сайдаа сармагчин болгоод зурж буйг «доромжлол» гэж үзэхгүй л байгаа шүү дээ. Тийм үү?

Дахин хэлье. Би П. Очирбат, Д. Бямбасүрэнг хүнийх нь хувьд хүндэтгэдэг. Улсын Их Хуралд суугаа Р. Гончигдорж, Д. Ганболд, М. Энхсайхан, Ц. Элбэгдорж нарыг ч мөн ялгаагүй. Зөв зүйтэй үг хэлэхэд нь баярлаж, буруудаж зөрүүдэж зүтгэвэл гомдохийг шүүдэг. Бид хоорондоо ээ тушаал хагарчихсан, хүний харилцааны эвлэршгүй зөрчилд орчихсон улс биш шүү. Зарим хүн инээж ойлгодог юм билээ. Манай залуу улс төрчдөд сүүлийн үед үнэн үг хэлдэг хүн хомсордсон. Харин дутагдлыг нь хаацайлж буруу руу хөөргөдөн турхирдаг нь олширсон. Энэ чинь л хүнийг эвдэнэ шүү дээ.

*— Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль ойртлоо. Ямар хүн улс орныг удирдаасай гэж боддог вэ?*

— Монгол Улс, монголын ард түмний нийтийн амьдралыг нэвтэрхий мэддэг хүн улсын Ерөнхийлөгч байх ёстой. Монгол ухаантай, монголын төлөө цохилох зүрхтэй халуун эх оронч, эрдэм мэдлэгтэй хүн л эв нэгдлийн илэрхийлэл, тусгаар тогтнолын бэлгэдэл болж чадна. Хувийн явцуу эрх ашгийг эгнэгт таягдан хаяад амь амьдралаа ард түмнийхээ төлөө бүрэн зориулж чадна гэдэг тухайн хүнээс тун их зүйл, хатан зориг шаардана. Албан тушаалд дуртай хүн хэрэгт осолдоно. Эдийн шуналтай бол заавал алдана. Архи дарсанд дурлаж, зугаа цэнгэл эргүүлдэг бол бүр ч тусгүй. Энэ бүхнийг огоорсон, эрдэм мэдлэгтэй, улс төрийн пөйн нуруутай, хүнлэг хүн Монголд цөөнгүй бий. Японы зэрэг ардчилал их хөгжсөн улс оронд нас тогтсон хүнийг зориуд улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдаар өргөмжилдөг нь хүн төрөлхтөний амьдралын ухаанаар шалгарсан нэгэн үнэн ч байж магадгүй юм шүү.

Шинэчлэгдэж байгаа, ардчилсан үзэлтэй хүн болох гэж цагийн аясад инээдүүлэн зүсээ хувиргаж жүжиглэдэг хүн нэгэн Ерөнхийлөгч байж таарахгүй. Тэгээд дээрээ суудлаа олохоо больж, дороо гүйлдэж олохгүй бужигнана. Ахиад л намайг шүүмжиллээ гэж битгий зэмлээрэй. 1992 оны хавар бидний хэсэг хүн Ерөнхийлөгч П. Очирбаттай уулзсан юм. Тэгэхэд би түүнд «хулигаануудыг дал мөрөн дээр алгадаж, эх орон, ард түмнийхээ хувь заяагаар тоглохоо болихгүй юу» гэж чин үнэнээсээ хэлж

байснаа мартаагүй байна. Иргэний ч, эр хүний ч хувьд би түүнд энэ үгийг хэлэх ёстой байсан. Ингэж боддог, ярьдаг атлаа өөрт нь хэлдэггүй улс зөндөө шүү дээ.

— *Тэнгэр их булуулсан хүн, хүнд сурталтны тэмцэгч гэж бичиж, ярьдгийг нуугаад яахав. Ингэж хэлсний минь уучлаарай. Өөрөө юу гэж бодсоныг сонсоход илүүдэхгүй биз ээ гэж бодсон юм.*

— Намайг дайрч дайшилдаг, гүтгэн доромжилж бичдэг улсад би гомдохгүй. Мэндийн Зэнээ байгаагүй байсан бол тэдний бичих сэдэв нэгээр дутах байсан биз ээ. Өнөөдөр чинь зах зээл шүү дээ. Сонинд «сонирхолтой» сэдэв хэрэгтэй. Сонин сэдвийг шүүрч авч бичсэн хүнд нь бол хэдэн бор төгрөг хэрэгтэй. Мэндийн Зэнээг бичих үү, үгүй юу гэж хүмүүс аль нэг сониныг эрж хайж байвал тэрхүү редакцийнханд тустай. Энэ утгаар ойлгох юм бол би багагүй буян үйлдэж байж ч мэднэ. Хэн нэгнийг хийх ажилтай болгож, мөнгө олох эх үүсвэрийг нь бүрдүүлээд зогсохгүй «нэр төрд» хүрэх үүд хаалга нээж өгч байгаа ч юм биш үү.

— *Цаг гаргаж ийм дэлгэрэнгүй ярилцсан Танд баярлалаа.*

— Зүгээр. Төр, Засгийн тогтоолын эмхтгэлийг түмэн олонд хүртээмжтэй нийтлэлээр байнгуулж сэтгүүл болгох гэж зорьж байгаа та бүгдийн ажилтай үйлс дэлгэрэх болтугай. Улсын Их Хурлын үйл ажиллагааны талаар хамгийн үнэн зөв мэдээлэл өгч, Их Хурлын гишүүдийг ард түмэнтэй холбох гүүр болж чадах «Төрийн мэдээлэл» сэтгүүл түмэн олонд үнэхээрийн буян үйлдэх болно шүү.

x x x

Мэндийн Зэнээгийн өрөөнөөс гарахдаа миний бие сүүлчийн асуултад маань энэ хүн юу гэж хариулчихав даа. Ороо бусгаа энэ цагийн түүхэнд олонд «алдаршсан» энэ хүн ямархуу байр суурьтай үлдэж хоцрох бол гэж эргэлзсэн бодол. Өөрөө тэртээ тайлсан ийм асуултаа хариулт олох гэж хүрэхийн өмнөх эрин хөгжлийн нэхэн саргаахыг хичээв. Тэгээд хэзээд ч юм

Хахуу газар хальтирч унадаг
Хазайж будрэхийн хий гараад
Ширүүхэн зэрлэгээс дальдирч байдаг
Шантарч халирахын золдон арилаад
Ачаа татсан ч зам сурамгүй
Арван хуруугны тамир гүйцээд
Айлд уригдсан ч хожимдоо гутрамгүй
Айраг найрын хэмжээг тааруулаад

Болшгүй омголон залуугийнхаа ширүүнд
Болохгүй үгийг хэлчихдэг минь цөөрөөд
Болгоомжгүй гэнэхэн сэтгэлийнхээ хөнгөнд
Болохгүй юмыг мөрөөддөг минь багасаад
Хэцүү хүнд үүрэг өгч гэмээ нь
Хийж чадна гэж түмэндээ үнэлэгдээд
Хэрэгтэй цаг болж гэмээ нь
Хэлээд байлаа гэж төрдөө итгэгдээд
НАС ТОГТОХ САЙХАН

гэсэн нэгэн алдарт шүлэгчийн цогт мөрүүд санаанд орж ирээд болохгүй байлаа.

Улаанбаатар, 1993 оны 1 дүгээр сарын 23.

## ЦАХИАГИЙН ЭЛБЭГДОРЖ АЛТАН ХАРААЦАЙ МӨН ҮҮ?

*— Сэтгүүлч хүн сэтгүүлчтэйгээ цуулж ярилцлага авна гэдэг сонин байна. Та өөрөө сэтгүүлчийн мэргэжлээр сургууль дүүргэсэн. Гэрхүү мэргэжлээ орхиж мэргэжлийн улс төрч болон хувирч байна уу? Сүүлийн үед бичиж нийтэлсэн зүйл чинь цөөрч эхэллээ.*

— Нэгд, сэтгүүлч мэргэжлээ орхиогүй гэдгээ хэлмээр байна. Хоёрт, улс төрийн амьдралд гүнзгий орох шаардлага аяндаа гарч ирсэн юм. Энэ нь миний өөрийн хүсэл бодлоос хамааралгүй. Нийгмийн амьдралд оролцож улс төрийн үйл ажиллагаа явуулахгүйгээр байж суухад бэрх тийм нөхцөл байдал бүрэлдэн бий болсон юм. Өөрөөр байж чадсангүй.

Аль нэг сонинд юм уу эсвэл үйлдвэрт ажил хийгээд явж болох л байлаа. Гэвч хувь заяа улс төрийн тэмцлийн замыг сонгож авчээ. Энэ дашрамд хэлэхэд миний хамгийн тааруухан хийж чаддаг ажил бол улс төр гэж бодож байна.

*— Өөрөө Улсын Бага Хуралд хоёр жил суусан. Улмаар Улсын Их Хурлын гишүүн боллоо. Энэ хооронд юу бүтээв? Улсын*

*Бага Хурал болоод Улсын Их Хурлын хооронд ялгаа байна уу?*

— Улсын Бага Хурлын бүтээл бол бүрэн эрхийнхээ хугацаанд баталж гаргасан хуулиуд юм. Энэ нь нэг хүний бүтээл бус хамтын оюун ухааны нэгдсэн илэрхийлэл, бүх гишүүдийнх нь хамтын хөдөлмөр шингэсэн төрийн дээд байгууллагын баримт бичиг. Түүнд миний санал бодол ямар нэг хэмжээгээр туссан. Зориуд цохон тэмдэглэхэд Улсын Бага Хурлын хамгийн гол бүтээл бол Монгол Улсын Үндсэн хууль гэж хэлж болно. Улсын Бага Хурлаас оруулсан Үндсэн хуулийн эх төсөл Ардын Их Хурлын хуралдаанаар тодчилон нэмж өөрчлөгдөж өнгө зүсээ хувиргалгүйгээр бараг тэр чигээрээ батлагдсан. Үнэн хэрэгтээ Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг Улсын Бага Хурал баталж Ардын Их Хурал батламж өгсөн ч гэж хэлж болно. Харин Ардын Их Хурлаар уг хуулийн төслийг хэлэлцэх явцад зарим нэг ойлгомжгүй үг өгүүлбэр нэмэгдэж чанарын түвшин доошилсон тал бий.

*— Бид хоёрын яриа Үндсэн хуулийн тухай сэдэвт шилжчихлээ. Саяхан Үндсэн хуулийн нэг жилийн ойг тэмдэглэсэн. Энэ ойг угтан зохион байгуулсан нэг эрдэм шинжилгээний бага хурал дээр Та үг хэлэхдээ Үндсэн хууль Монголд цаасан дээр хоцорч ардчилал гэгээн дурсгал болж үлдэх нь гэж хэлсэн санагдана. Тэр тухай ойлгомжтой тодруулж ярихгүй юу?*

— Монгол улсыг ардчилахын төлөө явуулсан тэмцэл Үндсэн хуулинд жинхэнэ утгаараа туссан гэж боддог. Үндсэн хуулинд туссан тэрхүү үзэл баримтлалыг төрийн бодлогоор зохицуулж амьдруулахгүй бол цаас хэвээрээ үлдэнэ. Харамсалтай нь шинэчлэл түүштэй хэрэгжүүлэх төрийн бодлого манайд явагдахгүй байна. Энэ утгаар нь Үндсэн хуулийн үзэл санаа цаасан дээр хоцорч, ардчиллын ололт амжилт гэгээн дурсгал болон үлдэж магадгүй гэж хэлсэн юм. Үндсэн хуулийн залгамж хуулинд тун тодорхой заалт бий. Улсын Их Хурал 1992—1996 онд багтааж Монголын бүх хууль тогтоомжийг Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн өөрчилж шинэчилсэн байх ёстой. Монголын нийгмийн бүх амьдралыг Үндсэн хуулинд оруулж өгсөөр Улсын Их Хурлын үндсэн үүрэг биелэгдэнэ. Түүгээр ч түүний бүрэн эрх дуусгавар болох учиртай. Гэтэл өнөөдрийн гаргаж байгаа хууль тогтоол нь Үндсэн хуулийн үзэл баримтлалаас зөрсөн, түүнийг зөрчсөн байх нь цөөнгүй байна. Ийм байдлаар цааш явах юм бол хэсэг хугацаа өнгөрсний дараа Үндсэн хууль өөрөө цаас болж хувирна.

— *Тодорхой баримт хэлж өгөхгүй юу?*

— Тэр болноо. Жишээлбэл татварын тухай багц хууль байна. Монголын татварын хуулиуд нь зах зээлийн хөгжингүй орнуудын түвшинд тогтоогдлоо. Татварын хувь хэмжээг их тогтоох тусам татвараас орох орлогын хэмжээ дандаа л багасна. Харин бага тогтоож өгвөл улсад оруулах орлого нь нэмэгддэг юм. Миний бодлоор татварын хувь манайд 25—30 хувь байхад хангалттай. Өндөр татвар тогтоосноор хэд хэдэн сөрөг үзэгдэл нийгэмд бий болно. Орлогоо нууна. Хээл хахууль цэцэглэнэ. Ер нь нийгэмд үүсэн гарч байгаа гаж буруу үзэгдэл бүхэн, түүний дотроос бизнесийн сүүдэртэй үйл ажиллагаа нь төрийн байгууллагын алдааг ашиглаж, түүн дээр дэгжиж бий болдог зүй тогтолтой. Зүйрлэн хэлбэл биеийн хамгаалалтыг мэдэрдэг халууны шинж л гэсэн үг.

Амьдрах чадваргүй, үрэлгэн тогтолцоог тэжээхийн тулд, улсын төсвийг ямар ч үнээр хамаагүй бүрдүүлэхэд л чиглэсэн хуулиуд гэж хэлж болно. Манайд 12 төрлийн албан татвар бий. Бас 6 төрлийн хураамж, 5 төрлийн төлбөртэй. Тэр бүхэн нийлээд хувийн болон аж ахуйн байгууллагын орлогын 80—90 хувийг татвараар дайчлахаар болчихсон. Ингэж болохгүй.

Төр бол татвар төлөгч нараа хамгаалах ёстой юм. Татвар төлөгчдийн хүрээ улам бүр өргөжиж байхуйц ийм бодлогыг явуулах учиртай. Гэтэл манайд тэгж чадсангүй. Байдгаа татварт өгчихсөн улс чинь өчүүхэн үлдэгдлээр яаж амьдарч, үйлдвэрлэлээ хэрхэн өргөжүүлэх юм бэ? Улсын Их Хурлаас сая баталж гаргасан татварын тухай багц хууль бол хувийн хэвшлийнхний орлогыг татварт хуу татахад чиглэсэн хууль.

— *Өөр жишээ байна уу?*

— Байна. 1993 оны төсвийн тухай хуулийг аваад үзье л дээ. *Нэгдүгээрт*, уг хуулийн үндэслэл амьдралтай нийцэхгүй. *Хоёрдугаарт*, төлөвлөсөн л бол заавал биелүүлэх ёстой гэсэн хуучин зарчмыг баримталсан. *Гуравдугаарт*, 1993 оны төсвийн тухай хууль бол бүтэн жилийг багтааж, урьдчилан харж журамлагүйлан тусгаж чадаагүй. Ердөө л энэ оны нэгдүгээр улирлын төдий юм. Түүнээс цааш харж чадаагүй. Төсвийн тухай хуулийг хэлэлцэж байх шатанд л юмны үнэ хэд дахин нэмэгдэж төгрөгийн ханш үнэн хэрэгтээ хоёр дахин унасныг санахад хангалттай.

Засгийн газрын зардал асар өндөр байгаа. Энэ нь ч татварыг өндөр тогтоохыг аргагүй л шаардсан. Өнөөдөр Монгол улсад [illegible] сэр аппаратын хүчээр нийгмийг удирддаг хуучин тогтолцоо хэ

нэрээ байна. Төсвөөс цалин шаардсан дарга мэндагтны тоо 7500-д хүрсэн гэж бодоод үз дээ.

— *Ярьж хэлэх, хийж гүйцэтгэх хоёрын хооронд их зөрүү гарах юм даа.*

— Тийм ээ. Тэрнийг чинь л би шүүмжлэх гээд байна. Улс төрийн нам бүр хөтөлбөр боловсруулж сонгуульд уралдсан. Ард түмэн тэрхүү хөтөлбөрийнх нь төлөө саналаа өгцгөөсөн. Гэтэл миний дурдаж ярьсан дээрх хуулиудыг батлахдаа парламентад ихэнх суудлыг авсан МАХН-ынхан сонгуулийн өмнөх амлалт, мөрийн хөтөлбөртөө дэвшүүлсэн зүйлээ эргэж харсангүй. МАХН-ын сонгуулийн хөтөлбөрт хүн ардыг хүнсний хомсдлоос гаргана. Гурилын хэрэгцээг хангана. Картын системийг хадгалж нэг хүнд ногдох барааны нэр төрлийг нэмэгдүүлнэ гэж тод тодорхой бичээстэй байгаа. Тэр сайхан амлалтууд хаачваа?

Хувийн хөдөлмөр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж эхний 3 жилд 50 хувийн татварын хөнгөлөлт үзүүлнэ гэж тэр хөтөлбөрт цагаан дээр хараар их тодоор бичсэн байгаа. Гэтэл хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хүн амын орлогын татварт хамааруулаад аж ахуйн нэгжийн орлогын татвараас өндөр тогтоосон. Хоршоо, компаниудын хувьд 5 сая төгрөгийн орлогоос 40 хувийн татвар авахаар тогтоосон бол хувиараа эрхлэх аж ахуйн болохоор нэг саяас 40 хувийн татвар төлөх болсон. Энэ шударга зарчим гэж үү?

Төсвийн талаар МАХН хөтөлбөртөө амласнаа бас биелүүлсэнгүй. Жишээ нь жилийн төсвийн орлогын 3—4 хувийг шинжилгээ, судалгааны ажилд зориулна гэсэн атлаа 1993 онд нэг төгрөг ч төсөвлөсөнгүй. Соёл, урлагийн салбарт төсвийн орлогын 3-аас доошгүй хувийг зориулна гэчхээд 1993 оны төсөв батлахдаа дөнгөж 1,01 хувийг л арай ядан гаргалаа.

Үүнээс хийх ноцтой дүгнэлт бол аль ч *улс төрийн нам төрийн эрхийг худал хэлж авах эрхгүй. Ард түмний итгэлээр тоглож* болохгүй гэж анхааруулмаар байна.

— *Санал бодлын энэхүү зөрүүгээ илэрхийлж хэлдэг биз дээ? Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд ганцаарлах явдал гардаг уу? Үүнийг би оппозици хүчнийхэнтэй холбон асууж байна. Хурал даргалагчаас та нарыг ялгаварлан гадуурхдаг уу? Өөрөө хууль санаачилж байна уу? Үгүй бол яагаад?*

— Парламентын засаглалын нэг гол шалгуур бол сөрөг хүчний санаа бодлыг үргэлж сонсдог байх явдал юм. Сөрөг хүчинд ажиллах боломж олгох ёстой. Ерөнхийлөгчийн засаглалтай улс

оронд бол Ерөнхийлөгч, Парламент хоёр нь ийнхүү тэнцвэрт харьцааг бариад явж чаддаг юм. Харин парламентын засаглалтай улсад бол сонгуульд ялсан нам, сөрөг хүчин хоёр төрийн эрх барих тэнцвэрт харьцааг бариддаг. Ялсан нам нь өөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн төлөө ажилладаг. Сөрөг хүчин нь өөрсдийн намын бодлогын үүднээс тэрхүү хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт хандаж ард түмний хүсэл бодлыг илэрхийлэгчийн байр сууринаас асуудлыг хөндөдөг.

Өнөөдөр Улсын Их Хуралд нэг намын бүлэг байгаа. Суудал бүхий бусад нам тэнд намын бүлэг байгуулж ажиллах хууль зүйн эрх, үндэс байхгүй. Тийм бололцоо ч үгүй. Ийм болохоор л бид парламентын үндсэн зарчим манайд алга болчихоод байна гэж ярьж байгаа юм.

Хууль санаачилж болно. Тэгэхдээ хуулийн төслийг хэлэлцэх явцад цөөнхөөс хэлсэн үг өгүүлбэр, санал санаачилга, тавьж буй зарчмын асуудлууд их ач холбогдолтой юм. Түүнийг бараг хууль санаачилсан түвшинд авч үзэж болох ёстой. Миний өөрийн хувьд ямар нэгэн хууль санаачлаад Улсын Их Хуралд оруулаад тэрхүү хуулийн үзэл баримтлал бүрэн бүтнээрээ хууль болж гарна гэсэн итгэл алга байна.

— *Өөрөө төрийн жолоо атгалцсан түшээ болжээ. Монгол Улсын хууль зүйтэй холбоотой олон хуулийг батлалцан зүтгэж байна. Тийм болохоор Монгол улсын тухай асуулт тавья. Монгол Улсын хөгжил арван жилээр ухарлаа гэж ярьж бичдэг болсон. Саяхан Улсын Их Хурлын эрхэм гишүүдэд зориулж хийсэн мэдээлэлдээ Шинжлэх ухаан, боловсролын сайд Н. Өлзий-Хутаг монголын боловсрол хорин жилээр ухарлаа гэсэн. Энэ талаарх өөрийн чинь бодлыг сонсъё.*

— Ер нь эгэл тухайн хүмүүс, ард иргэд өөрсдөө үнэлэлт дүгнэлт хийгээд ярилцах нь тэдний эрхийн асуудал. Харин Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүдийн хувьд бол амьдрал ингэж хүндэрлээ, ийм зүйл болохгүй байна гэж ярих биш, энэ бэрхшээлээс яаж гаргах вэ? Бид ийм зүйл хийнээр байна. Тийм тийм юм хийх зайлшгүй шаардлагатай байна гэж хэлж ярьж байх ёс байгаа юм. Гэтэл тэгэхгүй байна. Монгол Улсад хүнд хэцүү байна гэж бүх хүн ярьж болно. Харин Ерөнхий сайдын хувьд бол тэр хүнд хэцүү байдлаас ингэж гаргана л гэж ярьж байх ёстой. Үүгээрээ *Нэгдүгээрт*, ялгаатай. *Хоёрдугаарт*, нэгэнт амьдрах чадваргүйгээ харуулсан тэр л тогтолцоог өндөр татвар тогтоогоод төсөв цуглуулаад нэг зэрэг тэжээх бодлого барих биш, түүнийг бүтцийнх нь хувьд нэн яаралтай өөрчлөх

хэрэгтэй. Хүмүүс өлсөж цангаж байна. Хүнд хэцүү амьдралтай байна гээд байдаг атлаа өөрсдөө удирдлагын бүтцийг улам томруулж ард түмний нуруун дээр гарч суучихаад байгаагаа ажиглахгүй, харин өлсөж цангаж буйг нь гайхаж суух нь учир утгагүй хэрэг. Үүний оронд ядарч зүдэрч байгаа улсынхаа нуруунаас газарт бууж тэгээр ядарсан хүмүүсээ халамжилж тэтгэх төрийн бодлогоо туушгай явуулах, үүний тулд бүтцийн өөрчлөлтийг эрчимтэй хийх хэрэгтэй юм.

*— Монгол Улсыг хямралаас гаргах ямар үндсэн арга зам байна гэж Та бодож байна. Эх орныхоо ирээдүйг хэрхэн төсөөлдөг вэ? Улсын Их Хурлын тэргүүний хувьд улс орныхоо хөгжилд ямар хувь нэмэр оруулж байна.*

— Хямралаас улс орныг гаргах арга замын тухай асууж байна. Миний бодоход бид Монгол улсыг хямралаас гаргаж чадна. Бидэнд ийм тодорхой хөтөлбөр байна гээд сонгуулийн өмнө ард түмэндээ өргөн барьсан, түүнд нь итгээд түмэн олон саналаа өгсөн, тэдний итгэлийг хүлээж сонгуульд ялсан тэр нам л Үндсэн хуулийн үзэл санаатай үйл ажиллагаагаа нийцүүлж улам хөгжүүлээд эрчимтэй ажиллах хэрэгтэй байна. Үүнээс өөр ямар нэгэн арга байхгүй.

Хүмүүс ерөнхийдөө монголчууд тэжээлгэх сэтгэлгээнээс салж хөрсөндөө ажиллаж сурвал улс орон хямралаас түргэн гарна гэж ярьдаг. Энэ асуудлын нэг тал нь. Нөгөө нэг тал нь юу вэ гэвэл төрийн эрхийг барьж төрийн бодлогыг барьж байгаа хүмүүс шийдэмгий, зоримог ажиллах ёстой. Ер нь Монгол улс ард түмнээсээ биш, харин урагшгүй удирдлагаасаа болж дордож ирсэн нь түүхэнд цөөнгүй.

Монголын ирээдүйн хувьд бол надад тодорхой бодол бий. Монгол ирээдүйгээ харъя гэвэл Монголд өөрт нь ямар онцлог байна гэдгээ харах ёстой. Монголд өөрт нь ямар онцлогтой вэ гэвэл Монгол улс жижиг орон. Цөөн хүн амтай. Аугаа уужим газар нутагтай. Ийм болохоор Монгол улс цөөхөн удирдлагатай байж их зүйлийг хийж болох орон. Энэ онцлогоо харж, энэ онцлогоо барьж хөгжүүлэх ёстой. Түүнээс биш бусад бүх оронд байдаг удирдлагыг дуурайж, бүх замыг Монголд байгуулах зэргээр ажиллаж болохгүй. 200 сая хүнтэй, тэрбум иргэдтэй улс орны хэмжээнд сэтгэж, тэдний загвараар гүйнэ гэвэл бүх юмаа цацаад ямар ч үр дүнгүй үлдэнэ. Иймд бид өөрсдийн онцлогоо л харж улс орноо хөгжүүлэх ёстой. Тэгвэл Монголд их ирээдүй бий гэдгийг дахин хэлмээр байна.

*— Сүүлийн үед Монгол оронд баян, хоосны ялгарал гарч байна гэж хэвлэлд их бичих, хүмүүс ч ярьж хөөрөх боллоо. Телевизороор өнчин өрөөсөн хүүхдүүд, гуламжны тэнэмэл жаалуудын хувь заяаны талаар үзүүлэх боллоо. Энэ үзэгдэл цаашид гүнзгийрэх үү? Хэрэв гүнзгийрвэл Улсын Их Хурлын гишүүний хувьд юу хийх вэ? Ер нь энэ үзэгдлээс айж болгоомжилж байна уу?*

— Миний сэтгэл зовж байгаа нэг зүйл бол энэ. Тухайлбал ядарч, өлсөж байгаа тэнэмэл хүүхдийг харуулаад ийм олон хүн ядарч байна гэж хэлж байна. Тэгсэн атлаа тэдний төлөө ажиллах ёстой, тэдний нуруун дээрээс буугаад ачаа үүргээ ажил хийх ёстой, тэднийг халамжлах учиртай, тийм үүргийг өөрсдөө хүлээлгэсэн, тэрхүү амлалтыг авсан хүмүүс, төр захиргааны байгууллагын ажилтнууд шүүмжлэлгүй байна. Тэд ч дорвитой ажил хийхгүй байна. Гол асуудал үүнд байгааг хэлэх хэрэгтэй. Өөр нэг зүйл бол нийгмийн доторх ялгарал, тухайлбал баян, хоосны ялгарал ихсэх тусам, үнэ өсөх тусам, хүмүүс бухимдах тусам сайн байдаг, түүнд амьдарч чаддаг тийм үзэл суртал гэж байдаг. Өөрийнхөө бодлыг хэлье. Яг тийм юмны дундаас коммунист үзэл суртал өөрөө бий болсон юм. Түүний үндэс нь үл гүйцэлдэх үзэл. Нэгэнт үл гүйцэлдэх үзлийг гүйцэлдүүлэх гэж чармайсан учраас залхаан цээрлүүлэх цусэр аппаратыг бий болгосон. Тэр нь ямар ч амьдрах чадваргүй гэдгээ харуулаад дэлхий нийтээр сүйрэлд орж байна. Гэтэл өнөөдөр манайд засгийн эрх барьж байгаа нам, удирдлагад байгаа бодлого явуулж буй хүмүүс тэрхүү коммунист үл гүйцэлдэх үзлээсээ салж чадаагүй хэвээр байна.

Хүмүүс өлсөж, цангаж байна гэж телевизороор харуулахын оронд тэдний нуруун дээрээс өөрсдөө буугаад ажил хийх нь илүү ашигтай. Өнөөдрийнх шиг зүгээр л харуулаад, үзүүлээд байх юм бол хүмүүс энэхүү өлсгөлөн, хомсдолд дасч эхэлнэ. Автобусны үнийг нэг төгрөг болгоод өсгөхөд л, сүүний үнийг хоёр төгрөг байсныг дөрвөн төгрөг, найман төгрөг болгоод нэмэгдүүлэхэд л хувин саваа бариад Сүхбаатарын талбай дээр хүрч ирж байсан шүү дээ. Энэ бол нэг талаас зөв үзэгдэл. Болохгүй байна гэдгээ ард түмэн төрдөө илэрхийлж буй нэг хэлбэр. Гэтэл өнөөдөр сүүний үнэ 30 дахин нэмэгдэж, литр нь 70 төгрөг болчихоод байхад л хах ч үгүй байна. Ер нь юмны үнэ нэмэгдсэний хэрээр бараа таваарын чанар, үйлчилгээ сайжрах ёстой. Автобусны тасалбар 3 төгрөг болоход л үйлчилгээ нь дээшилж, улам олон автобус явж байх, эсвэл талхны үнэ 20 төгрөгт хүрэхэд л амт чанар нь

сайжирч, үйлдвэрлэл нь өсөх ёстой. Гэтэл энэ нь манайд ердөө ч үзэгдэхгүй байна. Эндээс юу гэж хэлж болох вэ гэвэл та бид зах зээл рүү орж байгаа биш, харин зах зээлийн эсрэг бодлого явуулаад байна гэж хэлж болно. Нэг зүйлийг нэмж хэлье. Юмны үнийг өсгөөд, үйлдвэрлэлийг монополчилдог хэдэн үйлдвэртээ алдагдлыг нь нөхөж өгөх, төсөв дээр суудаг байгууллагуудаа цалин [illegible] нь нэмэх, хөрөөр холбоод амиа аргацаах чиглэлээр л явж байна. Зах зээлийн зарчим хэрэгжихгүй байна. Гол зарчимтайгаа нийцэхгүй байна. Үнэ өсч байхад түүнийг дагаад чанарын сайжрал гарч байх учиртай. Энэ нь харагдахгүй байна. Товчхон хэлэхэд бодлого буруу явж байна.

— *Хүмүүс манай улс төрийн зүтгэлтнүүдийн талаар янз янзын л зүйл ярих юм. Жишээ нь өөрийг чинь аль хэдийнэ салтан болчихсон, хувьдаа унаа тэрэгтэй гэлцдэг. Энэ бүхэн үнэнд нийцэж байна уу?*

— Би бусдын л нэгэн адил. Ихэнх монголчууд шиг цалингаас цалингийн хооронд л амь тэрж байна. Унааны хувьд гэвэл МоАХ ердөө ганцхан тэрэгтэй. Түүнийгээ хотод ч, хөдөөд ч дундаа хэрэглэдэг. Ийм л байна.

— *Өнгөрсөн 1992 онд Та Монголын хамгийн шилдэг залуу улс төрч болсон. Бас 500 ам. доллараар шагнуулсан гэдгийг хэвлэл, мэдээллээр бичиж шуугиулсан. Юмтай хүнд өчүүхэн мэт боловч юмгүй хүнд, ялангуяа [illegible] улс ядарч зүдэрч байгаа өнөөгийн Монголын нөхцөлд бас ч шагшийсан мөнгө юм. Түүнийгээ яаж зарцуулж байна.*

— Хэрхэн зарцуулах тухайгаа бодох завгүй л хэрэглээд л дуусч байх шиг байна даа.

— *Бид хоёр нэг нууцгүй сайхан ярилцаж байна. Тийм учраас өөрөөс нэг зүйл асууя. Уучлаарай, хэрэв миний асуулт зөвгүй санагдвал шууд хэлээрэй. Хариулахгүй байсан ч болно. Цахиа, чоно хоёр Зэргийн мянгат барсан юмсан. Цахиагийн Элбэгдорж монголын ялалт барах нь энэ гэж нутгийн хүмүүс ярьж байхыг би чихээрээ сонссон хүн. Өөрөө ч мэдэж байгаа байх. Арлын [illegible] хөдөлгөөнийг оргуулж эхлэх үеийн ярна. Сэнвачилж байгуулсан тэр холбоо чинь юу хийж байна.*

— Одоогоос 11 жилийн өмнө ордонгийн [illegible] бусыг үзүүлсэн миний аавын нэр (*түүнд [illegible] зэнтирээд толгой бисэ барьж [illegible]*), чоно гэдэг тэрхүү хиймордлог [illegible] Нэг талаас харамсах, нөгөө

талаас тулгамдах байдалд орж байна гэдгээ хэлье. Миний аавын аав бол Монгол гэдэг нэртэй хүн байсан. Манайхан удмаараа мал дагаж байгалийнхаа хишгийг шүтэж амьдарсан улс. Аав, ээж хоёрт үлдсэн юм юу вэ гэвэл «мал өсгөлөө», «улсын даалгаврыг сайн биелүүллээ», «ноосыг нь их сайн авч өглөө», «махыг нь гүйцэд тушаалаа» гэсэн хавтас дүүрэн баярын бичиг л байгаа. Өөр юм үлдээгүй. Хэдэн малаа өсгөх гэж, нийгэмчлээд нэгдлийн төлөө зүтгэсээр байгаад тэтгэвэрт гараад сүүлд Эрдэнэтэд шилжин орж суурьшаад аав минь насан өөд болсон. Ээж минь одоо ч тэндээ байгаа. Эргийн малыг барахын хэмжээнд эцэг минь тийм үйл ажиллагаа явуулаагүй болов уу гэж би боддог юм даа.

*(Ахин хоолой нь зангирч шүлсээ дуусхийн гомдонгуй өгүүлэв)*

*— Хэтрүүлэг, давруулгатай яриа байсан биз. Ардын аж ахуйтны холбоо, нэгдлийн мал хувьчлал дээр зөвлөж ярихгүй юу?*

— Ардын аж ахуйтны холбооны хувьд гэвэл би нэгдүгээрт тус холбооны дарга биш ээ. Өнөөдрөөс жил гаруйн өмнө Ардын аж ахуйтны холбоо зөвлөгөөнөө хийж, би хүсэлтээ тавиад үг албан тушаалаас чөлөөлөгдсөн. Төрийн хуулийг зөв тайлбарлаж хэрэгжүүлэх ёстой тэр хүмүүс өөрсдийн санал бодолдоо тохируулан тайлбарлаж, албан тушаалаараа далимдуулан өмч хөрөнгө олж авахыг санаархаж, сандал суудал дээрээ нэг хэсэг тогтож байхын тулд буруугаар сэнхрүүлж малчдад сөрөг сэтгэгдэл төрүүлдэг. Энэ нь өмч хувьчлал дээр хортой дахрал гаргахад хүргэсэн юм. Үүнийг халах ёстой. Өмч хувьчлалыг төрийн эзэгээс хатуу хяналттай явуулъя. Хөдөө аж ахуйн нэгдлийн өмчийг нэгэнт эхэлсэн хувьчилъя гэж хуульд тодорхой заалт оруулъя гэдэг асуудлыг Улсын Бага Хуралд байхдаа ч би тавьж байсан. Янз бүрийн олон нийтийн байгууллагын шугамаар ч тавьсан. Засгийн газар, төрийн дээд байгууллагад олон удаа сонордуулах бичиг өргөж санал болгосон. Удирдлагуудтай цөөнгүй уулзсан. Тэд нэгдлийн өмчийн 70 хувийг авч үлдээд хувьцаат компани байгуулна. Үлдсэн 30 хувийг хувьчилна гэсэн байр суурьтай байсаар байгаад, үйл явц тэдний хүсэл бодлын эсрэг эргэсээр байгаад өнөөдөр Монголын малын 70 хувь, түүн дээр хувьцаат компанийн малыг нэмбэл бараг зуун хувь хувьд оччихоод байна. Зөвхөн зөөлөн суудал, дулаан байрандаа хоргодож, түүнийгээ хадгалж үлдэхийн тулд ард түмний өмч хөрөнгөөр тоглосон, түүн дээр ямар нэгэн хяналт тавиагүйн хариуцлагыг хэрэв шударга ёс гэж байдаг юм бол тооцох ёстой.

Бид нар тэр бэлтгэл хэл 1989 оны 12 дугаар сарын 1-ний үеийг 1991 оны 12 дугаар сарын 1-ний тоотой харьцуулж тооллогоо нэгтгээд түүн дээр дүгнэлт хийж тэр үед байсан өмч хөрөнгийн хэмжээ ямар болсныг судалж гаргаж ирье гэсэн асуудлыг Ерөнхийлөгчөөс явуулаад, Засгийн газрын ерөнхий сайд, бүх яамд тавьж байсан. Үүнийг үнэхээр авч үзэх хэрэгсээгүй ээ. Нэг хашааг арван малчны дунд хувааж өгчихсөн энэ та нарын өмч шүү гэж хэлэх юм бол тэр дор нь буулгаад арван тийш нь авааад л явчихна. Харин өвөлжөөн дээр байгаа хашааг тэнд өвөлждөг малчид нь ончлуулж өгөх ёстой. Истэх юм бол тэр хашаа эвдрэхгүй, тэр хэн сүйрэхгүй. Нэг хэсэг хөрөнгийг энэ бол та бидний дундын өмч, хувьцаат компанийн хөрөнгө гэж хэлчихээд тал талаас нь идээд, нэг тийш нь ганцхан үнээр өгөөд л суугаад байх юм бол тэнд өмч хөрөнгө үлдэхгүй. Үрэгдэнэ. Харин бүгдийг сонгосон эзэнтэй болгочихоод өөрсдийнх нь тэрхүү өмчин дээр тулгуурлаж аж ахуйн нэгж байгуулаад цаашаа яв гэх юм бол тэр өмч үрэгдэхгүй. Ер нь энэ талаар ярих маш их зүйл бий.

— *Өнгөрсөн хугацаанд сонгогчидтойгоо хэдэн удаа уулзав. Тэд нар юу ярьж байх юм.*

— Хөвсгөл рүү очиж чадаагүй байгаа. Сонгогчидтойгоо уулзана гэдгийг би өргөн утгаар ойлгож байна. Надад ирүүлж байгаа захидал, ирж уулзаж буй хүмүүсийн санал бодлыг, ард түмний дотор байгаа уур амьсгалыг аль болох ашигтаар хэвлэл, мэдээллээр ч юм уу, эсвэл Улсын Их Хурлын хуралдаан дээр, Засгийн газрын гишүүдэд хүргэхийг хичээдэг. Үүнийгээ сонгогчдынхоо төлөө хийж байгаа ажил гэж би үзэж байгаа. Ер нь сонгогчид гэж ялгаруулах биш, Хөвсгөл аймагт гарч байгаа хүндрэлтэй асуудал нь Монгол улс даяар л байгаа гэж ойлгодог. Монгол даяарх тэрхүү асуудлаас аль нэгнийг шийдвэрлэхээр Хөвсгөл аймаг дахь нэг хэсэг хүний ачаа хөнгөрч, нэг хэсэг хүн нэн амьдрах ийм боломж бүрдэнэ. Энэ утгаар бол би сонгогчдынхоо төлөө их санаа тавьж ажиллаж байгаа. Тэгэхдээ очиж уулзана.

— *Улсын Их Хурлын намрын чуулган дуусч байна. Хаврын чуулганы хооронд чөлөө гарах юм биз. Тэр үеэр Хөвсгөл явах уу?*

— Тэгнэ. Тийм бодолтой байна.

— *Улсын Их Хуралд та нэрээ Хөвсгөлөөс тавьж дэвшүүлсэн юм бэ. Төрж өссөн Ховд нутгаасаа дэвшүүлж болоогүй юм уу?*

— Ер нь Улсын Их Хурлын сонгуульд оролцсон бараг хүн бүр нэрээ нутаг нутгаасаа дэвшүүлсэн. Миний хувьд бол нэрээ төрсөн нутгаасаа дэвшүүлж болохоор байсан. Гэхдээ өөр аймгаас нэрээ дэвшүүлж өрсөлдөөд Улсын Их Хурлын гишүүн болж чадах нь уу, үгүй юу гэдгээ үзье гэж бодсон юм.

*— Улсын Их Хурал ойрын үед Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцэж эхлэх бололтой. Энэ талаар өөрийн чинь санал бодлыг сонсох гэсэн юм. Учир нь Монгол дахь засаглалын хэлбэрийн талаар та бүр өөр сонин саналтай байсан гэж би дуулсан юм. Монгол улсад Ерөнхийлөгч бүхий парламентын засаглал хэр нийцэж байна. Хааяа буюу өөр засаглалын хэлбэр байж болохгүй юу?*

— Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулин дээр нэг зүйлийг сайтай анхаарах ёстой. Энэ хууль бол аль нэг салбарын тухай, энгийн засгийн бусад хуультай адилхан хууль биш. Энэ бол Монгол улсын төрийн тэргүүн, тэр тусмаа монголын үндэсний эв нэгдлийн бэлгэдэл болсон Ерөнхийлөгчийг сонгох тухай хууль юм. Иймээс Монгол оронд байгаа олон нам, улс орны амьдралд нөлөө үзүүлэхүйц олон нийтийн байгууллагууд, ард иргэдийн саналыг хуулийн төсөлд нь аль болох өргөнөөр тусгах шаардлагатай. Нөгөөтэйгүүр Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулиас Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагаа, түүний статусыг тусад нь гаргаж хуульчлан тогтоох ёстой.

Монгол оронд ямар засаглалыг сонгож авах тухай асуудлаар Үндсэн хуулийг батлахаас өмнө янз янзын санал, үзэл бодол иргэдэж хэлэлцэгддэг байсан юм. Нэгэнт бид нар Үндсэн хуулиа баталсан, Монгол улс парламентын засаглалтай байна гээд тогтчихсон учраас та бид энэ засаглалаа сод татаж Үндсэн хуулийнхаа заалтын дагуу, тэр утгаар нь бүрэн хэрэгжүүлэхийн төлөө бүгд санаа тавьж зүтгэхээс өөр аргагүй. Парламентын засаглалтай байна гэдэг нь Улсын Их Хурал зөвхөн хууль батлах үүрэгтэй байна гэсэн үг биш. Энэ бол улс орны амьдралтай холбоотой амин чухал бүх асуудал, түүний дотор төрийн гадаад, дотоод бодлогын бүх асуудлыг Улсын Их Хурлаас тодорхойлж гаргах тухай ойлголт юм. Тийм учраас Улсын Их Хурал, түүний байнгын хороод, аппаратын эрх үүрэг нь тодорхой ажиллах чадамж маш өндөр байх ёстой юм. Үүнийг парламентын засаглал шаарддаг.

Ерөнхийлөгчийн засаглалтай байх нөхцөлд парламент нь хуулиа дагнаад харин Ерөнхийлөгч дээрх бүх үүргийг хэрэгжүүлээд явж болдог байна. Энэ ондлогийг бид их анхаарах ёстой.

*— Монгол Улсын тусгаар тогтнолын талаарх Таны санал бодол, ойлголтыг хэлж болох уу?*

— Монгол Улсын тусгаар тогтнол гэж ярьж байсан удсаас эх орныхоо тусгаар тогтнолд хохирол учруулж байсан тохиолдол бий. Эх оронч бүхэн эх орныхоо тусгаар тогтнолын төлөө байдаг гэдэг нь ерөөсөө ойлголт болов уу. Монгол улсын тусгаар тогтнолын хэд хэдэн баталгаа бий. *Нэгдүгээрт*, улс төрийн баталгаа. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл Монгол улс жижиг орны хувьд хүчтэй улс төрийн бодлого явуулж тусгаар тогтнолоо хамгаалах ёстой. Зоригтой улс төрийн бодлого. *Хоёрдугаарт*, эдийн засгийн баталгаа орно. Эдийн засгийн тусгаар тогтнолын хувьд бол аль болох олон улс оронтой эн тэгш харьцаж байх ёстой. Нэг улс оронтой хэт ойртож, тэр улсыг дагасан үзэл баримтлал бариад тэр нь гэнэт тасрах юм бол юунд хүрдгийг бид өнөөдөр харж байна. *Гуравдугаарт*, монголчуудын соёл, зан, түүхэн уламжлалыг аль болохоор хөгжүүлэх ёстой. Энэ нь тусгаар тогтнолтой нэг холбоотой зүйл.

*— Өчигдөр, өнөөдөр, маргаашийн шүтэлцээ холбоог өөрөө яаж ойлгодог вэ?*

— Таны асуултыг сонсоод хамгийн түрүүнд миний санаанд үгүйсгэлийн тухай асуудал орж ирж байна. Өчигдрийн юмыг өнөөдөр үгүйсгээд маргааш нь шинэ юм хийнэ гэдэг байдлаар нийгмийн хөгжил явах ёсгүй. Та бидний аж төрж байсан өмнөх тогтолцоо яг тийм байсан. Өмнөх бүх юмаа үгүйсгээд, феодалын юм гэж хэлээд эзэнтэй хөрөнгөтөнгийг нь устгаад, өмч хөрөнгийг нь хураагаад, улс орноо зөв хөгжлийн замаар явуулъя гэснийг нь сөрөг үзэл бодолтой буруу номтон гэж хэлмэгдүүлээд, өөрсдөө бүх түүхийг шинээр эхлэх гэсэн ч чадсангүй. Тэр нь үнэхээр болж өгсөнгүй. Тийм болохоор өмнөх түүхээ үгүйсгэх байр сууриндээр байдаг хүн биш гэдгээ би хэлмээр байна.

Өнгөрсөн 70 жилийн түүхэнд юм юм л бий. Бидний түүх үнэхээр анхаарч үзэх л учиртай. Түүнээс өмнөх түүхэнд ч бий. Тухайлбал миний сэтгэлд шингэж байгаа нэг зүйл гэвэл Гадаад харилцааны яам өөрийн үүсч бий болсон түүхээ 1911 он гэж тооцдог болж ойгоо тэмдэглэж байна. Бусад газар ч мөн ялгаагүй. Үүсэл хөгжлөө өмнөх үеэсээ эрж хайж байна. Энэ бол их сайн үзэгдэл. Мөн 1921 оноос үүсч хөгжсөн ч сайн юм бий. Түүнийг ч ялгаагүй бид хойшдоо авч залгамжилж явах ёстой.

Өмнөх үед ажиллаж амьдарч байсан бидний ахмад үеийнхний тухай бас нэг үг хэлье. Миний тухай ч хүмүүс бас өрөөсгөлөөр ойлгодог юм шиг байгаа юм. Хувьсгалт намын гишүүнийг л бол

сид хүмүүс ална ацтал нэг нэгнийгээ шүүмжилчихээд 1994 оноос эхлэн нэг шүүмжлэлгүйгээр нэг нам төрийн эрх барьсаад пичихээ ц гэж боддог юм уу, бүх юм алга болчихно гэж бодвол эндүүрэл болно. Өмчийн олон хэлбэр бий. Үзэл бодлын олон урсгал бас байдаг. Тэдгээр нь гагцхүү хуулинд захирагддаг, гагцхүү ард түмнийхээ эрх ашигт захирагддаг тийм нийгэм рүү явж байгаа гэдгээ ойлгох хэрэгтэй. Одоогоор надад дайсан гэж нэрлэчих тийм хүмүүс байхгүй ээ.

— *Өөрийн чинь хамгийн шилдэг сайн чанар юу вэ?*

— Би энэ асуултанд хариулж чадахгүйнээ.

— *Тэгвэл сул тал, дутагдал гэж хэлмээр зүйл байна уу?*

— Дутагдал өөрт олон бий гэж боддог. Ер нь тийм надад ч биш. Ардчиллын төлөө хөдөлгөөн Монголд үүсээд, ерөөд прэхээр манай сэхээтнүүд, аливаа асуудлыг ойлгодог тэр хүмүүс нялээд зай барьж хандсан. Энэ бол ардчиллын үйл хэрэгт хүрч болох, олж болох байсан тэр ололтуудыг дутуу хагас хийгдэхэд хүргэсэн. Ийм зүйлүүд бий гэж боддог.

— *Та бурханд итгэдэг үү? Там ба диваажингийн тухай ямар ойлголттой байдаг вэ?*

— Бурхны сургаалаас хүний амьдралыг тайлбарлах гэсэн тэр тайлбар, дэлхий ертөнцийн амьдрал, тэдгээрийн хоорондын шүтэлцээ холбооны талаарх бичсэн зүйлсийг уншиж ойлгохыг эрхэлдэг. Там ба диваажингийн тухай ойлголт ч тэр дотор багтаж байдаг.

— *Бидний ярилцлага мэргэжлийн хүрээнээс эхэлсэн. Ахаад түүн рүүгээ эргэж оръё. Бид хоёр хүн чанарын тухай хөндөж ярилцлаа. Энэ бол миний мэргэжилтэй их холбоотой юм. Хүний сайхан чанарын тухай, түүнтэй холбогдуулж сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээний тухай тодруулж юу хэлэхсэн бол?*

— Хүн бол өөрөө байгалийн бүтээгдэхүүн. Үүсэл хөгжлийнхөө урт удаан хугацааны хөгжлийн хэрээр өсөж дэвшиж байгаа байгалийн амьтан. Оюун ухааны өндөр хөгжилтэй. Энэ үүднээс хүнийг ойлгох ёстой. Өөрөөр хэлбэл байгаль дээр байгаа бүх амьтдаас дээгүүр, ийм нь байгаль ертөнцийг гэзгээр нь аваад гэсэн тэр утгаар биш, харин өөрөө байгалийн нэг бүтээгдэхүүн, түүний салшгүй хэсэг гэдэг ойлголт нэгүү зөв байх гэж боддог.

Хүнлэг чанар бол тухайн хүн Хүн болж байгааг харуулдаг хамгийн гол шалгуур. Хүнд 70 хувь нь байгальтай холбоотой, амьтдын гаралтай зан чанар байдаг юмаа гэж бодоход үлдэх

30 хувь нь хүндэт сайн санаатай байвал тэр хүн сайн хүн гэж ойлгох ёстой. Тэр гучин хувь дээр нь бид түшиглэж тулгуурлаж ажиллах ёстой болов уу.

Хоёр дахь ойлголт руу оръё. Сэтгүүлч хүн бол өөрийн бичсэн зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг л байх ёстой. Өнөөдөр хэвлэлийн эрх чөлөө гэхэд аль ч талаас нь аваад үзсэн үнэхээр тэр эрх чөлөөг эдэлж чадахгүй байгаа, тэр эрх чөлөөг мэдэхгүй, эдлэж сураагүй хандлага нэлээд их байна. Гэхдээ тэр бүрийг хаалж боож хорих шаардлагагүй. Бас биенээ үндэслэлгүй гүтгэж байна. Янз бүрийн ой гутам зүйлийг үзүүлж харуулж, бичиж байна. Ийм зүйлээс хүмүүс ихэндээ уйдаж эхэлдэг. Тийм юмыг уншихаа болиод өөрсдийнх нь оюуны өсөлт хөгжилтөд хэрэгтэй зүйлийг эрж хайдаг, уншдаг болж эхэлнэ. Ингэсэн тохиолдолд тийм зүйл хийж байгаа, тийм юм бичиж байгаа хүмүүсийн «бүтээл» шийгээд үнэлэгдэхээ байна. Үнэлэгдэхээ болихоор цаашаа амьдрахаа болино. Ийм хэрхүү байдлаар шалгараад орно. Өнөөдрийн манай хувьд гэвэл тэнд нэг юм болохоо байчихаж, энд ийм юм зурчихаж, түүнийг ч хориглоё, үүнийг ч хуулийн байгууллагад шилжүүлье гэсэн асуудал гараад байгаа юм. Уран бүтээлчдэд, тэр дотроос сэтгүүлчдэд ингэж хандаж болохгүй. Сэтгүүл зүй бол их нарийн зүйл. Үүн дээр ганц зүйлийг нэмж хэлмээр байна. Ардчиллын өөрийнх нь амьд явахын гол баталгаа бол хэвлэлийн эрх чөлөө. Хаана хэвлэлийн эрх чөлөө байна, тэнд ардчилал баталгаатай байна, тэнд иргэдийн эрх ашиг зөв илэрхийлэгдэж байна гэж үзэх үндэстэй. Харин хэвлэл болохоо байлаа, радио болоод телевиз нэг л болохгүй байна. Үүн дээр хатуу гар хэрэгтэй байна гэж тэр, засгаас юм уу, түүний албан тушаалтнаас ярьж хэлж эхэлбэл тэр тэр, засаг амьдрах чадваргүй болж байгаагаа л харуулж буй хэрэг. Тэдгээр албан тушаалтнууд ажилдаа тэнцэхгүй болж байгаагаа л харуулж буй хэлбэр. Ер нь эрхэлсэн ажилдаа эзэн болж чадахгүй байгаа хүн эхлээд өөрийгөө шүүмжлэгчээ алга болгож авахыг эрхэмлэдэг. Хийж чадаж байгаа хүн бол түүнээс аль болох үг сонсохын төлөө байдаг

*— Үүнтэй холбогдуулж өөр нэг асуулт аяндаа урган гарч байна. Хэвлэл бол «дөрөвдэх засаглал» гэсэн үзэл бодлыг сэтгүүлчид бид аль болохоор өөч дөөл, хөгжүүлэх сонирхолтой байдаг. Хэвлэлийн эрх чөлөөний талаарх өөрийн чинь бодолтой би нэрэлжил нэгтний хувьд, сэтгүүл зүйг судлаж сонирхлогийн хувьд санал нэг байна. Манай хэвлэл эрх чөлөөтэй болсон нь үнэн. Сэтгүүлчдийн энэ эрх чөлөө хэр баталгаатай юм бол. Би*

*өөрөө болохоо батална алга гэж хэлэх гээд байгаа хүн. Тийм учраас хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн эрхийн тухай хууль гаргах цаг болсон юм биш байгаа? Тэдний эрхийг хуулиар баталгаажуулж өгөх нь зүйтэй биш үү? Үүнийг юуны түрүүнд УИХ-д сууж буй сэтгүүлчид та нар болох ёстой бүй гээ.*

— Хууль хэрэгтэй. Хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулж, нийгмийн доторх тархүү харилцааг зохицуулсан хууль зайлшгүй шаардлагатай болно.

— *Цаг зав гаргаж манай сэтгүүлд ярилцлага өгсөн нутгийн дүүд баярлалаа.*

— Зүгээр. Үнэхээр цагт хавчигдаад олон зүйл ярьж амжсангүй. Үг нь хэлж ярих юм туи их байна санж.

x x x

Их Хурлын чуулганы завсарлагаар бидний ярилцсан зүйл энэ. Ийм тийм гэж үнэлэлт дүгнэлт өгөхөөс миний бие зайлсхийж байна. Энэ нь ерөөсөө ч сэтгүүлчийн үүрэг биш. Уханит мэргэн уншигч авгай нар өөрсдөө шүүн тунгаах буй заа. Цахиагийн Элбэгдорж бол пас залуу, цус шингэн нэгэн. Хараал, ерөөлийн аль алийг сонсож бяцхан томоожиж яваа ч байж болох юм. Тэгэхлээ л зоригтой, зүрхтэй хөвгүүн гадгийг хүлээн зөвшөөрөхгүй байхын аргагүй. Энэ бол залуу хүмүүст байдаг төрөлхийн сайхан чанар. Тэр тусмаа Ц. Элбэгдорж бол төр, засгийн удирдлагын жолоо барилцагч, түүний гэгээн өндөрлөг өөд зарч шуурч яваа залуу хүн гадгийг мартаж болохгүй. Буруутгах ч хэрэггүй. Маршал болохыг мөрөөдөлгүй цэргийг муухан эр гэдэг биз дээ? Жигүүртний ертөнцөөс алтан хараацайг ойрын зайнд хамгийн хурдан нисдэг цуцашгүй шувуу ч гэлцдэг.

Улаанбаатар, 1993 оны 1 дүгээр сарын 29

*Захидал задлахад*

# ИРГЭДИЙН ЭРЭЛТ, ХҮСЭЛТ

Монгол Улсын Их Хурал үйл ажиллагаагаа эхалсэн 1992 оны 7 дугаар сарын 20-ноос жилийн эцэс хүртэл 5 сар гаруйн хугацаанд 830 иргэд, байгууллага, хамт олноос 1213 санал, хүсэлт, гомдол, мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсний 90 гаруй хувь нь шинээр батлан гаргах хуулийн талаар болон одоо дагаж мөрдөж байгаа хуулийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэхтэй холбоотой санал, хүсэлт байв. Энэ хугацаанд Улсын Их Хурлын даргад 142, дэд даргад 23 иргэн санал, хүсэлт, өргөдөл ирүүлсэн байна. 1992 онд Хууль зүйн байнгын хороонд 60, Хүн ам зүй, нийгмийн бодлогын байнгын хороонд 35, Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороонд 5, бусад хороодод 20 гаруй захидал хүлээн авч шийдвэрлэжээ.

Улсын Их Хуралд ирсэн нийт захидлын 72,4 хувь нь нийслэлийн иргэд, байгууллагаас, 27,6 хувь нь аймаг, хотуудаас ирсний дотор Дорнод аймаг, Дархан хотоос тус бүр 19, Өмнөговь аймгаас 2 захидал иржээ. Улсын Их Хуралд захидал ирүүлсэн иргэдээс Нийслэлийн Ханын материалын комбинатын ажилтан Л. Зундуйхүү 10 удаа, Баянгол дүүргийн иргэн Г. Жагай 7 удаа захидал, мэдээлэл ирүүлсэн нь бусдаасаа хамгийн олон ажээ.

1993 оны 1 дүгээр сарын эхний 20 хоногт Улсын Их Хурал, түүний Тамгын газарт 70 гаруй иргэний бичгээр ирүүлсэн захидлыг хүлээн авч 40 гаруй хүн хүлээн авах байранд ирж санал хүсэлтээ илэрхийллээ.

Ирж байгаа санал хүсэлтийн олонхи нь ажлын хариуцлага, сахилгыг дээшлүүлэх, хяналт шаардлагыг өндөржүүлж, гэмт хэрэг, алдаа гаж буруу үйлдэл зөрчилтэй шийдвэртэй тэмцэх, өмч хөрөнгийг хайрлан хамгаалах, улс орны амьдрал, эдийн засгийн хүндрэлийн бэрхшээлийг даван туулах талаар тодорхой бодол санаа илэрхийлсэн байна.

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн Э. Рэгзэн, Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны Д. Баатар нарын зэрэг иргэд төрийн захиргааны байгууллагын орон тоог цомхотгож тодорхой ажиллуулах, бензин, шатахууныг арвин гамтай зарцуулах, үнийг нь хямдруулах талаар [illegible] үед, албан ажлын суудлын машин

хэрэглэгчдийн тоог цөөрүүлж хязгаарлах, яам, аймаг,.. хот засаг даргын тамгын газрыг тодорхой ажиллуулах арга хэмж авахуулахыг хүсэлт болгосон байна.

Улсын Их Хуралд ирж байгаа ард иргэдийн захидлаас үз хэл яамдын болон аймаг, хотын Засаг даргын Тамгын газру хууль тогтоомжийг суртадчлах, биелүүлэх ажлыг хангалттүй хион байгуулж байгааг шударгаар шүүмжилж энэ ажлыг сайжруулж хуулийг чанд мөрдөж биелүүлэхэд Улсын Их Хур онцгой анхаарал тавихыг хүсэлт болгож байна.

УИХ-ын Тамгын газрын захидал харилцааны х гийн ахлагч Ч. БАВ

---

**Сэтгүүлийн зөвлөл:**
Ерөнхий эрхлэгч **Н. Ринчиндорж**
Нарийн бичгийн дарга **Д. Алтангэрэл**
**Т. Баасансүрэн**
**Ч. Бавуу**

Техник редактор **С. Заяадамаа**
Хянагч **С. Итгэл**

Зах № 1

Үйлдвэрт шилжүүлсэн 1993 оны 1-р сарын 20-нд. Өрөлтөд 1993 оны 1-р сарын 21-нд. Хэвлэлтэд 1993 оны 2-р сарын 9-нд. Цаасны хэмжээ 60x84/16. Хэвлэлийн хуудас 9,5. Хэвлэсэн тоо 4000 ширхэг.

Засгийн газрын хэвлэх үйлдвэр